**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ**
**ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН**

# МОНГОЛ-ОРОСЫН ХАРИЛЦАА «ЗӨӨЛӨН ХҮЧ»-НИЙ БОДЛОГО

**ХАМТАРСАН ТӨСЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**
**2019-2022**

| | |
|---|---|
| **Төслийн хавсран гүйцэтгэгч:** | **ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвд судлалын хүрээлэн** |
| **Төслийн удирдагч:** | **А.Нямдолжин доктор /Ph.D/ Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан** |
| **Захиалагч байгууллага:** | **Боловсрол, шинжлэх ухааны яам** |
| **Санхүүжүүлэгч байгууллага:** | **Шинжлэх ухаан технологийн сан** |

**УЛААНБААТАР**
**2023**

ГАРЧИГ

Төслийн карт 3
Реферат 5
Судалгааны үр дүнгийн гүйцэтгэл: 6
Удирдтгал 6
Сэдвийн судалгааны тойм 7
Үр дүнгийн даалгавар: 8
Хавсралт 1. Бүтээлийн жагсаалт 12
Хавсралт 2. Эрдэм шинжилгээний өгүүллүүд 15
А.Нямдолжин. Монгол Улс, ОХУ-ын улс төрийн харилцаанд хийсэн дүн шинжилгээ 15
А.Нямдолжин. Монгол, Оросынын улс төрийн харилцаа: Монголын эдийн засаг ба төмөр замын хөгжилд нөлөөлөх нь 31
A.Nyamdoljin. Mongolia’s view on Sino-Russian Relations 47
В.А.Родионов, А.Нямдолжин. Политический образ Владимира Путина в Монголии 64
А.Нямдолжин. Уулын Карабахын мөргөлдөөн ба ОХУ 71
А.Нямдолжин.ОХУ-аас Монгол Улсын талаар баримталж буй бодлогын зарим шинэ хандлага: Оросын Монгол судлаачдын судалгааны үр дүнгээс. 77
А.Нямдолжин.Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ОХУ-ын гүйцэтгэх үүрэг 90
Н.Ариунгуа. Хүйтэн дайны дараах Монгол, Хятад, Оросын гурван талт харилцааны үе шат ба онцлог 96

## ТӨСЛИЙН КАРТ

| | |
|---|---|
| **Нууцын зэрэглэл:** | Б энгийн |
| **Төсөл гүйцэтгэх гэрээний дугаар** | Шу/ОХУ/-2019/21 |
| **Төслийн хавсран гүйцэтгэгч:** | ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвд судлалын хүрээлэн |
| **Төслийн удирдагч:** | А.Нямдолжин доктор /Ph.D/ Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан |
| **Захиалагч байгууллага:** | Боловсрол, шинжлэх ухааны яам |
| **Санхүүжүүлэгч байгууллага:** | Шинжлэх ухаан технологийн сан |
| **Төслийн гүйцэтгэгчийн нэр:** | ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн |
| **Төслийн тайлангийн бүрэн нэр**: | “Монгол-Оросын харилцаа. «Зөөлөн хүч»-ний бодлого” гадаадтай хамтарсан төсөл |
| **Тайлангийн төрөл:** | эцсийн тайлан |
| **Төслийг хэрэгжүүлсэн хугацаа:** | эхлэх 2019 он<br>дуусах 2022 он /3 жил |
| **Тайланг өмчлөгч байгууллага:** | ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн |
| **Сэдвийн гүйцэтгэгчийн шуудангийн хаяг:** | ШХ-187, Улаанбаатар-38, Монгол Улс 15141<br>ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн<br>Утас: 11-318691, 80092345<br>E-mail: nyamdoljin@mas.ac.mn |
| **Сэдэв гүйцэтгэсэн хот:** | Улаанбаатар |
| **Тайлан бичсэн он:** | 2023 он |

**Монголын талын төслийн гүйцэтгэгчид:**

| | |
|---|---|
| 1. А.Нямдолжин | төслийн удирдагч, доктор (Ph.D), Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан |
| 2. Д.Шүрхүү | доктор (Ph.D), Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан |
| 3. Н.Ариунгуа | доктор (Ph.D) Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан |
| 4. Ж.Орхон | магистр, Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дэд ажилтан |

**Оросын талын төслийн гүйцэтгэгчид:**

| | |
|---|---|
| 1. В.А.Родионов | Төслийн удирдагч, улс төрийн шинжлэх ухааны доктор, Доржи Банзаровын нэрэмжит Буриад улсын их сургуулийн Дорно Дахины сургуулийн захирал |
| 2. Л.В.Курас | Доктор, профессор, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвд судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан |
| 3. И.Г.Актамов | Доктор, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвд судлалын хүрээлэнгийн ази хэлний орчуулгын төвийн лабораторийн эрхлэгч |
| 4. И.Ц.Доржиева | Доктор, Доржи Банзаровын нэрэмжит Буриад улсын их сургуулийн улс төр, социологийн тэнхимийн доцент |
| 5. А.В. Комбаев | Доктор, Доржи Банзаровын нэрэмжит Буриад улсын их сургуулийн улс төр, социологийн тэнхимийн доцент |
| 6. Э.В.Цыремпилова | Доктор, Доржи Банзаровын нэрэмжит Буриад улсын их сургуулийн улс төр, социологийн тэнхимийн ахлах багш |

**РЕФЕРАТ**

Монгол-Оросын харилцаан дахь “зөөлөн хүч”-ний бодлогыг судлах үүднээс “Монгол-Оросын харилцаа. «Зөөлөн хүч»-ний бодлого” хамтарсан төслийг Монгол Улсын ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Түвд, Будда судлалын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид хамтран 2019-2022 онд гурван жилийн хугацаатай хэрэгжүүллээ. Хамтарсан төслийн ажлын үр дүнд төслийн гүйцэтгэгчид Монгол-Оросын харилцаан дахь “зөөлөн хүч”-ний бодлогыг орчин үеийн Оросын түүх бичлэгт хэрхэн туссан, Монгол дахь их гүрнүүдийн “зөөлөн хүч”-ний бодлого, Монгол дахь Оросын "зөөлөн хүч" -ийн нөөц боломж, хоёр орны харилцаа хамтын ажиллагаанд “зөөлөн хүч”-ний бодлого хэрэгжих нэг гол хэрэгсэл болох боловсролын салбар дахь харилцаа, хамтын ажиллагаа, аялал, жуулчлалын салбарын үүрэг роль, жижиг орны “зөөлөн хүч”-ний бодлого ба Монгол Улсын олон улсад нөлөөлөх боломж, Монгол Улсын “зөөлөн хүч”-ний бодлого хэрэгжүүлэх боломж, Монголын “зөөлөн хүч”-ний бодлого дахь Оросын хил залгаа бүс нутаг гэх мэт хоёр орны харилцаа хамтын ажиллагааг хоёр орны хооронд дипломат харилцаа тогтоосон цагаас эхлэн авч үзэж, өнөөгийн харилцаа ба харилцааны хэтийн төлөвийг Жозеф Найгийн дэвшүүлсэн “зөөлөн хүч”-ний бодлогын үзэл баримтлалын үүднээс иж бүрнээр судаллаа.

Хамтарсан төслийн хүрээнд хамтын бүтээл, өгүүллийн эмхэтгэл – 2, эрдэм шинжилгээний өгүүлэл 3, илтгэл 18-ийг дотоодын болон олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьж хэлэлцүүлсэн. “Мягкая сила в Российско-Монгольских отношениях” (Монгол-Оросын харилцаан дахь Зөөлөн хүчний бодлого) 11,27 хх. хамтын нэг сэдэвт бүтээл 2022 онд Эрхүү хотын “Оттиск” хэвлэлийн газарт хэвлэгдэв. Түүнчлэн тус хамтын бүтээлийг дараах линкээр онлайнаар унших боломжтой. http://www.mongolnow.com/wp-content/uploads/2022/09/Miagkay-sila-monograph.pdf “Зөөлөн хүчний бодлого: Монгол-Оросын харилцаа” монгол, орсын судлаачдын өгүүллийн эмхэтгэлийг 2022 онд Улаанбаатар хотноо “Бэмби” хэвлэлийн газарт хэвлүүлэв.

**Судалгааны үр дүнгийн гүйцэтгэл:**

Төслийн гэрээний үр дүнгийн даалгаварт хийхээр төлөвлөсөн ажлууд бүрэн биелэсэн.

| Төлөвлөсөн | | Биелэлт | |
|---|---|---|---|
| Хамтын бүтээл, өгүүллийн эмхэтгэл | 2 | Хамтын бүтээл, өгүүллийн эмхэтгэл | 2 |
| Эрдэм шинжилгээний өгүүлэл, | 3 | Дотоодод-12, Гадаадад-4 | 16 |
| Эрдэм шинжилгээний илтгэл | 3 | Дотоодод-7, Гадаадад-2 | 9 |

| | | | |
|---|---|---|---|
| Бодлогын зөвлөмж | 1 | | 1 |
| Нийт | 9 | | 28 |

**УДИРДТГАЛ**

**Зорилго:** Монгол, Оросын харилцаа, хамтын ажиллагаанд геополитик, аюулгүй байдал, улс төр, үзэл суртлын хүчин зүйлс маш хүчтэй нөлөө үзүүлсээр ирсэн бөгөөд Оросын зүгээс Монгол дахь улс төр, хувь хүний сэтгэлгээ, хэл, соёл, шинжлэх ухаан, урлаг, утга зохиол, боловсрол, дипломат хамтын ажиллагааны хөгжилд үзүүлсэн нөлөөг "зөөлөн хүч"-ний үзэл баримтлалын үүднээс хоёр орны харилцааны түүхэн уламжлалд тулгуурлан судлахыг зорьсон зорилгоо бүрэн биелүүлсэн.

**Шинэлэг тал, ач холбогдол:** Тус бүтээлийн шинэлэг тал нь Монгол-Оросын харилцааны уламжлал, өнөөгийн байдлыг "зөөлөн хүч"-ний бодлогын хүрээнд харилцаа, хамтын ажиллагааны эерэг туршлагыг иш үндэс болгон судалсанд оршиж байна. Монгол, Оросын харилцааны асуудлаар арвин их бүтээл хэвлэгдэн гарч, тус хүрээлэнгийн эрдэмтэн судлаачид хоёр орны түүх, улс төр, эдийн засаг, хүмүүнлэгийн салбар гээд бүх салбар чиглэлийн судалгааг хийж, суурь судалгааны төсөл болоод ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэн, ОХУ-ын ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвд судлалын хүрээлэн, Буриадын их сургуулийн эрдэм судлаачидтай хамтран 10 гаруй хамтарсан төсөл хэрэгжүүлж ирсэн туршлага дээрээ тулгуурлан Монгол, Оросын харилцааны асуудлыг "зөөлөн хүч"-ний бодлогын үүднээс судалсан явдал тус бүтээлийн үр дүнг улам ач холбогдолтой болгож байна.

Уг бүтээл нь түүхч, улс төр судлаач, олон улсын харилцааны ажилтан, багш, их, дээд сургуулийн оюутнууд болон Монгол-Оросын харилцааны түүхийг сонирхогч хэн бүхэнд зориулагдана.

Түүнчлэн нэг сэдэвт хамтын бүтээл хэлбэрээр хэвлэгдэн гарсан бөгөөд түүний цахим хувилбарыг интернетэд байршуулсан нь хэдийн олны хүртээл болоод байна.

**Санжүүжилт**: 27,000,0 сая төгрөгийн санхүүжилтээс нийт 24,480,0 сая төгрөгийн санхүүжилт авсан.

## СЭДВИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ

“Монгол-Оросын харилцаа. «Зөөлөн хүч»-ний бодлого” гадаадтай хамтарсан төслийн ажлын хүрээнд Монгол, Орос хоёр орон дипломат харилцаа тогтоосноос хойш 100 жилийн түүхийн энэхүү урт хугацаанд тогтсон онцгой харилцаа, харилцан ойлголцол, итгэлцэлийг “зөөлөн хүч””-ний онолын үзэл баримтлалын үүднээс судласнаараа онцлог юм. Социализмын замаар замнасан 70 жилийн найрсаг харилцаатай байх хугацаанд Монгол улс ЗХУ-ын тусламж дэмжлэгийн үр дүнд ядуу буурай, хоцронгуй улсын түвшнээс XX зууны хөгжиж буй улс орны нэг болж хувирсан. Энэ үед Монголын нийгэм эдийн засаг хурдацтай хөгжиж, улс төр, хувь хүний сэтгэлгээ, хэл, соёл, шинжлэх ухаан, урлаг, утга зохиол, боловсрол, дипломат хамтын ажиллагааны хөгжилд ЗХУ-ын зүгээс үзүүлсэн нөлөө хүчтэй түлхэц болсон. Энэхүү бат бэх хөрс суурийг бататган, уламжлал, шинэчлэлийг хослуулан, олон талт харилцан ашигтай хамтын ажиллагааг “зөөлөн хүч”-ний бодлогын хүрээнд харилцаа хамтын ажиллагааны эерэг туршлагыг хадгалж, тэдгээрийг цаашид хөгжүүлэн, орчин үеийн дэлхийн бодит нөхцөлд тохирсон шинэ агуулгаар баяжуулах шаардлагыг судлан харуулахаар зорьсон. Төслийн гүйцэтгэгчид өгүүлэн буй сэдвийн чиглэлээр дагнан судалгаа хийдэг, хуримтлуулсан мэдлэг, судалгааны ажлын туршлагатай, онол-арга зүй, мэдлэг, мэдээллийн бааз суурьтай судлаачид хамтын төсөлд оролцсон нь судалгааны ажлыг үр дүнтэй, чанартай гүйцэтгэх үндсэн нөхцлийг бүрдүүлсэн болно.

Төслийн Монгол болон Оросын талын гүйцэтгэгч судлаачид судалгааны бүтээл, ном сэтгүүл, дотоод гадаадын хэвлэмэл болон цахим мэдээллийн эх сурвалжууд, албан ёсны статистикийн дүн мэдээнүүдэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр судлаач бүр өөр өөрийн үнэлэлт дүгнэлтийг хийх замаар “Монгол- Оросын харилцаан дахь «зөөлөн хүч»-ний бодлого” хамтын бүтээл, “Монгол-Оросын харилцаа: Зөөлөн хүчний бодлого” хамтын өгүүллийн эмхэтгэлийг хэвлүүлэн олны хүртээл болгоод байна. Төслийн ажлын хүрээнд төслийн гүйцэтгэгчид олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцон илтгэл тавьж хэлэлцүүлсний зэрэгцээ өөрсдийн ном бүтээл, эрдэм шинжилгээний өгүүллүүдийг хэвлүүлэн гаргасан байна.

**ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР**:

***"Дугуй ширээний уулзалт. 2019.11 сар***

Монгол, Оросын талын оролцогчдын хамтарсан дугуй ширээний уулзалтыг 2019 оны 11-р сард Улаанбаатар хотноо зохион байгуулж, Оросын талын удирдагч В.А.Родионов тэргүүтэй 4 оролцогч ирж оролцов. Тус дугуй ширээний уулзалтаар "Орос дахь Монголын "зөөлөн хүч"- бодлого" шинжээчийн түвшиний социологийн судалгаа явуулахаар тохирч, тус судалгаа орох асуултуудыг нэг бүрчлэн хэлэлцэн ярилцсан үр дүнтэй уулзалт болов.



***"Орос дахь Монголын "зөөлөн хүч"-ний бодлого" шинжээчийн түвшиний социологийн судалгаа. 2020.03.01-05.01***

"Орос дахь Монголын "зөөлөн хүч"- бодлого" шинжээчийн түвшиний социологийн судалгаа явуулж, 50 шинжээчээс 45 асуулт бүхий судалгаа авч, оросын талд онлайнаар хүргүүлэв. Энэхүү судалгааны үр дүн "Монгол-Оросын харилцаа. Зөөлөн хүчний бодлого" өгүүллийн эмхэтгэлд хэвлэгдсэн.

***Бодлогын зөвлөмж. 2021.01 сар***

Монгол судлаач Оросын эрдэмтдийн судалгааны үр дүнг судлан, тэр судалгаа нь ОХУ-ын зүгээс Монголын талаар баримталж буй бодлогод хэрхэн нөлөөлж байгаа болон сүүлийн үеийн шинэ хандлагыг судлаж, судалгааны үр дүнг зөвлөмж хэлбэрээр ҮАБЗ-д 2021 оны 1-р сард хүргүүлсэн. Зөвлөмжийг эрдэм шинжилгээний өгүүлэл болгон "Олон улс судлал-2021" эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлүүлсэн.

***Эрдэм шинжилгээний өгүүллүүдийн орчуулга. 2021***

“Монгол-Оросын харицаа. Зөөлөн хүчний бодлого” өгүүллийн эмхэтгэлд орох оросын талын оролцогчдын өгүүлэл болон зөвлөмж бичихтэй холбоотой материалуудыг орос хэлнээс монгол хэл рүү орчуулав. Тус орчуулсан оросын талын эрдэмтдийн өгүүллүүд “Зөлөн хүчний бодлого: Монгол-Оросын харилцаа” өгүүллийн эмхэтгэлд 2022 онд хэвлэгдэв.

***Оросын талтай төслийн явцыг уулзалт. 2021.09.05. Улаан-Үүд хот***

Оросын талын төслийн удирдагч В.А.Родионов тэргүүтэй төслийн оролцогчидтой уулзан хийсэн ажлуудаа дүгнэн, хамтын бүтээлийн агуулга, бүтэц, бүлгийн талаар уулзалт хийв.

***“Мягкая сила: в Российско-Монгольских отношений” нэг сэдэвт хамтын бүтээл. 2022. 07. Улаан-Үүд хот***

“Монгол-Оросын харилцаан дахь Зөөлөн хүчний бодлого” хамтын бүтээлийн бичилтийг дуусган Оросын талд хүлээлгэж өгснөөр хамтын бүтээлийг Эрхүү хотноо орос хэл дээр хэвлүүлэв.




УДК 327.82
ББК 66.4(2Рос)
М99

Работа выполнена в рамках гранта Российского фонда фундаментальных исследований-Министерства образования и науки Монголии (проект «"Мягкая сила" в российско-монгольских отношениях: сравнительный анализ», № 19–514–44001 Монг_т)

Ответственные редакторы:
*д.полит.н., доц.* ***В.А. Родионов***
*к.и.н.* ***А. Нямдолжин***

Рецензенты:
*д.и.н., проф.* ***Ц.П. Ванчикова***
*д.и.н., проф.* ***Ю.В. Кузьмин***
*д.и.н., проф.* ***В.Д. Дугаров***

М99 **«Мягкая сила» в российско-монгольских отношениях**: [коллективная монография] / Отв. ред. В.А. Родионов, А. Нямдолжин; Федеральное государственное бюджетное учреждение науки Институт монголоведения, буддологии и тибетологии Сибирского отделения Российской академии наук. – Иркутск: Изд-во «Оттиск», 2022. – 196 с.

**ISBN 978-5-6047699-8-0**

В книге описываются основные сюжетные линии, связанные с использованием «мягкой силы» в отношениях России и Монголии. С одной стороны, проанализированы различные аспекты политики «мягкой силы» России в отношении Монголии, выявлены ее основные ресурсные составляющие, сильные и слабые стороны. С другой стороны, впервые в российской науке описаны ключевые элементы «мягкой силы» Монголии, применяемой в том числе в отношении России, ее отдельных регионов.

Монография может быть интересной для специалистов и широкого круга читателей – востоковедов, историков, политологов, социологов, а также всех, кто интересуется современными международными отношениями.

© Коллектив авторов, 2022

http://www.mongolnow.com/wp-content/uploads/2022/09/Miagkay-sila-monograph.pdf

***"XXI зууны Монгол Улс ба Орос Улс" сэдэвт эрдэм шинжилгээний хурал. 2022.10.14***

“XXI зууны Монгол Улс ба Орос Улс” сэдэвт эрдэм шинжилгээний хурал 2022 оны 10 сарын 14-ний өдөр Олон улс судлалын хүрээлэнгийн хурлын танхимд зохион байгуулав. Уг хурал нь БШУЯ-ны ШУТС, ОХУ-ын ШУТС-ийн дэмжлэгээр хэрэгжиж буй “Монгол-Оросын харилцаа. “Зөөлөн хүч”-ний бодлого” сэдэвт хамтарсан төслийн хүрээнд зохиогдсон болно. Хуралд хамтарсан төслийн Оросын талын удирдагч ОХУ-ын Буриадын их сургуулийн Дорно дахины хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D) В.А. Родионов хүрэлцэн ирж “Мягкая сила” малых стран: опыт Монголии” сэдвээр илтгэл тавив. Олон улс судлалын хүрээлэнгийн Монголын талын төслийн удирдагч, Орос судлалын салбарын эрхлэгч, доктор (Ph.D) А.Нямдолжин “Зөөлөн хүч”-ний бодлого: Монгол - Оросын харилцааны жишээн дээр”; ЭШАА, доктор (Ph.D) Д.Шүрхүү “Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор ба “зөөлөн хүч”-ний бодлогын нөлөө”; ЭШАА, доктор (Ph.D) Н.Ариунгуа “Монгол ба “зөөлөн хүчний бодлого” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлэв. Тус хуралд Монгол улсын Гадаад харилцааны яамны Хөрш орнуудын газрын мэргэжилтнүүд болон Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Стратегийн судалгааны хүрээлэнгийн шинжээчид, Аюулгүй байдал судлалын хүрээлэн болон Олон улс судлалын хүрээлэнгийн судлаачид оролцон хэлэлцүүлэг өрнүүллээ. Хурлын үйл ажиллагааны үеэр ОХУ-ын Буриадын их сургуулийн Дорно дахины хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D) В.А. Родионовт Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны яамнаас олгосон Шинжлэх ухааны тэргүүний ажилтан цол тэмдгийг гардуулав.



**“XXI ЗУУНЫ МОНГОЛ УЛС БА ОРОС УЛС”**
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН**
**ХӨТӨЛБӨР**

**Хэзээ:** 2022 оны 10 дугаар сарын 14-ны өдөр, Улаанбаатар, Монгол Улс

**Хаана:** ШУА-ийн хүрээлэнгүүдийн нэгдсэн II дугаар байр, 4-р давхар, Хурлын танхим

**Зохион байгуулагч:** ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн

**НЭЭЛТ**

10:00-10:10

Д.Золбоо - ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор (Ph.D)

О.Батсайхан - “Путины засаглалын үеийн ОХУ-ын гадаад бодлого ба түүний Монгол улс дахь тусгал” сэдэвт суурь судалгааны төслийн удирдагч, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн профессор, түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)

**ИЛТГЭЛҮҮД**

10:10-10:30 **Монгол-Оросын харилцааны өнгөрсөн 30 жилд хийх дүгнэлт, ойрын ирээдүйн прогноз**
*К.Дэмбэрэл , ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)*

10:30-10:50 **“Мягкая сила” малых стран: опыт Монголии**
*Родионов Владимир Александрович, ОХУ-ын Буриадын их сургуулийн Дорнодахины хүрээлэнгийн захирал, доктор (Sc.D)*

10:50-11:10 **“Зөөлөн хүч”-ний бодлого: Монгол - Оросын харилцааны жишээн дээр**
*А.Нямдолжин, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрхлэгч, доктор (Ph.D)*

11:10-11:30 **Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор ба “зөөлөн хүч”-ний бодлогын нөлөө**
*Д.Шүрхүү, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)*

11:30-11:50 **Монгол ба “зөөлөн хүчний бодлого**
*Н.Ариунгуа, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)*

11:50-12:10 **ЦАЙНЫ ЦАГ**

12:10-12:30 **Российская гуманитарная политика за рубежом: концепты и реальность**
*Бадмацыренов Тимур Баторович, Доржи Банзаровын нэрэмжит ОХУ-ын Буриадын их сургуулийн улс төр, социологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Sc.D), доцент*

12:30-12:50 **Ази-Номхон далайд чиглэсэн ОХУ-ын бодлого дахь Монгол Улс**
*Б.Хишигжаргал, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын Эрдэм шинжилгээний ажилтан, магистр*

12:50-13:00 **ОХУ-ын гадаад бодлогын үзэл баримтлалын өөрчлөлтүүд: 2000 ба 2008**
*Х.Мандухай, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын Эрдэм шинжилгээний ажилтан, докторант*

13:00-13:30 **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**
13:30-13:35 **ХУРЛЫН ХААЛТ**
13:35-14:20 **ҮДИЙН ХООЛ**

**“Зөөлөн хүчний бодлого: Монгол-Оросын харилцаа” Монгол, Оросын эрдэмтдийн хамтарсан өгүүллийн эмхэтгэл. УБ. 2022**

“Монгол-Оросын харилцаа: Зөөлөн хүчний бодлого” хамтын өгүүллийн эмхэтгэлийг хэвлэлд бэлтгэн эмхэтгэн монгол хэл дээр 2022 онд Улаанбаатар хотноо хэвлүүлэв.




Тайлан бичсэн:

А.Нямдолжин Төслийн удирдагч
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн
ЭШТА, доктор /Ph.D/

**Хавсралт 1**

# “МОНГОЛ-ОРОСЫН ХАРИЛЦАА. “ЗӨӨЛӨН ХҮЧ”-НИЙ БОДЛОГО” СЭДЭВТ ТӨСЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ /2019-2022/

## НЭГ. НОМ, ХАМТЫН БҮТЭЭЛ

***Хамтын бүтээл:***

1. Мягкая сила в Российско-Монгольских отношениях. Улан-Удэ. 2022. 196 с.

***Өгүүллийн эмхэтгэл***:

1. Монгол-Оросын харилцаа: Зөөлөн хүчний бодлого. УБ. 2022. 110 с.

## ХОЁР. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ:

1. **А.Нямдолжин.** Монгол Улс, ОХУ-ын улс төрийн харилцаанд хийсэн дүн шинжилгээ. Монгол Улсын гадаад бодлогын зангилаа асуудлууд. хамтын бүтээл. УБ. 2020, 253-281-р тал.
2. **А.Нямдолжин.** Монгол-Оросын улс төрийн харилцаа: Монголын эдийн засаг ба төмөр замын хөгжилд нөлөөлөх нь. Олон улс судлал сэтгүүл. 2020. №1, 21-40-р тал. DOI: https://doi.org/10.5564/10.5564/jis.v1i110.1340
3. **А.Нямдолжин.** Монгол-Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойд зориулан гаргасан “Монгол ба Оросын харилцаа: он дараалын товчоон. 1911-2021”-ны 2001-2010 оны хооронд дахь он дарааллын бичиг. УБ. 2021. 531-572-р тал.
4. **A.Nyamdoljin.** Mongolia’s view on Sino-Russian relations. MONGOLIAN STUDIES. Volume Thirty Nine for 2017-2018. P. 81-96 (2021 оны 3-р сард хэвлэгдсэн.)
5. **В.А.Родионов, А.Нямдолжин.** Политический образ Владимира Путина в Монголии. Власть. Общенациональный журнал. 29 № 1 (2021), Стр.30-36. https://doi.org/10.31171/vlast.v29i1.7862
6. **А.Нямдолжин.** Уулын Карабахын мөргөлдөөн ба ОХУ. МУИС, ОУХНУС-иас эрхлэн гаргадаг “Бодлогын мэдээ”. №17. 2020.12. 5-9-р тал
7. **А.Нямдолжин**.ОХУ-аас Монгол Улсын талаар баримталж буй бодлогын зарим шинэ хандлага: Оросын Монгол судлаачдын судалгааны үр дүнгээс. Олон улс судлал-2021: Монголын Орос судлал. Хурлын эмхэтгэл. УБ. 2022. 31-41-р тал.
8. **А.Нямдолжин.** Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ОХУ-ын гүйцэтгэх үүрэг. Олон улс судлал-2021: Монголын Орос судлал. Хурлын эмхэтгэл. УБ. 2022. 143-149-р тал.

9. **А.Нямдолжин.** “Мягкая сила” великих держав в Монголии: ретроспективный обзор. Мягкая сила в Российско-Монгольских отношениях. Улан-Удэ. 2022. Стр. 46-61.
10. **Н.Ариунгуа**. Монголия и политика “мягкой силы”: исторические аспекты. Мягкая сила в Российско-Монгольских отношениях. Улан-Удэ. 2022. Стр. 30-46.
11. **А.Нямдолжин.** Монголия между Центральной и Севере-Восточной Азией. Мир Центральной Азии -V. Новосибирск, СОРАН. 2022. Стр. 640-642 DOI: 10.53954/9785604788981_640
12. **Н.Ариунгуа.** Хүйтэн дайны дараах Монгол, Хятад, Оросын гурван талт харилцааны үе шат ба онцлог. Олон улс судлал сэтгүүл. 2019. №1,40-63-р тал. DOI: https://doi.org/10.5564/jis.v0i1.1253
13. **Д.Туул**. Хөгжиж буй орнуудын дижитал эдийн засгийн хөгжилд тулгарч буй бэрхшээл: ОХУ-ын жишээн дээр. Олон улс судлал сэтгүүл. 2020. №2, 84-100-р тал. DOI: https://doi.org/10.5564/jis.v2i111.1447
14. **Д.Туул**. ОХУ-ын Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад нөлөөлсөн хүчин зүйлс, Үндсэн хуульд тусгалаа олсон байдал. Олон улс судлал сэтгүүл. 2021. №112,80-94-р тал. DOI: https://doi.org/10.5564/jis.v44i112.1589
15. **Д.Туул.** Монгол-Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойд зориулан гаргасан “Монгол ба Оросын харилцаа: он дараалсан товчоон. 1911-2021”-ны 2011-2021 оны хооронд дахь он дараалсан бичиг. УБ. 2021. 572-639-р тал.
16. **Ж.Орхон.** Монгол-Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойд зориулан гаргасан “Монгол ба Оросын харилцаа: он дараалсан товчоон. 1911-2021”-ны 2011-2021 оны хооронд дахь он дараалсан бичиг. УБ. 2021. 491-531-р тал.

## ГУРАВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ИЛТГЭЛ:

1. **А.Нямдолжин.** Дорнын эдийн засгийн VI форумын хүрээнд зохион байгуулагдсан Монгол-Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойд зориулсан “Орос, Монголын харилцааны түүхэн ба орчин үеийн чиг хандлага: 100 жил” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд “Стратегическое партнерство между Монголией и Россией. Состояние и перспективы“ (Монгол, Оросын стратегийн иж бүрэн түншлэл: өнөөгийн байдал, хэтийн төлөв) сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. ОХУ. Владивосток хот. 2021.09.02.
2. **А.Нямдолжин**. Монголын Олон улс судлалын Алтан аргамж холбооноос зохион байгуулсан “Цар тахал, Өрнөдийн хоригийн нөхцөл дэх Орос-Хятадын харилцаа” сэдэвт олон улсын панел хэлэлцүүлэгт “Орос, Хятадын харилцааны ойртол ба Америкийн хүчин зүйл” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. 2021.06.04

3. **А.Нямдолжин.** Эрдэмтдийн их семинарт “Орос-Хятадын ойртолт ба Монголын нутгаар дамжуулах хийн хоолойн асуудал” сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. ОУСХ. 2021.10.28.
4. **А.Нямдолжин.** Монгол-Оросын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойд зориулсан “Монгол-Оросын харилцаа: түүх, орчин үе ба хэтийн төлөв” сэдэвт эрдэм шинжилгээний хуралд "Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ОХУ-ын гүйцэтгэх үүрэг" сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлэв. ГХЯ. 2021.11.02.
5. **А.Нямдолжин.** ОХУ (ЗХУ)-д сургуульд төгсөгчдийн МАВСУЗ холбоо болон Эрхүү мужийн Ректоруудын зөвлөлтэй хамтран “Монгол Улс ба Эрхүү мужийн боловсролын салбарын хэтийн байдал” сэдэвт дугуй ширээний уулзалтанд “Сотрудничество Монголии и России в области образования как инструмент «мягкой силы» сэдвээр үндсэн илтгэл тавьж хэлэлцүүлэв. МАВСУЗ. 11-р сарын 26.
6. **A.Nyamdoljin.** Mongolia-Russia relations after the crisis in Ukraine. The 11th East Asian Conference on Slavic Eurasian Studies. Shanghai. 12.10-11. 2022
7. **А.Нямдолжин.** “Зөөлөн хүч”-ний бодлого: Монгол-Оросын харилцааны жишээн дээр. “XXI зууны Монгол Улс ба Орос Улс” сэдэвт эрдэм шинжилгээний хурал. 2022.10.14. ОУСХ.
8. **Д.Шүрхүү.** Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор ба “зөөлөн хүч”-ний бодлогын нөлөө. “XXI зууны Монгол Улс ба Орос Улс” сэдэвт эрдэм шинжилгээний хурал. 2022.10.14. ОУСХ.
9. **Н.Ариунгуа.** Монгол ба “Зөөлөн хүч”-ний бодлого. “XXI зууны Монгол Улс ба Орос Улс” сэдэвт эрдэм шинжилгээний хурал. 2022.10.14. ОУСХ.

**Хавсралт 2. Эрдэм шинжилгээний өгүүллүүд**

**А.НЯМДОЛЖИН**

# МОНГОЛ УЛС, ОХУ-ЫН УЛС ТӨРИЙН ХАРИЛЦААНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хураангуй:** Монгол-Оросын орчин цагийн улс төрийн харилцааг дэлхийн улс төрийн байдалд гарсан огцом өөрчлөлт болон ЗХУ задарсан XX зууны 90-ээд оны эхэн үеэс эхлэн судалж, ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед Монгол-Оросын харилцааг бүхэлд нь эрх тэгш, харилцан ашигтай байх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчимд тулгуурлан өөрчлөн хөгжүүлэх эрх зүйн үндэс шинэчлэгдсэнийг хоёр орны хооронд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрийг үндэслэн судлан шинжиллээ. 90-ээд онуудад Монгол-Оросын харилцаа сулран саарсан асуудлыг хоёр орны улс төр, эдийн засгийн байдал, гадаад бодлогод холбогдох үйл явц, өөрчлөлтийг үе шаттайгаар задлан үзэж, харилцааг зохих түвшинд хөгжүүлэхэд саад болсон хүчин зүйлүүдийг илрүүлэн судалсан болно. Монгол-Оросын харилцаа сэргэсэн үеийг 2000 оноор зааглан авч үзэж, эдүгээ иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрээд байгаа хоёр орны харилцаа, тус түвшнийг илэрхийлэх хэмжээнд хүрэхгүй байгааг ОХУ-ын Монгол Улсын талаарх баримталж ирсэн бодлого хэр оновчтой байсан ба алдаа нь юунд байсныг судлан, тавь, тавин хувийн эзэмшилтэй “Улаанбаатар төмөр зам” хамтарсан нийгмлэг нь Монгол Улс дахь Оросын геоэдийн засгийн ашиг сонирхол болохын хувьд эрх зүйн орчныг шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгааг Монгол Улсын эрдэс баялгийн салбар эрчимтэй хөгжиж, томоохон ордуудыг шинээр нээж илрүүлснээр эдгээр орд газруудын эрдэс баялгийг зөөх, тээвэрлэхэд төмөр замын сүлжээ байгуулах, шинэчлэх явдал төмөр замын эдийн засгийн нэвтрүүлэх чадварт нөлөөлөх чухал хүчин зүйл гэдэг үүднээс дэлгэрэнүй судаллаа.

**Түлхүүр үгс:** ЗСБНХУ, БНМАУ, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэг, Монгол, Орос, БНМАУ-ын өр, Халхын гол, “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээ”, “Эрдэнэт” уулын баяжуулах үйлдвэр гэх мэт.

* * *

Монгол, Орос хоёр орныг олон зуун жилийн турш холбож ирсэн хамтын хил, түүх, улс төр, худалдаа, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн болон хувь хүмүүсийн хэлхээ холбоо, социализмын замаар замнасан XX зууны 70 жилийн хугацаанд тогтсон түүхэн хувь заяаны эерэг болон сөрөг туршлага, зах зээлийн эдийн засаг, ардчилал руу зэрэг дэвшиж, харилцаа, хамтын ажиллагаагаа шинэ нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх нийтлэг хүсэл эрмэлзэл, үндэсний язгуур ашиг сонирхол холбож байдаг. Үүнийг харгалзан үзвээс хоёр орны улс төрийн харилцааг судлан шинжлэх явдал Монгол Улсын гадаад бодлогын судалгаанд чухал ач холбогдолтой юм.

Монгол-Оросын орчин цагийн улс төрийн харилцааны эхлэл 1990-ээд оны эхээр тавигдсан гэж үзэж болно. Энэ үед дэлхийн дэг журам өөрчлөгдөн, шинэ зарчим дээр тулгуурлан геостратеги, геоэконом гэсэн энх тайванч стратеги, тактик руу чиглэх болсноор Монгол Улс болон ЗХУ-ын өвийг залгамжилсан ОХУ-ын хоорондын харилцаанд ч шинэ үе эхэлсэн юм.

Хоёр орон хоёулаа ардчилал, зах зээлийн эдийн засгийн талаарх Өрнөдийн ойлголт, үзэл баримтлал, улс төрийн олон ургальч үзлийг ямар ч эргэлзээгүйгээр баримтлах боллоо. Энэхүү өөрчлөлт, шинэчлэл нь тус хоёр орон бие биеэ шинээр ойлгох болж, эрх тэгш, харилцан ашигтай, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчимд тулгуурлан, геополитикийн үнэлэмж, бий болсон нөхцөлөөр тодорхойлогддог улс төрийн уламжлалт чиг шугамд тулгуурлан хоёр улсын харилцааг чанарын шинэ түвшинд гаргахад оршиж байв.

Монгол Улс ОХУ-тай харилцаагаа шинэчлэх анхны алхмаа 1993 оны нэгдүгээр сарын 19-22-нд Монгол Улсын ерөнхийлөгч П.Очирбатын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалаар хийжээ. Айлчлалын өмнөх жил 1992 оны есдүгээр сард Монгол дахь Зөвлөлтийн цэрэг гарч дууссан, хоёр орны улс төр, эдийн засгийн харилцаа бараг бүрэн зогссон байв. Айлчлалын үеэр “Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ” байгуулснаар монгол, оросын ард түмний зарчмын цоо шинэ харилцааны үндсийг тавьсан юм. Шинэ харилцааг өмнөх шигээ үзэл сурталжсан, нэгнээсээ хараат байдалд оршдог “ах, дүүгийн” ивээлийн ёсоор бус олон улсын харилцааны түгээмэл зарчимд үндэслэн, эрх тэгш, бүрэн эрхт, тусгаар тогтносон байдлыг хүндэтгэх, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан хөгжүүлэхээр тохирчээ. Уг гэрээнд гарын үсэг зурахтай зэрэгцэн Оросын талын шахалтаар хоёр орны Ерөнхийлөгч нар хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурсан. Түүнд “хуучин ЗСБНХУ, БНМАУ-д 30-40-өөд онд гэм буруугүй олон хүний амь насыг бүрэлгэн, хоёр орны ард түмэнд сэтгэл санааны болон эд материалын асар их хохирол учруулж, үй олноор нь хоморголон хэлмэгдүүлж байсанд хоёр улсын Ерөнхийлөгч нар гүнээ харамсаж байна... Үүний улмаас Монголын ард түмэн туйлын хүнд хохирол үзсэн бөгөөд ялангуяа сэхээтний давхарга онцгой зүдгүүр эдэлж, санваартан нар нийгмийн нэг хэсгийнхээ хувьд хэрэг дээрээ устгагджээ. Монгол Улсын олон иргэн ЗСБНХУ-д хэлмэгдэн цаазлагдсан юм. Үүний хариуцлага өнөөгийн ОХУ-д холбогдолгүй юм” гэсэн байв. Энэхүү мэдэгдэл Монголын хувьд ашиггүй байсан юм. Учир нь ОХУ хэлмэгдүүллийн хохирлыг барагдуулах буюу нөхөн төлбөр хийлгэх гэсэн Монголын талын бүхий л шаардлагаас зайлсхийх боломжтой болж байхад нөгөө талд нь нэхэмжлэгчийн хувьд ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч ОХУ-д шилжин ирсэн БНМАУ-ын өр Монгол Улсад хэвээр үлдсэн явдал юм. Тус гэрээг хорин жилийн хугацаатай, мөн тухай бүрт нь тав таван жилээр сунгах боломжтой байгуулсан. Харин 1994 оны Монгол Улс, БНХАУ-ын хоорондын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг хугацаагүйгээр байгуулсан байдаг. Хэдий тийм боловч ЗХУ задарсны дараа ОХУ бусад хил залгаа орнуудтай бүгдтэй нь ийм төрлийн гэрээ байгуулаагүй байсан бөгөөд ямартаа ч хоёр орны олон улсын харилцааны нийтлэг ёс зүйг шингээсэн шинэ зарчмуудыг төлөвшүүлэх хамтын чин эрмэлзэл шингэсэн гэрээ байсан хэмээн дүгнэх бүрэн боломжтой юм.

Монгол Улс болон ОХУ-ын эдийн засгийн харилцаа зогсонги байдалд орсон хэвээр байсан төдийгүй 1993 оноос хоёр орны иргэд харилцан виз авч зорьчдог болсон, Монголын уламжлалт бүтээгдэхүүнийг Оросын зах зээлд гаргахад олон төрлийн хязгаарлалттай, Оросын талын идэвхи чармайлт сул байв.

Иймээс Монгол, Оросын харилцаа сулран саарсан үеийг 90-ээд оны эхэн үеэс 2000 оноор зааглан авч үзэх нь зүйтэй. Монгол-Оросын харилцааг зохих түвшинд хөгжүүлэхэд саад болсон хүчин зүйлүүд гэвэл: ОХУ шилжилтийн үед олон талын хүндрэл бэрхшээлтэй тулгарч, гадаад харилцаандаа Өрнөдийг түшиглэсэн чиг бодлогыг явуулан, дотооддоо эдийн засгийн хүчтэй хямралд нэрвэгдэж, улс төрийн хүрээнд нөлөө бүхий хэсэг бүлгийн сонирхлын үндсэн дээр засгийн эрхийн төлөө тэмцэл хурцдаж, санхүү, үйлдвэр худалдааны олигархийн эрх мэдэл хүчтэй болж, зохион байгуулалттай гэмт хэрэг газар авсан байна. Оросын улс төрийн байдал нэн тогтворгүй байсныг тус улсын засгийн газар энэ үед таван удаа солигдсон явдал харуулж байна. ОХУ гадаад бодлогын шинэчлэлээ хэрэгжүүлэхдээ гол төлөв Европ, Азийн их гүрнүүдэд хандаж, хил залгаа бага улс орнуудыг үл тоосон байдалтай байв. Тухайлбал, ОХУ-ын бусад улс орнуудад хийж байсан дээд хэмжээний айлчлалууд нь АНУ, Англи, Франц, Герман, БНХАУ, Япон, Солонгос гэх мэт өндөр хөгжилтэй орнууд руу чиглэж байв. Монгол-Оросын хооронд дээд хэмжээний айлчлалын урсгал Монголын талаас голлож нэг чиглэлтэй байлаа. Тухайлбал, ОХУ-ын ГХЯ-ны сайд Е.Примаков 1996 онд Монгол Улсад айлчилснаас өөрөөр Ерөнхийлөгч Б.Ельцин, Ерөнхий сайд В.Черномырдин нар Монголд айлчлах айлчлалаа хэрэгжүүлээгүй билээ. 1990 оноос хойш арваад жил Оросын удирдлагын Монголтой хүйтэн хөндий харьцаж ирсэн нэг шалтгаан бол социализмын өнгөрсөн түүхтэй холбоотой бүхнээс зайлсхийхийг эрмэлзэж байсантай холбоотой. Түүнчлэн 1990 онд Монгол Улсад явагдсан анхны чөлөөт ардчилсан сонгуулиар (үзэл суртлаас ангид, шинэчлэгдэн өөрчлөгдсөн) МАХН ялалт байгуулан засгийн эрхийг барих болсон нь мөн нөлөөлсөн.

Монгол Улсын хувьд ЗХУ-ыг даган дууриасан улс төр, үзэл суртлын хамаарлаас ангижирч, улс төрийн талаар бие даан шийдвэр гаргах болсон ба өөр бусад хүчин зүйлс тухайлбал, ид хүчээ аваад байсан үндсэрхэг үзэл, оросуудын эсрэг уур амьсгал ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэн эхний жилүүдэд хүчтэй мэдрэгдэж байлаа. Ялангуяа Монголын аж үйлдвэрүүд дэх Зөвлөлтийн техник, технологийн давамгайлал хэн бүхний нүдэнд ил байсаар атал монголчууд үндсэрхэх үзлээ оросуудад илэрхийлж байсан үед Монголын Засгийн газраас Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг эргүүлэн татахыг шаардан, түүнийгээ хэрэгжүүлэн алдаа гаргаж байв. Түүнчлэн Монголын зүгээс ЗХУ-ыг залгамжилсан гэдэг үүднээс ОХУ-тай харилцах харилцаанд идэвхгүй хандаж байсан тал ажиглагддаг. Энэхүү байдал нь олон арван жилийн туршид бүрэлдэн тогтсон хамтын ажиллагааны харилцан ашигтай олон чиглэл, хэлбэрийг алдагдуулахад хүргэж, Орос улстай урьдын харилцаагаа сулруулах нэг хүчин зүйл болсон юм. Ийнхүү Монгол, Оросын харилцаа 90-ээд оны эхээр асар хумигдан, зарим харилцааг сэргээх бус бүр шинээр байгуулах хүртлээ буурсан юм.

90-ээд оны хоёрдугаар хагаст Монгол-Оросын хамтын ажиллагааг өмнөх үеийн уналтын түвшинээс бага зэргийн хэлбэлзэлтэй тогтонги байдалд орсон гэж үзэж болохоор байлаа. 1994 оны 11-р сард Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид ОХУ-д айлчлах үеэр Монгол Улсын Их хурал, ОХУ-ын Төрийн Думын хооронд хамтран ажиллах тухай санамж бичиг болон хоёр талын Парламентын бүлгүүдийн хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурсан нь хоёр улсын хууль тогтоох байгууллага-парламент хоорондын

харилцааны суурийг тавьж, цаашид хөгжих эрх зүйн орчин бүрэлдэхэд таатай нөхцөл бүрдүүлсэн юм.

1995 онд ОХУ-ын Төрийн Думын дарга А.Венгеровский тэргүүтэй төлөөлөгчид, 1996 онд ОХУ-ын Төрийн Думын дарга Г.Селезнёв тэргүүтэй Төрийн Думын төлөөлөгчид, 1999 онд ОХУ-ын ГХЯ-ны сайд И.Иванов Монгол Улсад айлчлав. Эдгээр айлчлалуудын үр дүнд Монгол-Оросын хамтарсан үйлдвэрүүдийн цаашдын асуудал, Монголын бүтээгдэхүүнд оногдуулж байгаа Оросын гаалийн өндөр татвар, Монголын нутаг дэвсгэр дээрх Оросын өмчийн асуудал зэрэг хоёр орны харилцааны тулгамдсан асуудлуудаар яриа хэлцэл өрнүүлж байв.

Монгол-Оросын харилцааны 1991-1999 онуудын сааралт, зогсонги байдлыг гэтлэн давж, шинэ шатанд гарган хөгжүүлэх чухал үйл явдал бол 2000 оны 11-р сарын 13-14-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал байв. ЗХУ-ын төрийн тэргүүн Л.Брежнев 1974 онд БНМАУ-д айлчилснаас хойш 26 жилийн дараа их гүрнийг албан ёсоор залгамжилсан ОХУ-ын төрийн тэргүүний Монгол Улсад хийсэн анхны айлчлал байлаа. Энэ утгаараа В.Путины айлчлал Монголчуудын хувьд удаан хүлээсэн, онцгой үйл явдал болсон юм. Тус айлчлалын үеэр В.Путин цаг үеийн сорилтыг давсан Монгол-Оросын сайн хөршийн харилцааг харилцан туслах хамтран ажиллах олон жилийн бат зузаан уламжлалын үндсэн дээр сэргээн хөгжүүлэх шийдвэр төгс байгааг илэрхийлэн “Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд Монгол Улс онцгой байр эзэлдэг” гэж мэдэгдсэн. Энэ нь Орос улс Монгол дахь уламжлалт нөлөө, байр суурь дээрээ түшиглэн 1990-ээд онд сул байх үедээ алдсан орон зайгаа аажмаар нөхөх, бүс нутаг дахь ашиг сонирхлоо бэхжүүлэхэд чиглэсэн стратегийн сэтгэлгээ нь эргэн сэргэж байгаагийн илэрхийлэл болж байв. Айлчлалын үеэр талууд “Улаанбаатарын тунхаглал”-ыг баталсан нь шинэ зуунд Монгол Оросын харилцааг шинэ шатанд гаргаж, бүх талаар хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, харилцан ашигтай хамтын ажиллагааны улс төрийн үндэс суурийг тавьж өгсөн юм. Тунхаглалд хоёр талын хийгээд бүс нутгийн аюулгүй байдлын асуудлууд онцгой байр суурь эзэлсэн бөгөөд энэ үүднээсээ нэлээд хөтөлбөржсөн шинжтэй болсон байв. Ерөнхийлөгч В.Путиныг Буриад болон Тувагийн Ерөнхийлөгчид, Эрхүү мужийн Амбан захирагч нар дагалдсан нь хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэх, ингэснээрээ Монголыг ямар нэг юмтай холбох, интеграцчлах санаа агуулагдаж байгаа нь илэрхий байв. Тунхаглалын 23-р зүйлд нэгэн онцгой заалт бий. Түүнд “ Оросын тал олон улсын өргөн хамтын ажиллагааны нээлттэй байгууллага болох Шанхайн Чуулга уулзалтын зорилго, зорилт, үйл ажиллагааны тухай Монголын талд мэдээлэв. Монголын тал Чуулга уулзалтын үйл ажиллагааг сонирхон, ямар нэгэн хэлбэрээр түүнд оролцох боломжийг судалж үзэхээ мэдэгдэв” гэсэн байдаг. Үүнээс харахад Монгол Улсыг Шанхайн бүлэглэлд оруулах сонирхолтой байгаагаа 2000 оноос эхлэн илэрхийлж байжээ. Түүнээс гадна Монголын талаарх Оросын гадаад бодлого харьцангуй идэвхжих болсон нэг шалтгаан бол ЗХУ задарсаны дараа Монголд Оросын нөлөө буурч хоосон орон зай үүссэн тэр үед Хятад улс Монголд өөрийн нөлөөг бий болгож чадсан явдал юм. ОХУ-ын Монгол дахь нөлөө буурах тохиолдолд Хятад, АНУ, Японы нөлөө ихсэж, улмаар ОХУ-ын нөлөө Монголд цаашлаад Алс Дорнодод буурахыг үгүйсгэхгүй.

Нөгөөтэйгүүр ОХУ-ын хувьд БНХАУ-тай олон улсын болон бүс нутгийн асуудлаар үйл ажиллагаа, байр сууриа уялдуулан зохицуулж байдаг ба энэ хүрээнд Монгол дахь

тэдний нийтлэг ашиг сонирхлоос үүдэн Орос улс ЗХУ-ын үеэс бий болсон Монгол дахь нөлөөллийн хүрээгээ хадгалах геополитикийн ашиг сонирхол байгаа нь тодорхой.

1990-ээд оноос хоёр улсын Засгийн газрын тэргүүнүүдийн хэмжээнд яригдаж, тохиролцсон зарчмуудыг үндэслэн ОХУ-ын Монголын зах зээлд нэвтрэх, уул, уурхайн салбарт давуу байр суурь олж авахын тулд өрийг чөлөөлж хөрөнгө оруулдаг дэлхий нийтийн жишгийн дагуу Их өрийн асуудлыг шийдвэрлэсэн. Ингэхдээ 2003 онд БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол Улсад айлчлан, “сайн хөршийн, харилцан итгэсэн түншлэл”-ийн харилцаа тогтоож, юуны өмнө уул уурхайн салбарт “эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх”-ээр болж, 300 сая ам.долларын зээл олгох амлалттай Орос улс бараг зэрэгцэн Монгол Улсын их өрийг хүчингүй болгов. Үүнийг их өрийг тэглэх гадаад хүчин зүйл гэж харж болох юм. Ямар ч юманд өөрийн үнэ цэнэ гэж байдаг учир Монгол Улс 2004 онд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад ажиглагчаар элссэн.

2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д албан ёсны айлчлал хийж, “Москвагийн тунхаглал”-д гарын үсэг зурсан ба тус тунхаглалд Монгол Улс, ОХУ ойрын жилүүдэд хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн шинж чанартай болгож, цар хүрээг нь тууштай нэмэгдүүлж, агуулгыг баяжуулж үр ашгийг нь дээшлүүлэх замаар илүү өндөр, чанарын шинэ шатанд гаргана хэмээн тохиролцсон.

2008 он гарсаар Монголын улс төр дэх Оросын оролцоо илт мэдрэгдэж эхэлсэн. Тухайлбал, 2009 онд ОХУ-ын Ерөнхий сайд В.Путин айлчилснаас ердөө гурав хүрэхгүй сарын дараа ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев Монголд айлчилсан нь Оросын тал Монгол дахь нөлөөгөө дахин сэргээх, Монголын орд газруудад уран олборлох Оросын сонирхол нэмэгдсэнтэй холбоотой юм. Тухайлбал, айлчлалын үеэр хоёр орны хооронд “Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай Тунхаглал”-д гарын үсэг зурсан ба энэ үеэр байгуулсан гэрээ хэлэлцээр, баримт бичгүүдээс “Цөмийн эрчим хүч, уран олборлолтын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”, “Дорнод уран” хамтарсан үйлдвэр байгуулах тухай хэлэлцээрийг онцлон дурдаж болно. Гэвч Монголын ураны орд газрын лиценз Канад, Хятад гэх зэрэг орнуудын мэдэлд байгаад Оросууд эмзэглэж, Монголын Засгийн газартай хамтран нөхцөл байдлыг өөрт ашигтайгаар эргүүлж, энэхүү төсөлд давуу эрхтэй оролцохыг чухалчилж байв.

2019 оны 9-р сарын 3-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр орны хооронд “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээ”-г хугацаагүйгээр байгуулснаар хоёр улсын харилцааны хүрч болох хамгийн дээд түвшний харилцаанд хүрэв. 2014 онд Монгол, Хятад хоёр улс харилцаагаа “Иж бүрэн стратегийн түншлэл”-ийн харилцаанд шилжүүлэн хөгжүүлэх болсноор түншлэлийн харилцааны хамгийн өндөр түвшинд хүрээд байсан. Нөгөө талаас Монгол Улсын “Гадаад бодлогын үзэл баримтлал”-д “ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд эдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ” гэж тунхагласан байдаг. Эндээс харахад ч тэр Монгол, Оросын харилцаа, Монгол-Хятадын харилцааны түвшинээс хоцорч байсан бол одоо хоёр хөрштэйгөө хоёулантай нь иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай болж байна.

Түүнчлэн 2009 оны ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев Халхын голын байлдааны ялалтын 70 жилийн ойгоор, 2014 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Халхын голын байлдааны ялалтын 75 жилийн ойгоор, 2019 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Халхын

голын байлдааны ялалтын 80 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд тус ойг тэмдэглэхээр Монгол Улсад айлчилж байгаагаас харахад тэрхүү дайнд Орос улс гол үүрэгтэй оролцож, Монголчуудыг хамгаалан, Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолыг бататгахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгээ давхар сануулахын зэрэгцээ хүнд үед хамтарч чаддаг улс, мөн цаашид ч хамтран ажиллахад саад болох зүйлгүй бөгөөд цаг хугацааны сорилтоор шалгагдсан хоёр орны хоорондын уламжлалт харилцаа хэвээр хадгалагдан үлдсэн гэдгийг харуулсан айлчлалууд байсан хэмээн дүгнэж болохоор байна. Нөгөө талаас Халхын голын дайныг Японччууд "Номон ханы будлиан" хэмээн үздэг явдал дайны ач холбогдлыг бууруулахыг оролдож, түүхийг гуйвуулж байгаа гэсэн үг. Тиймээс Халх голын байлдааны ялалтын ойн арга хэмжээ нь хоёр орны улс төрийн харилцааг тодорхойлох нэг чухал үйл явдал юм.

Ерөнхийлөгч В.Путины 2019 оны 9-р сарын 3-нд Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал нь прагматик шинжтэй байж, хоёр улсын Ерөнхийлөгч нар ажил хэрэгч хэлэлцээр хийж, Монгол-Оросын харилцааг урагшлуулан хөгжүүлэх асуудлаар саналаа солилцсон. Ерөнхийлөгч В.Путиныг дагалдан тус улсын Гадаад хэргийн сайд С.Лавров, Ерөнхий сайдын орлогч А.Гордеев, Эрчим хүчний сайд А.Новак, Батлан хамгаалахын дэд сайд А.Фомин, Оросын төмөр замын РЖД нэгтгэлийн тэргүүн О.Белозеров, Оросын Шууд хөрөнгө оруулалтын сангийн тэргүүн К.Дмитриев, "Роснефть"-ийн тэргүүн И.Сечин зэрэг бизнесийн хүрээний төлөөлөл дагалдсан нь айлчлалын ажил хэрэгч чанар, түвшинг тодорхойлж байна. Айлчлалын үеэр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх Засгийн газар, яамд хоорондын нийт 10 баримт бичигт гарын үсэг зурсны дийлэнх нь эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсний зэрэгцээ уламжлалаа сэргээж уул уурхайн салбарт хайгуулын чиглэлээр хамтран ажиллахаар болов. Эдгээр 10 баримт бичгийг дурдвал:

1. "Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээ"
2. "Терроризмтой тэмцэхэд хамтран ажиллах тухай Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн хоорондын хэлэлцээр"
3. "Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"
4. "Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын 2004 оны хэлэлцээрийн үйлчлэлийг сунгах тухай Засгийн газар хоорондын протокол"
5. "Монгол-Оросын Улсын хил дээр Хиагт-Алтанбулаг олон улсын авто-замын хилийн боомтын хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон ОХУ-ын Холбооны Гаалийн алба хоорондын протокол"
6. "Монгол Улсын Гаалийн ерөнхий газар, ОХУ-ын Холбооны гаалийн алба хоорондын стратегийн хамтын ажиллагааны 2020-2024 оны төлөвлөгөө"
7. "Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны газар, Оросын Холбооны Улсын "Росгеологи" хувьцаат нийгэмлэг /төрийн өмчит компани/ хоорондын хэлэлцээр"
8. Монгол Шуудан хувьцаат компани, Оросын Холбооны Улсын "Орос шуудан" холбооны төрийн нэгдсэн үйлдвэр хоорондын Стратегийн хамтын ажиллагааны хэлэлцээр"

9. “Эрдэнэс Монгол” компани, Оросын Холбооны Улсын “Россеть” олон нийтэд нээлттэй хувьцаат нийгэмлэг хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг”
10. “Ди Би Эм ассет менежмент” үнэт цаасны компани болон Оросын Холбооны Улсын Шууд хөрөнгө оруулалтын сан хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр” болно.

Хоёр улсын төрийн тэргүүн нарын Иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хооронд гарын үсэг зурсан гэрээг хоёр улсын парламент соёрхон баталсан. Соёрхон баталсан батламж жуух бичгийг Монгол Улсын Гадаад харилцааны сайд Н.Энхтайван 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровтай солилцсон. Ийнхүү жуух бичиг солилцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж байна.

ОХУ-ын Монголын талаар баримтлах байр суурь, түүхэн уламжлалт бодлого цаашид өөрчлөгдөхгүй бөгөөд “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа”-нд тулгуурлан явагдах нь тодорхой болж байгаа ч Оросын гадаад бодлогын баримт бичгүүдэд Монголын талаар баримтлах бодлого бүрхэг явж ирсэн төдийгүй ОХУ-ын Гадаад бодлогын үзэл баримтлалын өмнөх 3 баримт бичигт Монголын талаар огт дурдаагүй байдаг. Харин 2013, 2016 онуудад тус тус шинэчлэн баталсан Гадаад бодлогын үзэл баримтлалын бүс нутгийн тэргүүлэх чиглэлийн дотор “Монгол Улстай уламжлалт нөхөрсөг харилцаагаа бэхжүүлэхийг зорино” гэж тусгажээ.

Энэ нь Монголыг геостратегийн эрх ашгийн хүрээндээ багтаан үзэх болж, хил залгаа, хэдэн арван жил өөрийн нөлөөнд байсан Монголыг анхаарлаасаа гаргахгүй гэсэн санаа агуулагдаж байна. Нөгөөтэйгүүр 2000 оноос хойшхи үеийн Оросын улс төрийн харилцааны идэвхижилт нь Оросын талд Монгол дахь нөлөөний төлөөх тэмцэлд оролцох боломжийг олгосон төдийгүй хоёр талын айлчлал, хэлэлцээр, уулзалтуудын үеэр хөндөгдсөн сэдвүүдээс харахад Монголын уул уурхайн салбарт давуу эрхтэй оролцох бүхий л боломжийг эрэлхийлж байлаа. Чингэхдээ ОХУ-ын зарим бодлого Монгол Улсын хувьд нэлээд хатуу байдаг. Тухайлбал, Монгол дахь дэд бүтцийн томоохон төсөл хөтөлбөрт хөндлөнгөөс оролцох, нефть шатахууны хараат байдлаар улбаалан улс төрийн бодлогоо тулган хүлээлгэх, Монголын гуравдагч хөршийн бодлогод эмзэглэх, Монгол дахь Өрнөдийн болон бусад орны нөлөө нэмэгдэж байна, АНУ-ын гадаад бодлого, түүний дотор цэрэг-стратегийн алхмуудыг дэмжиж байна хэмээн үл итгэх, хардах байдлаар ханддаг явдал цаашдын хөгжилд томоохон саад тээг болох магадлалтай. Гэвч нөгөө талаас НАТО Монгол Улстай түншлэл, хамтын ажиллагааны хөтөлбөр байгуулж, түнш орны статустай болсон, Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллагын (ЕАБХАБ) гишүүнээр Монгол Улс элссэн зэргээс харахад хөрш Орос улсын ашиг сонирхол, хүчин зүйлийг хөндөлгүй, эдгээр байгууллагуудтай ил тод, нээлттэй хамтран ажиллахад анхаарахад илүүдэхгүй болов уу.

Стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон 2009 оноос Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон 2019 он хүртэлх өнгөрсөн 10 жилийн хоёр орны харилцааг харахад 2014 оноос хоёр орны иргэд харилцан визгүй зорчих болсныг эс тооцвол тодорхой хэмжээний ахиц гарсан зүйл харагдахгүй байна. ОХУ Монголын эдийн засагт нөлөө үзүүлэхүйц нэг ч шинэ үйлдвэрийн газар байгуулаагүй, дорвитой шууд хөрөнгө оруулалт хийгээгүй байгаа нь түүний геополитикийн зорилт болон их гүрний байр суурьтай нь харьцуулахад чамлалттай үзүүлэлт юм.

Учир нь Стратегийн түншлэлийн харилцаа амжилттай хөгжих нь эдийн засгийн хамтын ажиллагааны үр өгөөжөөс шууд шалтгаална. Улс хоорондын харилцааны практикт дээд түвшинд улс төрийн тохиролцоо хийгдэж, стратегийн түншлэлийн үндэс суурь тавигддаг. Харин бодит үр ашиг нь худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа эрчимтэй хөгжсөнөөр илэрдэг. Монгол судлаач, эрдэмтэн В.В.Грайворонский: “2009 оноос хойш Орос-Монголын харилцаа ерөнхийдөө бэлгэ тэмдэг төдий байгаа гэхэд хилсдэхгүй. Гаднаасаа бүтэмжтэй сайхан мэт харагдавч өмнө нь баталсан хэлэлцээ, гэрээнүүд биелдэггүй” хэмээн дүгнэсэн нь хоёр талын байгуулсан дээрх гэрээ хэлэлцээрүүдийн үр дүнгээс харахад үнэний хувьтай гэж хэлж болохоор байна.

Иймээс хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааны түвшинг хүрээд буй улс төрийн харилцааны  хөгжүүлэх, үр ашгийг нь дээшлүүлэх хөшүүрэг болж чадахгүй, гэрээ, хэлэлцээрүүд тунхаглалын шинжтэй, бодит ажил болж хэрэгжихгүй байгаад оршиж байна. Хоёр орон улс төрийн хүрээнд маш сайн харилцаатай ч талуудын харилцааны шинж чанараас харахад худалдаа, эдийн засгийн харилцаа стратегийн түншлэлийн түвшинд хүрээгүй, талууд өөр өөрийн гэсэн хүлээлтийг бий болгож, тэр нь биелэхгүй байгаа, Орос улс Монголтой улс төр, эдийн засгийн хувьд стратегийн харилцааны хэмжээнд бодлого хэрэгжүүлэхгүй байна. Үүний зэрэгцээ Монголын нутгаар дайруулан хийн хоолой тавих, Монгол дахь төмөр зам, уул уурхай, эрчим хүч, нефть боловсруулах томоохон төслүүд хэрэгжиж чадалгүй ирсэн. Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон энэ цаг үеэс эхлэн, гаргасан шийдвэрүүдээ ажил хэрэг болгож, харилцан ашигтай төсөл хэрэгжүүлж чадах эсэх эргэлзээ мөн л төрж байна. Учир нь Монголын талын удирдлагын тууштай бус бодлого шийдвэр, стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын томоохон ордыг эзэмших болон гадаадын хөрөнгө оруулалтын хууль эрх зүйн орчны байнгын өөрчлөлт, Монголын улс төрийн тогтворгүй байдал зэрэг нь хоёр талын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байгаа юм. Энд дурдвал зохилтой нэг зүйл бол Монгол Улсаас ОХУ-д суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдуудын томилгоо оновчтой бус, намын харъяаллаар, мэргэжлийн бус хүмүүс томилогдох болсон нь хоёр талын харилцаа, хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нэг хүчин зүйл гэж хэлж болно.

Оросын хувьд  зах зээлийн зарчим, шударга өрсөлдөөний үед бусад оролцогчидтой эн тэнцүү өрсөлдөхөд бэлэн биш байсны дээр Оросууд илэрхий давуу, онцгой эрх эдэлнэ гэдэгтээ хэт найдаж байв. Монгол дахь Оросын эдийн засгийн сонирхлыг урагшлуулахад саад болсон хүчин зүйл бол Оросын Монголын талаарх алдаатай стратегийн бодлоготой нь холбоотой. Энэ нь нэгдүгээрт, Орос улс Монголын улс төрийн орон зайг “Оросын талыг баримтлагчид” буюу МАХН болон “барууныхныг баримтлагчид” буюу Ардчилсан нам гэсэн улс төрийн хүчнүүдэд  хуваагдсан гэж үзсэн учир МАХН-ыг бүх талаар дэмжихийг хичээж байв. Хоёрдугаарт, Энэ тооцооллоос улбаалан Монгол, Оросын улс төрийн харилцааны өндөр дээд түвшин болоод хоёр орны төрийн тэргүүнүүдийн хувийн харилцан итгэсэн харилцаан дээр  тулгуурлан Монгол дахь Оросын эдийн засгийн ашиг сонирхол, юуны өмнө хамгийн ирээдүйтэй салбар болох уул уурхайн салбар дахь Оросын оролцоог баталгаажуулна гэж үзсэн. Энэхүү төөрөгдөл нь Монгол Улсын Парламентын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр оросын албаны хүмүүс МАХН-ыг нээлттэй дэмжсэнээр илэрч байв. Оросын Засгийн газрын МАХН/МАН-д хандах хандлага нь дараах шалтгаанаар тайлбарлагдана. Үүнд: Монголд бараг монополь эрхтэйгээр төр барьж байсан МАХН-ын үед хоёр талын харилцан ойлголцол нэмэгдсэн. Тухайлбал, 2000-2004 онд УИХ-д 76 суудлаас 72

суудлыг МАХН-аас нэр дэвшсэн гишүүд эзэлж, Ерөнхийлөгч болон Ерөнхий сайд ч тус намын төлөөлөгчид байв. Тухайлбал, 2008 онд ОХУ-ын Төрийн Дум-ын депутат, олон улсын асуудал эрхэлсэн хорооны гишүүн Р.Кондратов Монголд айлчлах үеэр удахгүй болох парламентын сонгуульд МАХН/МАН-ыг дэмжиж байгаа тухайгаа мэдэгдсэн. Түүнчлэн 2009 оны Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшсэн Ц.Элбэгдорж сонгуульд ялалт байгуулсан бөгөөд МАХН-аас нэр дэвшсэн Н.Энхбаярыг В.Путин 2009 оны 5-р сард Монгол Улсад айлчлах үеэр дэмжсэн явдал Оросын удирдлагын алдаатай бодлогын нэг илрэл байв. Үнэн хэрэг дээрээ Монголын төр, нийгмийн зүтгэлтнүүдийн ихэнх нь тэдний намын харъяалал, улс төрийн үзэл баримтлалаас нь үл хамааран Орос, Хятад, Барууны орнуудыг түшиглэсэн олон талт гадаад бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг ба чингэхдээ хүчний төвүүдийн алийг нь ч онцлодоггүй. Иймээс Оросын Засгийн газар зөвхөн МАХН-ыг дэмжиж байгаа нь Монголын дотоод улс төрийн байдал өөрчлөгдөн буй нөхцөлд алсын хараагүй бодлого явуулж буйг харуулж байна.

Хоёр улс 1970-аад оноос зэсийн томоохон төслийг хэрэгжүүлэхдээ “Эрдэнэт” уулын баяжуулах үйлдвэрийг Монголын талын 49 хувь, Оросын талын 51 хувийн эзэмшилтэйгээр анх байгуулсан түүхтэй. ЗХУ задрахаас ердөө хоёр сарын өмнө буюу 1991 оны зун талууд зэсийн төслийн хэлэлцээрийг шинэчлэхдээ Монгол 51 хувь, Орос 49 хувийг эзэмшихээр болсон билээ. Энэ л үеэс талууд хамтарсан үйлдвэр дэх өөр өөрийн хувь эзэмшлийг нэмэгдүүлэх гэж далдхандаа “өрсөлдөж” ирсэн нь нууц биш бөгөөд аль аль талын хувь эзэмшил өөрчлөгдөлгүй өнөөг хүрсэн юм. Орос улсын хувьд иргэний болон цэргийн өндөр технологийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох стратегийн зорилготойгоор 2007 оны сүүлчээр төрийн өмчит “Ростехнологи” корпорацийг байгуулсан билээ. Ингэхдээ В.Путины шийдвэрээр корпорацийн шууд мэдэлд “Эрдэнэт” үйлдвэрийн Оросын талын 49 хувь очсон юм. Тухайн үед Оросын хэвлэл мэдээллүүд “Ростехнологи”-ийг зэсийн олборлолтоороо Азидаа тавдугаарт орох үйлдвэрийн хувь эзэмшигч боллоо” хэмээн онцолж байлаа. Гэвч тус үйлдвэрийн зэсийн баяжмал Орос руу биш Хятад руу гардаг бөгөөд Монгол Улс “гэнэтийн ашгийн татвар”-тай болсноор Оросын тал алдагдал хүлээх болж, “Эрдэнэт” хамтарсан үйлдвэр уг хуулийн дагуу 400 сая доллар төлснөөс болж Орос улс 196 сая ам.долларын алдагдал хүлээж байв. Эдгээр хүчин зүйлс нөлөөлсөн байж болох талтай ч ямартаа ч 2016 онд Монгол, Оросын хамтарсан “Эрдэнэт” үйлдвэр болон “Монголросцветмет” нэгдлийн 49 хувийг эзэмшиж байсан Оросын “Ростех” корпораци өөрийн эзэмшлийн бүх хувьцааг Монголын хувийн хэвшлийн компанид худалдсанаар Орос улс Монголын зах зээлээс гарсан. Ийнхүү тавь, тавин хувийн эзэмшилтэй “Улаанбаатар төмөр зам”-ыг эс тооцвол Монгол Улс дахь Оросын геоэдийн засгийн ашиг сонирхол үгүй болсон гэж харж болохоор байна.

Дэлхийн томоохон нүүрсний орд болох Таван Толгойг Монголын төмөр замын төв шугамтай холбож өгөх, төмөр замыг шинэчлэх, хариуд нь ашигт малтмалын мега төслүүд, тухайлбал, Асгатын мөнгөний орд, Таван Толгойн нүүрсний орд, Дорнодын ураны ордыг ашиглахад оролцох оролцоогоо баталгаажуулах оролдлогыг Оросын тал хийсэн хэдий ч одоогоор ямар ч амжилт олоогүй байгаа явдал нэг талаас зөвлөлтийн үеийн нөлөөнд дулдуйдсан бодлого, нөгөө талаас өнөөг хүртэл Монголын талаарх алдаатай төөрөлдсөн стратегийн бодлоготой нь холбоотой юм. Орос улс Монголын уул уурхайн салбарт чухал тоглогч болох давуу эрх олж авна гэдэгт итгэл дүүрэн байсан нь

Зөвлөлтийн үед оросууд хайн судалсан, ихээхэн хэмжээний хөрөнгө оруулсан гэдэгтээ илүү найдвар тавьж байсанд оршино.

ОХУ экспортын хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг, эхний байруудад ордог улсын хувьд Монголын уул уурхайн салбар дахь Оросын оролцоог нэмэгдүүлэх сонирхол юунд байна гэдэг асуудал судлаачдын анхаарлыг зүй ёсоор татдаг. Энэ нь Орос улс Монгол руу чиглэсэн бодлого хэрэгжүүлж байгаа нь байгалийн баялгийг сонирхохоос гадна геостратегийн хувьд Монгол дахь нөлөөний хүрээгээ нэмэгдүүлэх Оросын гадаад бодлогын чиглэлээр тайлбарлагдана.

Оросын хувьд төмөр замыг Дорнод Монгол хүртэл сунган тавьснаар Монгол дахь нөлөөгөө сулруулахгүй хэвээр хадгалах сонирхолтой. Түүнчлэн ОХУ "Төмөр замын тээврийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги"-ийг баталж, Транссибирийн төмөр замыг шинэчлэн барихаар төлөвлөж байгаа бөгөөд Оросын Евразийн нутгийг дамнасан транзит тээврийн маршрутыг тогтоож, Оросын Сибирь болон Алс Дорнодын бүс нутгийн төмөр замын тээвэрлэх чадварыг нэмэгдүүлэхийг зорьж байна. Монголын төмөр замын 50%-ийг эзэмшдэгийн хувьд "Оросын төмөр зам" ХНН төмөр замын үйл ажиллагаанд онцгой эрх үүрэгтэй оролцдог. Монголын Зам, тээврийн яам "Оросын төмөр зам" ХНН-тэй 2014 оны 2-р сараас эхлэн хэлэлцээ хийж, "Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн хэлэлцээр"-ийн төслийг бэлтгэн, 2014 оны 9 дүгээр сарын 3-нд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын үеэр баталгаажуулсан. Хэлэлцээрээр "УБТЗ" ХНН-ийн төмөр замын сүлжээг анх удаа эдийн засгийн үндэслэлтэй үндсэн 4 чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлэх, одоо байгаа коридорыг жилд 100 сая тн хүртэл ачаа тээвэрлэх хүчин чадалтай болгох, төмөр замыг цахилгаанжуулах, хос болгох, Салхит-Эрдэнэтийн салбар төмөр замын шугамыг баруун хойд чиглэлд үргэлжлүүлэн Монгол Улс, ОХУ-ын хилд хүргэж, ОХУ руу төмөр замын шинэ гарц нээх, улмаар ОХУ-ын Тува улсын Кызылтэй холбосноор ОХУ-ын уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын нутгаар дамжуулан БНХАУ-д гаргах шинэ замнал бий болгох, Монголын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, "Богдхан" төмөр замыг барих, Монголын баруун бүс нутгаар дайран өнгөрөх босоо чиглэлийн шинэ коридор байгуулах талаар хамтран ажиллахаар тохиролцов. Түүнчлэн тус айлчлалын үеэр Монголын эдийн засагт өндөр ач холбогдолтой хэд хэдэн тохиролцоонд хүрсэн. Тухайлбал, Монгол Улс БНАСАУ дахь ОХУ-ын хөрөнгө оруулалттай Ражин боомтод хувь эзэмшиж, хамтран ашиглах тохиролцоонд хүрсэн нь Монгол Улс анх удаа өөрийн далайн боомттой болох боломжтой боллоо гэсэн үг. Дээрх хэлэлцээрийн заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдсан Монгол, Орос хоёр талын ажлын хэсгийн анхны хамтарсан хурал 2015 оны 12 дугаар сарын 7-нд Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан. Айлчлалын үеэр тохиролцсон гэрээ хэлэлцээрүүдийг ажил хэрэг болгоход хоёр талын хүчин чармайлт дутмаг байгаа ч ОХУ-ын зүгээс ялангуяа төмөр замын шинэчлэлтэй холбоотой гэрээ хэлэлцээрүүд хөрөнгө мөнгө, санхүүжилтээс шалтгаалах учир хэрэгжихгүй байгаа тал бий. Түүнээс гадна ОХУ-ын "Русал", "Базовый элемент", "Ренова", "Севесталь", "Полиметал", "Газпромбанк" зэрэг санхүү, үйлдвэрлэлийн том бүлэглэлүүд Тавантолгойн нүүрсний орд, Оюу Толгойн зэс, алтны ордод хөрөнгө оруулалт хийж оролцох сонирхолоо илэрхийлэн үүндээ ч итгэлтэй байв. Түүнчлэн 2009 оны зун Оросын Засгийн газрын дэмжлэгийг авсан "РЖД" буюу "Оросын төмөр зам" компанийн удирдлага энэхүү ордын боловсруулалтын лицензийг олж авна гэдэгт ихэд найдвар тавьж байв. Энэ нь 2009 оны 5-р сард В.Путин Монголд айлчлах үеэрээ Монгол Улсын

Ерөнхийлөгч Н.Энхбаяр болон Ерөнхий сайд С.Баяртай хувийн журмаар хийсэн аман тохиролцоо байлаа. Гэвч 2009 оны 10-р сард Монголын Засгийн газар Оюу Толгойн олборлолтын лицензийг Канад-Австралийн хамтарсан “Айвенхоу Майнз” болон Рио Тинтод шилжүүлэв. Үүнээс үүдээд Оросын том компаниуд Монголд хөрөнгө оруулах сонирхол буурсан гэж хэлж болно.

Монгол Улс 1998 оноос хойш ОХУ, БНХАУ-тай дамжин өнгөрөх тээврийн асуудлаар гурван талын ерөнхий хэлэлцээр байгуулахаар хэд хэдэн удаа яриа хэлэлцээр хийсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байв. Харин 2018 оны 6 дугаар сарын 8-нд Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулан ОХУ-аар дамжуулан гуравдагч зах зээлд гаргах тохиолдолд ОХУ-ын нутгаар дамжин тээвэрлэх төмөр замын тээвэрлэлтэд 25 жилийн турш тогтвортой тарифын хөнгөлөлт эдлэх болж байна. Ийнхүү арван жилийн дараа Орос өөрийн нутгаар транзитын хямд, тогтвортой үнээр тээврийн коридор нээлээ. Олон улсын зах зээлд нүүрсний ханш түүхэн дээд үзүүлэлтэд хүрсэн цаг үед Монголын тал ОХУ-д санал тавьж, РЖД тэргүүтэй Оросын цөөнгүй компаниуд дэлхийн уул уурхайн том компаниудтай Тавантолгойн ордын төлөө өрсөлдөж байсан юм. Дэлхийд нүүрсний төслүүд анхаарлаас алсарч, түүхий эдийн үнэ цэнэ нь буурч байгаа одоо цагт 4000 км замыг туулах тарифын хөнгөлөлт монголчуудад шууд ашиг тусаа өгөх нь цаг хугацааны асуудал юм. Нөгөөтэйгүүр өөдрөгөөр харвал Монгол улсын уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг гуравдагч улсын зах зээлд гаргахад экспортын үнийн өрсөлдөх чадварыг хангах, уул уурхай, үйлдвэрлэлийн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг татаж урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаа явуулахад чухал ач холбогдолтой юм. Юутай ч УБТЗ нь Орос, Хятад гэсэн том зах зээлийг холбосон транзит тээврийн зангилаа болж, өрсөлдөх чадвар нэмэгдэхийн зэрэгцээ хил, гааль, логистик, терминалын үйлчилгээг сайжруулснаар Евразийн геополитик, тээврийн интеграцид өөрийн орны байр суурийг бэхжүүлэх, зах зээлээ тэлэх, ачаа тээвэрлэлт өсөх, үр ашиг нь нэмэгдэх боломж нээгдэх юм. Үүний дагуу Монгол Улс ОХУ-аар дамжуулах нүүрсний тээвэрт 66,4 хувь, чингэлэг тээвэрт 52 хувийн хөнгөлөлт эдлэх үүд хаалга нээгдээд байна. Гол нь дотооддоо хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төмөр замын төслүүдээ гацаанаас гаргаснаар гуравдагч зах зээлд гарах гарцын асуудал яригдах нь дамжиггүй.

Түүнчлэн Оросын талын шийдвэрийг хүлээгээд удаж буй төмөр замын эрх зүйн шинэчлэлийн стратегийн асуудлыг дээрх тохиролцоонд хүрсэн шинэ төмөр замын төслүүдтэй нэгэн зэрэг боловсруулан шинэчлэх асуудал чухлаар тавигдаж байна. БНМАУ, ЗХУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны 6 дугаар сард байгуулсан хоёр улсын хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэг байгуулах тухай гэрээ нь өнөөдрийг хүртэл шинэчлэгдээгүй, хүчинтэй хэвээр явсаар байгаа нь олон талаараа УБТЗ-ыг үр ашигтай, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх бодлого явуулахад саад тотгор болж байгаа нь хэнд ч нууц биш юм. Тус гэрээг Монгол Улсын хөгжлийн өнөөгийн цаг үеийн шаардлага, хууль эрх зүйн нэр томьёо, утга агуулга, зах зээлийн нийгмийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэх, ялангуяа нийгэмлэгийн эдлэх монополь эрх болон татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбогдох заалтуудыг эргэж харах шаардлагатай байна. “УБТЗ” нийгэмлэгийн үйл ажиллагаа нь түүхэн үүргээ нэгэнт гүйцэтгэж дууссан, олон улсын хуучирсан гэрээгээр өнөөг хүртэл зохицуулагдаж, Монгол Улсын Үндсэн хууль болон Татварын хуулийг зөрчсөөр байгааг тус гэрээний нэг зүйлийг дурдахад

хангалттай юм. Тухайлбал, БНМАУ-ын Засгийн газар ЗХУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны гэрээний 10 дугээр зүйлд "Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хувь нийлүүлсэн нийгэмлэг, түүний салбар, контор, төлөөлөгчдийн газруудыг байгуулах, бүртгэхэд хамааралтай ямар нэгэн татвар, хураамжийг үл ногдуулна. Түүнчлэн БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр одоо байгаа болон ирээдүйд бий болох ямар ч татвар, хураамжийг үл ногдуулна" гэж заасан байна. Монгол Улсад ашиггүй гэрээний энэ заалтын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх төсөвт ямар ч татвар төлдөггүй цорын ганц аж ахуйн нэгж юм. Хувь тэнцүү хувьцаа эзэмшдэг УБТЗ нийгэмлэгийн дээд удирдлагыг хувь нийлүүлэгч хоёр тал тэнцүү хуваарилан хэрэгжүүлдэг бүтэц, зохион байгуулалт нь шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлдөг тул Монголын Засгийн газар УБТЗ ХНН-т тавих хяналтыг сайжруулах зорилгоор өөрийн эзэмшлийн хувьцааг 51 хувьд хүргэх боломжийг эрэлхийлсээр ирсэн. Өргөн хүрээтэй хамтран ажиллах аливаа санал, санаачилга байвч Монголын тал асуудлыг ганцаарчлан шийдэх эрх мэдэл байдаггүйгээс гуравдагч орнуудын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны саналыг хүлээн авах боломжгүйн дээр УБТЗ нь үйл ажиллагааныхаа орлогоос олсон ашгаа (дивиденд) Оросын талтай тэгш хуваадаг. Тухайлбал, АНУ-ын Мянганы Сорилтын сангаас 285 сая ам.долларын буцалтгүй тусламжийн ихэнх хувь болох 188.3 сая ам.долларыг Монголын төмөр замын шинэчлэлтэд зориулан санхүүжүүлэх боломжтой байсан боловч Орос улс гуравдагч орны мөнгийг төмөр замд оруулахыг хүлээж аваагүй. Энэ нь ОХУ-ын зүгээс Монголын "гуравдахь хөршийн" бодлогыг саармагжуулах бодлогын илрэл гэж үзэж болно.

Монгол Улсын ашигт малтмал, газрын баялгийг ашиглах, хамтарсан болон бие даасан хөрөнгө оруулах сонирхол дэлхийн олон том компаниудад байгаа өнөө үед түүхэн хөгжлийнхөө явцад хэзээ ч ийм хөрөнгө оруулалтын далайцтай хувилбарууд, харилцан ашигтай санал, бизнесийн хууль эрхзүйн хувьд боломжтой үе Монгол Улсын төмөр замын өмнө тулгарч байгаагүй гэж хэлэхэд болно. УБТЗ-ын суурь бүтэц, үндсэн бааз суурийг ашиглан түүнийг орчин үеийн Ази-Европыг холбосон хамгийн дөт, ачаа тээвэрлэн өнгөрүүлэх хүчин чадал сайтай, ачаа хүргэх хугацаа нь хамгийн бага байх, цахилгаанжсан төмөр зам болгох таатай эрх зүйн орчин өмнө нь хэзээ ч байгаагүй гэсэн үг юм. Тиймээс 1949 оны гэрээг зайлшгүй өөрчилж, Оросын талаас хараат байдлыг арилгах шаардлага байгаа юм. Тус гэрээнд өөрчлөлт оруулсанаар Монгол Улсын төмөр замыг 2021 он хүртэл хөгжүүлэх бизнес төлөвлөгөөг биелүүлэхэд шаардлагатай хөрөнгийг гуравдагч орнууд болон ОХУ-ын "Оросын төмөр замууд" нээлттэй хувьцаат нийгэмлэгтэй аль алинтай нь харилцан ашигтай гэрээ хэлцэл хийж, төмөр замын хүчин чадлыг сайжруулах боломжтой болох юм. Гэвч Оросын тал тус гэрээг шинэчлэх ажилд тодорхой алхам хийхгүй байгаа нь Монголын уул уурхайн салбарт хүлээж байсан үр дүндээ хүрч чадаагүйтэй холбон үзэж болох талтай. Түүнчлэн айлчлалуудын үеэр тохиролцсоны дагуу ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев 2009 оны 8 дугаар сарын 22-нд Москва хотноо Зөвлөлт-Монголын хувь нийлүүлсэн "Улаанбаатар төмөр зам" нийгэмлэгийн "Оросын төмөр зам"-ын /РЖД/ эзэмшиж буй холбооны мэдлийн хувьцааны төлөөлөн удирдах гэрээг 5 жилийн хугацаатай сунгах тухай зарлигт гарын үсэг зурсан. ОХУ-ын Ерөнхийлөгч В. Путин 2014 оны 9 дүгээр сарын 4-нд тус гэрээг 2019 оны 12-р сарын 17 хүртэл сунгах тухай зарлигт гарын үсэг зурсан. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины 2019 оны 9-р сарын 3-нд Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр Монголын талын Зүүнбаян-Ханги чиглэлийн шинэ төмөр замын бүтээн байгуулалтад 100 тэрбум рублийн экспортын зээл хүссэн ч Оросын тал хариу өгөөгүй байхад

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус зээл авах гэж байгаа мэт шуугиж байна. Хүлээлттэй байсан төмөр замын гэрээг шинэчлэх тухай  яриа хэлэлцээ болоогүй нь дээр дурдсан тав, таван жилийн хугацаатай ОХУ-ын Ерөнхийлөгчийн гаргадаг тус зарлигийг үндэс болгон 1949 онд байгуулсан хоёр орны гэрээ ойрын хугацаанд шинэчлэгдэх эсэх нь тодорхойгүй хэвээр үлдэж байна. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад айлчилснаас гурван сарын дараа 2019 оны 12 дугаар сарын 3-6-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ОХУ-ын Засгийн газрын дарга Д.А.Медведевийн урилгаар ОХУ-д албан айлчлал хийсэн. Энэ нь Монгол Улсын Ерөнхий сайдын түвшинд есөн жилийн дараа ОХУ-д айлчилснаараа онцлог байв. 2010 онд тухайн үеийн Засгийн газрын тэргүүний албан айлчлалаар Монголын их өрийг тэглэж, “Эрдэнэт” үйлдвэр болон “Монголросцветмет” компаниудыг нэгтгэн IPO гаргах талаар талууд санал солилцож, нийт 11 баримт бичгийг үзэглэсэн байдаг. Энэ удаагийн Ерөнхий сайдын айлчлалаар 15 баримт бичиг байгуулсны дотор Монгол Улсын Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр замын шугам барих, ажил  гүйцэтгэх тухай гэрээг хэрэгжүүлэхэд техникийн зөвлөгөөний үйлчилгээ үзүүлэх тухай “Улаанбаатар төмөр зам” ХНН болон Оросын “РЖД Интернешнл” компани хооронд гэрээ байгуулсан. Айлчлалын үеэр хоёр улсын Засгийн газрын тэргүүн нар зам, тээврийн салбарын хамтын ажиллагаа, “Улаанбаатар төмөр зам”ХНН-ийн хөгжил шинэчлэлийн талаар болон нийгэмлэгийн дүрмийн санг нэмэгдүүлэх асуудлыг хөндсөн бөгөөд зам, тээврийн салбарын хоёр баримт бичгийг байгууллаа. Оросын төмөр зам” (РЖД) компани нь Монголын төмөр замыг шинэчлэх төслийг хэрэгжүүлэх эхний ээлжинд 260 сая ам.долларын хөрөнгө оруулахаар төлөвлөж байгаа юм. Монголд шинээр баригдах төмөр замын төслүүдэд Оросын Шууд хөрөнгө оруулалтын сан хөрөнгө оруулахаар сонирхож байна.

Монголын төмөр замын өмнө тулгарч буй олон төрлийн бэрхшээл, хүндрэл хийгээд төмөр замын ирээдүйн асуудал Оросын болоод Монголын талын харилцан идэвхитэй оролцоогүйгээр шийдвэрлэгдэхгүй юм.

Монгол Улсын хувьд эдийн засгийн бүх салбарт гадаадын хөрөнгө оруулагч орсон, төрөлжсөн байх нь эдийн засгийн хөгжил, аюулгүй байдалд нэн чухал бөгөөд эрдэс баялгийн тээвэрлэлтийг төрөлжүүлэх үүднээс шинэ төмөр зам барихад хөрөнгө оруулалтыг татах байр суурьтай байна. Ямар ч аймгийн төвийг дайраагүй босоо тэнхлэгийн нэг гол зам, хэдэн салаа зам бүхий одоогийн төмөр замыг өргөтгөх, шинэ төмөр зам барих төсөл нь зөвхөн нүүрс зөөхийн тулд биш улс орныг хөгжүүлэх том хөшүүрэг болох үүднээс үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал юм. 2008 онд “Шинэ төмөр зам” төслийг хэрэгжүүлэх “Монголын төмөр зам” төрийн өмчит компани байгуулагдсан боловч санхүүгийн эх үүсвэрээс шалтгаалан төмөр зам тавих асуудал зогсонги байдалд ороод удаж байна.

Монгол Улс төмөр зам барьж байгуулах асуудлыг зөвхөн дангаараа биш, хөрш орнуудын бодлого, хөгжлийн хандлага, нөхцөл байдалтай уялдуулах нь чухал юм. Өнгөрсөн 2014-2016 онуудад Монгол, Орос, Хятадын дээд хэмжээний уулзалтуудын хүрээнд Монголын санаачилгаар “Нэг бүс нэг зам”, “ЕвроАзийн эдийн засгийн холбоо”, “Талын зам” санаачлагыг нэгтгэн уялдуулах хэлбэрээр гурван улс эдийн засгийн коридорт хамтран ажиллах хөтөлбөр боловсруулсан. Улмаар 2016 оны 6 дугаар сард Узбекистан улсын нийслэл Ташкент хотноо болсон Төрийн тэргүүнүүдийн гурван талт уулзалтаар гурван улсыг холбосон “Эдийн засгийн коридор” байгуулах тохиролцоонд хүрч, хөтөлбөрийг баталсан.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын эрдэс баялгийн салбар эрчимтэй хөгжиж, томоохон ордуудыг шинээр нээж илрүүлснээр эдгээр орд газруудын эрдэс баялгийг зөөх, тээвэрлэхэд төмөр замын сүлжээ байгуулах, шинэчлэх явдал төмөр замын эдийн засгийн нэвтрүүлэх чадварт нөлөөлөх чухал хүчин зүйл болж байна. Өнөөдөр Монголын төмөр зам дээд ачааллалдаа хүрсэн, төмөр зам өсөхгүй болохоор уул уурхай өсөхгүй. Тэгэхээр уул уурхайн өсөлтийн хязгаарлагч нь төмөр зам болж байгаа нь Монгол Улс уул уурхайгаас хараат биш төмөр замаас хараат болсон мэт харагдаж байна. Тухайлбал, Орос, Хятадтай холбосон төмөр замын шугаманд байгалийн болон техникийн осол гарах болон бусад хориг арга хэмжээ тавигдахад олон улсын чанартай тээвэр зогсож, бараа бүтээгдэхүүний хангамж доголдох, экспортын орлого буурах, дотоодын зах зээл дээр импортын бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх зэрэг олон эрсдэлийг ар араасаа дагуулах аюултай. Нөгөөтэйгүүр дотоодын төмөр зам барих асуудал Оросоос хэт хамаардаг, мөн төмөр замын тээвэрт Хятадын нөлөө бий болсон, гуравдагч орны дэмжлэг авах боломж хомс тул хөрш их гүрнүүдийн нөлөөгөө тэлэх гэсэн өрсөлдөөний зэрэгцээ Орос улс төмөр зам дахь эрх мэдлийн тэнцвэртэй байдлаа ашиглан, Монгол Улсын эдийн засагт шууд болон шууд бус замаар нөлөөлөх ашиг сонирхлын улмаас төмөр замын шинэчлэл мухардмал байдалд ороход хүрсэн байна.

Оросын Монголын эдийн засагт үзүүлэх нөлөөлөл 1990 оноос хойш тасралтгүй буурсаар ирсэн. Тийм ч учраас Оросын зүгээс Монголтой эдийн засгийн интеграцчлал дахин үүсгэх, өөрийн сонирхлыг томоохон шийдвэрүүдэд оруулах сонирхол нэмэгдэж байна. Оросын Монгол дахь улс төр, стратегийн ашиг сонирхол, түүнийг бэхжүүлэх үүднээс явагдаж байдаг эдийн засгийн ашиг сонирхлын агуулга, чиглэл өөрчлөгдөөгүй боловч Оросын эдийн засгийн өнөөгийн ашиг сонирхлыг түүний Сибирь, Алс Дорнодын бүс нутгаа хөгжүүлэх бодлогын түвшинд Ази, Номхон далай руу чиглэсэн бодлоготой уялдуулах, Евразийн интеграцийн хүрээнд баримталж буй бодлоготой холбон үзэх нь илүү тохиромжтой.

Сүүлийн жилүүдэд Алс Дорнодын бүс нутгийг хөгжүүлэх үүднээс Алс Дорнодын хөгжлийн яамыг шинээр үүсгэн байгуулсан ба Алс Дорнод, Байгалийн бүсийг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийг баталсан. Тус хөгжлийн хөтөлбөрт Монгол Улстай хил залгаа орших Байгаль орчмын бүс нутаг оролцож байгаагийн дотор Монгол угсаатан оршин суудаг хүн амын бүтэцтэй Холбооны субъектууд хөгжлийн хөтөлбөрт онцгой үүрэг оролцоотой байх нь хоёр талын худалдаа, эдийн засгийн эргэлтэнд 70 гаруй хувийг дангаараа эзэлж байдаг тус бүс нутаг Монголын хувьд ихээхэн ач холбогдолтой байх нь тодорхой. Хэдийгээр Оросын Азийн чиглэлд Монгол Улс тодорхой байр суурь эзэлж буй боловч Оросын гадаад худалдаанд Монголын эзлэх хувь өчүүхэн бага бөгөөд экспортод 0,5 хувь, импортод 0,7 хувь -ийг эзэлж байгаагаас харахад Монголын зах зээл хэмжээ, багтаамжийн хувьд маш бага, энэ утгаараа эдийн засгийн хувьд ашигтай байдал харагдахгүй байгаа юм. Учир нь Монголын экспортын бараа, бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар доогуур, нэр төрөл цөөн, Оростой адил уул уурхайд чиглэсэн эдийн засгийн бүтэцтэй.

Монголын хувьд Оросын гаалийн өндөр татвар, тарифын болон тарифын бус саад тотгор, бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх, тээвэрлэх, борлуулахад оршиж буй саад бэрхшээл, Монголын мах, махан бүтээгдэхүүнд оросын талаас тавьж буй хорио цээр, квот, ариун цэвэр, эрүүл ахуйн хэт хатуу нөхцөл, Оросын нутаг дээгүүр транзит тээвэр хийхэд өндөр үнэтэй, хүнд суртал ихтэй зэрэг асуудлууд хоёр талын худалдаанд саад учруулж буй нэг хүчин зүйл гэж үздэг. ОХУ-ын Монгол Улстай худалдаа хийхэд

гарч байгаа эдгээр тарифын болон тарифын бус хориг саадууд нь зөвхөн Монгол Улсад зориулан тогтоож байгаа явдал биш юм. ОХУ нь хуурай газраар дэлхийн 18 оронтой хиллэдгийн хувьд экспорт, импортын бараанд хяналт болон хязгаарлалтыг тогтоохдоо дотоодын зах зээлээ хамгаалж, аливаа түүхий эдийн боловсруулалтын түвшинг дагуулан өсгөн нэмэгдүүлсэн гаалийн татвар ноогдуулах тогтолцоотой ба ДХБ-ын хамгаалалтын арга хэмжээ, Гаалийн холбооны гишүүдийн хоорондын олон төрлийн гэрээгээр зохицуулагддаг бөгөөд Евразийн эдийн засгийн холбооны болон үндэсний хэмжээний хууль тогтоомжоор зохицуулагддаг.

Орос-Украины хямралаас үүдэж өрнөдийнхний зүгээс үе шаттай авч хэрэгжүүлсэн болон Оросын хариу хориг арга хэмжээ авсан хийгээд түүхий эдийн зах зээлийн үнэ унасан зэрэг үйл явц Орос улс эдийн засгийн бүтцээ өөрчлөх нөхцөл байдлыг бий болгов. Үүнтэй холбоотой “Нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах эн тэргүүнд хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г 2015 оны 1 дүгээр сард баталж, уг баримт бичигт эдийн засгийг тогтворжуулах болон өсгөхөд чиглэсэн 60 гаруй арга хэмжээг тусгасан байна. Үүнээс үзвэл Орос улс үндэсний үйлдвэрлэлээ хөгжүүлэх, Ази дахь байр сууриа сэргээх бодлогоо эрчимжүүлэх бодлого, төлөвлөгөө гаргасан. Оросын экспортын 80 хувийг түлш ашигт малтмал, импортын 75 хувийг аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, 40 хувийг хүнсний бүтээгдэхүүн эзэлдэг.

ОХУ-ын Сибирь, Алс Дорнодоо хөгжүүлэх үүднээс Ази руу чиглэсэн бодлогоо идэвхитэй урагшлуулж, Хятад чөлөөт худалдааны бодлогын стратегиа хэрэгжүүлснээр Монгол, Орос, Хятад гурван талт хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улс Орос, Хятадыг холбогч тэнхлэг улсын хувьд ашиг сонирхлын нийлбэр дээр урагшлах учраас үр өгөөж ихтэй байхын зэрэгцээ гурван талын ашиг сонирхол давхцахгүй тохиолдолд гацах магадлалтай боловч хоёр талын хүрээнд асуудлыг шийдэх бүрэн боломжтой. Дамжин өнгөрөх хязгаарлагдмал эрх, хэт өндөр төлбөр ногдуулах, тухайн зах зээлд тээвэрлэлтийн арга, хэрэгслийг сонгоход ялгавартай хандах зэрэг тарифын бус хориг, саадуудыг илрүүлэн судалж олон болон хоёр талын талын хэмжээнд хэлэлцэх нь зүйтэй бөгөөд Монгол улс өөрийн эрх ашгийг хамгаалахын төлөө шургуу ажиллахаас өөр аргагүй.

**Дүгнэлт**

1. Монгол, Оросын харилцаа нь түүхийн явцад бүрэлдсэн, уламжлалт, найрсаг, сайн хөршийн харилцаанд тулгуурлан хоёр талын хүчин чармайлтаар шинэ зууны эхэн үеэс эхлэн сэргэх шатанд орсон нь нэг талаас ОХУ дотоодын нийгэм, эдийн засгийн байдлаа тогтворжуулан, улмаар гадаад бодлогоо идэвхжүүлэх нөхцөл, боломж бүрдсэнтэй холбоотой. Нөгөө талаас Монголын уул уурхайн салбарт олон улсын хөрөнгө оруулагчдын сонирхол эрс нэмэгдсэн 2000 оны эхэн үед хоёр талын улс төрийн харилцаа идэвхижсэн нь Оросын талд Монгол дахь нөлөөний төлөөх тэмцэлд оролцох боломжийг олгосоны зэрэгцээ хоёр талын айлчлал, хэлэлцээр, уулзалтуудын үеэр хөндөгдсөн сэдвүүдээс харахад Монголын уул уурхайн салбарт давуу эрхтэй оролцох боломжийг эрэлхийлж байна.

2. Монголын төмөр зам дахь Оросын ашиг сонирхлыг Монголын талын ашиг сонирхолтой уялдуулан тэнцвэржүүлэх, цаашлаад шийдвэр гаргах болон төмөр замын

эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхэд Монголын талын оролцоог нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт татах, 1949 оны гэрээг шинэчлэх, төмөр замын техник, технологийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн хоёр улсын эрх ашгийн хүрээнд боловсронгуй болгох зайлшгүй шаардлага тулгарч байна.

3. Олон зуун жилийн харилцааны түүхэн сургамж, өнгөрсөн зууны социалист хөгжлийн хамтын түүх, улс төр болон хүн хоорондын нягт хэлхээ холбоон дээр суурилан хоёр улсын бие биеийн талаарх эерэг санаа бодлыг Монголын болон Оросын нийгэм, олон нийтийн дунд бататган, улмаар Оросын зүгээс Монголын талд ашигтай улс төрийн болон эдийн засгийн шийдвэр гаргах томоохон хүчин зүйл болох юм.

5. Бүс нутгийн эдийн засгийн интеграцчлалын хүрээнд хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд ОХУ-тай хийж буй Монгол Улсын худалдааны алдагдлыг багасгах, Оросын Алс Дорнод, Байгалийн бүсийн хөгжлийн хөтөлбөр болон Евразийн эдийн засгийн холбооны хүрээнд хил орчмын, бүс нутгийн хоорондын худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, ЕАЭХ-той Чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах замаар хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

6. Их гүрнүүдийн ашиг сонирхлын өрсөлдөөнийг эдийн засгийн харилцаандаа боломжийн хэрээр ашиглах арга замыг эрж хайснаар Монгол Улс хөрөнгө технологийн хомсдол, гарааны шатандаа байгаа уул уурхайн хөгжил, нөөц баялагийн ашиглалт, төмөр замын бүтээн байгуулалт төлөвлөсөн төвшинд хүргэхийн тулд Оросын Монгол дахь ашиг сонирхлыг бүх талаар нэмэгдүүлэх, стратегийн түншлэлийн дунд хугацааны хэрэгжилтийг хангах явдал туйлын чухал бөгөөд хоёр орны харилцаанд маш их боломж, хөгжлийн том орон зай бий.

7. Дэлхийн хүндийн хүчний төв Ази тивд шилжихийн хамт Монгол орныг тойрсон Орос, Хятадын эдийн засаг, цэрэг, улс төрийн хамтын ажиллагааны тэнхлэг улам нөлөөтэй болж байгаа өнөөгийн нөхцөлд хоёр талтай шууд хиллэсэн өргөн уудам зах зээлийг түшиглэх таатай боломж, ашигтай эдийн засгийн шийдвэр, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломж бүрийг алдалгүй ашиглах нь зүйтэй юм.

8. Орос-Хятадын харилцаа үлэмж өргөжиж байгаа нь Монголын эдийн засгийн дэд бүтцэд хүчтэй түлхэц болохын зэрэгцээ хоёр оронтой харилцаа, хамтын ажиллагаагаа иж бүрэн стратегийн түншлэлийн зэрэглэлд хүргэсэн нь эдийн засаг, худалдааны урт хугацааны тогтвортой харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж бий. Түүнчлэн гурван талт хамтын ажиллагааг ялангуяа дамжин өнгөрөх тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааг урагшлуулах хөшүүрэг болгон ашиглах боломжтой.

*Олон Улс Судлал №1 (110), 2020 он* *DOI: https://doi.org/10.5564/10.5564/jis.v1i110.1340*

# Монгол-Оросын улс төрийн харилцаа: Монголын эдийн засаг ба төмөр замын хөгжилд нөлөөлөх нь

***Адъяагийн Нямдолжин***

*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн ЭШТА, доктор /Ph.D/*
*Цахим хаяг: nyamdoljin@mas.as.mn*

***Хураангуй:*** *Монгол-Оросын орчин цагийн улс төрийн харилцааг дэлхийн улс төрийн байдалд гарсан огцом өөрчлөлт болон ЗХУ задарсан XX зууны 90-ээд оны эхэн үеэс эхлэн судалж, ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үед Монгол-Оросын харилцааг хоёр орны хооронд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрийг үндэслэн судлан шинжиллээ. 90-ээд онуудад Монгол-Оросын харилцаа сулран саарсан асуудлыг хоёр орны улс төр, эдийн засгийн байдал, гадаад бодлогод холбогдох үйл явц, өөрчлөлтийг үе шаттайгаар задлан үзэж, харилцааг зохих түвшинд хөгжүүлэхэд саад болсон хүчин зүйлүүдийг илрүүлэн судалсан болно. Монгол-Оросын харилцаа сэргэсэн үеийг 2000 оноор зааглан авч үзэж, эдүгээ иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хүрээд байгаа хоёр орны харилцаа, тус түвшинг илэрхийлэх хэмжээнд хүрэхгүй байгааг ОХУ-ын Монголын талаарх баримталж ирсэн бодлого хэр оновчтой байсан ба алдаа нь юунд байсныг судлахыг зорив.*

***Түлхүүр үгс:*** *Монгол, Оросын харилцаа, улс төр, эдийн засгийн харилцаа, ашиг сонирхол*

XX зууны 90-ээд оны эхээр дэлхийн улс төрийн байдалд гарсан огцом өөрчлөлтүүд, түүний дотор Монгол, Орос хоёр оронд өрнөсөн ардчилсан өөрчлөлтийн дүнд Монгол Улс болон ЗХУ-ын өвийг залгамжилсан ОХУ-ын хоорондын харилцаанд шинэ үе эхэлсэн юм. Энэ нь хоёр орон ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих ээдрээ төвөгтэй гараан дээр Монгол-Оросын харилцааг эрх тэгш, харилцан ашигтай байх, бие биеийн дотоод хэрэгт үл оролцох зарчимд тулгуурлан өөрчлөн хөгжүүлэхэд оршиж байв.

Монгол Улс ОХУ-тай олон жилийн түүхэн уламжлал бүхий хамтын ажиллагаан дээрээ тулгуурлан 1993 онд байгуулагдсан Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээгээр хоёр орны шинэ үеийн харилцааны эрх зүйн үндсийг тавьсан юм. 1993 оны гэрээ нь хоёр орны харилцааг агуулгын хувьд өөрчлөн, холбоотны харилцаанаас сайн хөршийн харилцаанд шилжиж байгааг нэг талаараа тодорхойлсон. Оросын монгол судлаач асан Г.С.Яскина тус гэрээ нь "төвийг сахисан, өөрөөр хэлбэл, Орос улс Монголыг гадаад бодлогынхоо бусад түнш орнуудтай эн тэнцүү түвшинд тавьсан"[1] гэжээ. Түүнээс гадна 1994 оны Монгол Улс, БНХАУ-ын хоорондын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг хугацаагүйгээр байгуулсан бол тус гэрээг цаашид сунгах боломжтой 20 жилийн хугацаатай байгуулсан байдаг. Хэдий тийм боловч ЗХУ задарсны дараа ОХУ бусад хил залгаа орнуудтай бүгдтэй нь ийм төрлийн гэрээ байгуулаагүй байсан бөгөөд ямартаа ч хоёр орны олон улсын харилцааны нийтлэг ёс зүйг шингээсэн шинэ зарчмуудыг төлөвшүүлэх хамтын чин эрмэлзэл шингэсэн гэрээ байсан хэмээн дүгнэх бүрэн боломжтой юм.

## Монгол-Оросын харилцааг зохих түвшинд хөгжүүлэхэд саад болсон хүчин зүйлүүд

ОХУ 1990-ээд оны шилжилтийн үед олон талын хүндрэл бэрхшээлтэй тулгарч, гадаад харилцаандаа Өрнөдийг түшиглэсэн чиг бодлогыг явуулан, дотооддоо эдийн засгийн хүчтэй хямралд нэрвэгдэж, улс төрийн хүрээнд нөлөө бүхий хэсэг бүлгийн сонирхлын үндсэн дээр засгийн эрхийн төлөө тэмцэл хурцдаж, санхүү, үйлдвэр худалдааны олигархийн эрх мэдэл хүчтэй болж, зохион байгуулалттай гэмт хэрэг газар авсан байна. Оросын улс төрийн байдал нэн тогтворгүй байсныг тус улсын засгийн газар энэ үед таван удаа солигдсон явдал харуулж байна. ОХУ гадаад бодлогын шинэчлэлээ хэрэгжүүлэхдээ гол төлөв Европ, Азийн их гүрнүүдэд хандаж, хил залгаа бага улс орнуудыг үл тоосон байдалтай байв. ОХУ-ын бусад улс орнуудад хийж байсан дээд хэмжээний айлчлалууд нь АНУ, Англи, Франц, Герман, БНХАУ, Япон, Солонгос гэх мэт өндөр хөгжилтэй орнууд руу

1 Г.С.Яскина. Монголия: смена модели развития. Политические и экономические реформы. М.: ИВРАН, 1994. С.35

чиглэж байв. Тухайлбал, ОХУ-ын ГХЯ-ны сайд Е.Примаков 1996 онд Монгол Улсад айлчилснаас өөрөөр Ерөнхийлөгч Б.Ельцин, Ерөнхий сайд В.Черномырдин нар Монголд айлчлах айлчлалаа хэрэгжүүлээгүй билээ. 1990 оноос хойш арваад жил Оросын удирдлагын Монголтой хүйтэн хөндий харьцаж ирсэн нэг шалтгаан бол социализмын өнгөрсөн түүхтэй холбоотой бүхнээс зайлсхийхийг эрмэлзэж байсантай холбоотой.[2] Түүнчлэн 1990 онд Монгол Улсад явагдсан анхны чөлөөт ардчилсан сонгуулиар (үзэл суртлаас ангид, шинэчлэгдэн өөрчлөгдсөн) МАХН ялалт байгуулан засгийн эрхийг барих болсон нь мөн нөлөөлсөн. Харин Монголын гадаад бодлогод Оросын хүчин зүйл илүү ач холбогдолтой, үүрэг нөлөөтэй байсан нь Монгол-Оросын хооронд дээд хэмжээний айлчлалын урсгал Монголын талаас голлон нэг чиглэлтэй байсан явдал харуулж байна.

Монгол Улсын хувьд улс төр, үзэл суртлын хамаарлаас ангижирч, улс төрийн талаар бие даан шийдвэр гаргах болсон ба өөр бусад хүчин зүйлс тухайлбал, ид хүчээ аваад байсан үндсэрхэг үзэл, оросуудын эсрэг уур амьсгал ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжсэн эхний жилүүдэд хүчтэй мэдрэгдэж байлаа. Ялангуяа Монголын аж үйлдвэрүүд дэх Зөвлөлтийн техник, технологийн давамгайлал хэн бүхний нүдэнд ил байсаар атал монголчууд үндсэрхэх үзлээ оросуудад илэрхийлж байсан үед Монголын Засгийн газраас Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг эргүүлэн татахыг шаардан, түүнийгээ хэрэгжүүлэн алдаа гаргаж байв. Түүнчлэн Монголын зүгээс ЗХУ-ыг залгамжилсан гэдэг үүднээс ОХУ-тай харилцах харилцаанд идэвхгүй хандаж байсан тал ажиглагддаг. Энэхүү байдал нь олон арван жилийн туршид бүрэлдэн тогтсон хамтын ажиллагааны харилцан ашигтай олон чиглэл, хэлбэрийг алдагдуулахад хүргэж, Орос улстай урьдын харилцаагаа сулруулах нэг хүчин зүйл болсон юм. Ийнхүү Монгол, Оросын харилцаа 90-ээд оны эхээр асар хумигдан, зарим харилцааг сэргээх бус бүр шинээр байгуулах хүртлээ буурсан юм.

1994 оны 11-р сард Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй Монголын парламентын төлөөлөгчид ОХУ-д айлчлах үеэр Монгол Улсын Их хурал, ОХУ-ын Төрийн Думын хооронд хамтран ажиллах тухай санамж бичиг болон хоёр талын Парламентын бүлгүүдийн хоорондын хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурсан нь хоёр улсын хууль тогтоох байгууллага-парламент хоорондын харилцааны суурийг тавьж, цаашид хөгжих эрх зүйн орчин бүрэлдэхэд таатай нөхцөл бүрдүүлсэн юм. 1995 онд Монгол Улсын Ерөнхий сайд П.Жасрайн Москвад хийсэн айлчлалын явцад "Монгол Улс ба ОХУ-ын хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Протокол"-д гарын үсэг зурсан.

90-ээд оны хоёрдугаар хагаст Монгол-Оросын хамтын ажиллагааг

2 В.А.Родионов. Политический процесс в Монголии в условиях постсоциалистической трансформации. Улан-Удэ. 2018. Стр. 225

өмнөх үеийн уналтын түвшинээс бага зэргийн хэлбэлзэлтэй тогтонги байдалд орсон гэж үзэж болохоор байлаа. Энэ нь 1996 онд Гадаад хэргийн сайдаар Е.М.Примаков томилогдсоноор Оросын гадаад бодлого, дипломат ажиллагаанд томоохон өөрчлөлт шинэчлэлтийг хийж эхэлсэнтэй холбоотой бөгөөд барууны улс төрчид, эрдэмтэд Оросын гадаад бодлогын нэгэн үе төгсгөл боллоо хэмээн хүлээн авсан юм. Оросын удирдлага социалист системийн үеийн холбоотон байсан улс орнуудтай харилцаа хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх нь зүйтэй юм гэж үзэх болов. Энэхүү Оросын гадаад бодлогын шинэ чиг шугам хоёр орны харилцаанд ч нөлөөлсөн. 1996 оны намар ОХУ-ын ГХЯ-ны тэргүүн Е.М.Примаковын Азийн гурван оронд хийсэн айлчлалын нэг нь Монголд байсан нь санамсаргүй хэрэг биш байв. Тус айлчлалын үеэр гарын үсэг зурсан Монгол-Оросын албан ёсны мэдээнд талууд хоёр талын харилцааны гэрээ эрх зүйн үндсийг цаашид шинэчлэн батлах сонирхолтой байгаагаа баталсан байна[3].

1995 онд ОХУ-ын Төрийн Думын дарга А.Венгеровский тэргүүтэй төлөөлөгчид, 1996 онд ОХУ-ын Төрийн Думын дарга Г.Селезнёв тэргүүтэй Төрийн Думын төлөөлөгчид, С.К.Шойгугийн ахалсан Онцгой байдлын комиссын төлөөлөгчид Монгол Улсад тус тус айлчилжээ. 1999 онд ОХУ-ын ГХЯ-ны сайд И.Иванов Монгол Улсад айлчлав. Эдгээр айлчлалуудын үр дүнд Монгол-Оросын хамтарсан үйлдвэрүүдийн цаашдын асуудал, Монголын бүтээгдэхүүнд оногдуулж байгаа Оросын гаалийн өндөр татвар, Монголын нутаг дэвсгэр дээрх Оросын өмчийн асуудал зэрэг хоёр орны харилцааны тулгамдсан асуудлуудаар яриа хэлцэл өрнүүлж байв.

Монгол дахь Оросын эдийн засгийн сонирхлыг урагшлуулахад саад болсон хүчин зүйл бол Оросын Монголын талаарх алдаатай стратегийн бодлоготой нь холбоотой. Энэ нь нэгдүгээрт, Орос улс Монголын улс төрийн орон зайг “Оросын талыг баримтлагчид” буюу МАХН болон “барууныхныг баримтлагчид” буюу Ардчилсан нам гэсэн улс төрийн хүчнүүдэд хуваагдсан гэж үзсэн учир МАХН-ыг бүх талаар дэмжихийг хичээж байв. Хоёрдугаарт, Энэ тооцооллоос улбаалан Монгол, Оросын улс төрийн харилцааны өндөр дээд түвшин болоод хоёр орны төрийн тэргүүнүүдийн хувийн харилцан итгэсэн харилцаан дээр тулгуурлан Монгол дахь Оросын эдийн засгийн ашиг сонирхол, юуны өмнө хамгийн ирээдүйтэй салбар болох уул уурхайн салбар дахь Оросын оролцоог баталгаажуулна гэж үзсэн. Энэхүү төөрөгдөл нь Монголын парламентын болон ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр оросын албаны хүмүүс МАХН-ыг нээлттэй дэмжсэнээр илэрч байв. Оросын Засгийн газрын МАХН/МАН-д хандах хандлага нь дараах шалтгаанаар тайлбарлагдана. Үүнд: Монголд бараг монополь эрхтэйгээр төр барьж байсан МАХН-ын үед хоёр талын харилцан ойлголцол

3 А.Нямдолжин. Монголо-Российские отношения на современном этапе. УБ. 2016. Стр. 31

нэмэгдсэн. Тухайлбал, 2000-2004 онд УИХ-д 76 суудлаас 72 суудлыг МАХН-аас нэр дэвшсэн гишүүд эзэлж, Ерөнхийлөгч болон Ерөнхий сайд ч тус намын төлөөлөгчид байв. Тухайлбал, 2008 онд ОХУ-ын Төрийн Думын депутат, олон улсын асуудал эрхэлсэн хорооны гишүүн Р.Кондратов Монголд айлчлах үеэр удахгүй болох парламентын сонгуульд МАХН/МАН-ыг дэмжиж байгаа тухайгаа мэдэгдсэн. Түүнчлэн 2009 оны Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшсэн Ц.Элбэгдорж сонгуульд ялалт байгуулсан бөгөөд МАХН-аас нэр дэвшсэн Н.Энхбаярыг В.Путин 2009 оны 5-р сард Монгол Улсад айлчлах үеэр дэмжсэн явдал Оросын удирдлагын алдаатай бодлогын нэг илрэл байв. Үнэн хэрэг дээрээ Монголын төр, нийгмийн зүтгэлтнүүдийн ихэнх нь тэдний намын харъяалал, улс төрийн үзэл баримтлалаас нь үл хамааран Орос, Хятад, Барууны орнуудыг түшиглэсэн олон талт гадаад бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрдөг ба чингэхдээ хүчний төвүүдийн алийг нь ч онцлодоггүй. Иймээс Оросын Засгийн газар зөвхөн МАХН-ыг дэмжиж байгаа нь Монголын дотоод улс төрийн байдал өөрчлөгдөн буй нөхцөлд алсын хараагүй бодлого явуулж буйг харуулж байна.

## Монгол-Оросын харилцаа сэргэсэн нь

Монгол-Оросын харилцааны 1991-1999 онуудын саарал, зогсонги байдлыг гэтлэн давж, шинэ шатанд гарган хөгжүүлэх чухал үйл явдал бол 2000 оны 11-р сарын 13-14-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал байв. ЗХУ-ын төрийн тэргүүн Л.Брежнев 1974 онд БНМАУ-д айлчилснаас хойш 26 жилийн дараа их гүрнийг албан ёсоор залгамжилсан ОХУ-ын төрийн тэргүүний Монгол Улсад хийсэн анхны айлчлал байлаа. Энэ утгаараа В.Путины айлчлал Монголчуудын хувьд удаан хүлээсэн, онцгой үйл явдал болсон юм. Тус айлчлалын үеэр В.Путин цаг үеийн сорилтыг давсан Монгол-Оросын сайн хөршийн харилцааг харилцан туслах хамтран ажиллах олон жилийн бат зузаан уламжлалын үндсэн дээр сэргээн хөгжүүлэх шийдвэр төгс байгааг илэрхийлэн "Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд Монгол Улс онцгой байр эзэлдэг"[4] гэж мэдэгдсэн. Энэ нь Орос улс Монгол дахь уламжлалт нөлөө, байр суурь дээрээ түшиглэн 1990-ээд онд сул байх үедээ алдсан орон зайгаа аажмаар нөхөх, бүс нутаг дахь ашиг сонирхлоо бэхжүүлэхэд чиглэсэн стратегийн сэтгэлгээ нь эргэн сэргэж байгаагийн илэрхийлэл болж байв. Айлчлалын үеэр талууд "Улаанбаатарын тунхаглал"-ыг

4 Выступление перед депутатами Великого государственного хурала Монголии. / http://kremlin.ru/events/president/transcripts/21133

баталсан нь шинэ зуунд Монгол Оросын харилцааг шинэ шатанд гаргаж, бүх талаар хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, харилцан ашигтай хамтын ажиллагааны улс төрийн үндэс суурийг тавьж өгсөн юм. Тунхаглалд хоёр талын хийгээд бүс нутгийн аюулгүй байдлын асуудлууд онцгой байр суурь эзэлсэн бөгөөд энэ үүднээсээ нэлээд хөтөлбөржсөн шинжтэй болсон байв. Ерөнхийлөгч В.Путиныг Буриад болон Тувагийн Ерөнхийлөгчид, Эрхүү мужийн Амбан захирагч нар дагалдсан нь хил орчмын хамтын ажиллагааг хөгжүүлэх, ингэснээрээ Монголыг ямар нэг юмтай холбох, интеграцчлах санаа агуулагдаж байгаа нь илэрхий байв. Тунхаглалын 23-р зүйлд нэгэн онцгой заалт бий. Түүнд " Оросын тал олон улсын өргөн хамтын ажиллагааны нээлттэй байгууллага болох Шанхайн Чуулга уулзалтын зорилго, зорилт, үйл ажиллагааны тухай Монголын талд мэдээлэв. Монголын тал Чуулга уулзалтын үйл ажиллагааг сонирхон, ямар нэгэн хэлбэрээр түүнд оролцох боломжийг судалж үзэхээ мэдэгдэв"[5] гэсэн байдаг. Үүнээс харахад Монгол Улсыг Шанхайн бүлэглэлд оруулах сонирхолтой байгаагаа 2000 оноос эхлэн илэрхийлж байжээ.

1990-ээд оноос хоёр улсын Засгийн газрын тэргүүнүүдийн хэмжээнд яригдаж, тохиролцсон зарчмуудыг үндэслэн ОХУ-ын Монголын зах зээлд нэвтрэх, уул, уурхайн салбарт давуу байр суурь олж авахын тулд өрийг чөлөөлж хөрөнгө оруулдаг дэлхий нийтийн жишгийн дагуу Их өрийн асуудлыг шийдвэрлэсэн. Ингэхдээ 2003 онд БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол Улсад айлчлан, "сайн хөршийн, харилцан итгэсэн түншлэл"-ийн харилцаа тогтоож, юуны өмнө уул уурхайн салбарт "эдийн засгийн харилцааг эрчимтэй хөгжүүлэх"-ээр болж, 300 сая ам.долларын зээл олгох амлалттай Орос улс бараг зэрэгцэн Монгол Улсын Их өрийг хүчингүй болгов. Үүнийг их өрийг тэглэх гадаад хүчин зүйл гэж харж болох юм. Ямар ч юманд өөрийн үнэ цэнэ гэж байдаг учир Монгол Улс 2004 онд Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад ажиглагчаар элссэн.

2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д албан ёсны айлчлал хийж, "Москвагийн тунхаглал"-д гарын үсэг зурсан ба тус тунхаглалд Монгол Улс, ОХУ ойрын жилүүдэд хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн шинж чанартай болгож, цар хүрээг нь тууштай нэмэгдүүлж, агуулгыг баяжуулж үр ашгийг нь дээшлүүлэх замаар илүү өндөр, чанарын шинэ шатанд гаргана хэмээн тохиролцсон.

5 Монгол-Оросын харилцаа баримт бичгийн эмхэтгэл. УБ. 2006. 166-р тал.

## Монголд оролцоогоо нэмэгдүүлэх Оросын талын сонирхол нэмэгдсэн нь

2008 он гарсаар Монголын улс төр дэх Оросын оролцоо илт мэдрэгдэж эхэлсэн. Тухайлбал, 2009 онд ОХУ-ын Ерөнхий сайд В.Путин айлчилснаас ердөө гурав хүрэхгүй сарын дараа ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев Монголд айлчилсан нь Оросын тал Монгол дахь нөлөөгөө дахин сэргээх, Монголын орд газруудад уран олборлох Оросын сонирхол нэмэгдсэнтэй холбоотой юм. Тухайлбал, айлчлалын үеэр хоёр орны хооронд "Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай Тунхаглал"-д гарын үсэг зурсан ба энэ үеэр байгуулсан гэрээ хэлэлцээр, баримт бичгүүдээс "Цөмийн эрчим хүч, уран олборлолтын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр", "Дорнод уран" хамтарсан үйлдвэр байгуулах тухай хэлэлцээрийг онцлон дурдаж болно. Гэвч Монголын ураны орд газрын лиценз Канад, Хятад гэх зэрэг орнуудын мэдэлд байгаад Оросууд эмзэглэж, Монголын Засгийн газартай хамтран нөхцөл байдлыг өөрт ашигтайгаар эргүүлж, энэхүү төсөлд давуу эрхтэй оролцохыг чухалчилж байв.

2019 оны 9-р сарын 3-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр орны хооронд "Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээ"-г хугацаагүйгээр байгуулснаар хоёр улсын харилцааны хүрч болох хамгийн дээд түвшний харилцаанд хүрэв. 2014 онд Монгол, Хятад хоёр улс харилцаагаа "Иж бүрэн стратегийн түншлэл"-ийн харилцаанд шилжүүлэн хөгжүүлэх болсноор түншлэлийн харилцааны хамгийн өндөр түвшинд хүрээд байсан. Нөгөө талаас Монгол Улсын "Гадаад бодлогын үзэл баримтлал"-д "ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад бодлогын эн тэргүүний зорилт мөн бөгөөд эдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ"[6] гэж тунхагласан байдаг. Эндээс харахад ч тэр Монгол-Оросын харилцаа, Монгол-Хятадын харилцааны түвшинээс хоцорч байсан бол одоо хоёр хөрштэйгөө хоёулантай нь иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай болж байна.

Түүнчлэн 2009 оны ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев Халхын голын байлдааны ялалтын 70 жилийн ойгоор, 2014 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Халхын голын байлдааны ялалтын 75 жилийн ойгоор, 2019 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд тус ойг тэмдэглэхээр Монгол Улсад айлчилж байгаагаас харахад тэрхүү дайнд Орос улс гол үүрэгтэй оролцож, Монголчуудыг хамгаалан, Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолыг бататгахад чухал үүрэг гүйцэтгэсэн

6 Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. https://www.legalinfo.mn/annex/details/3362?lawid=6340

гэдгээ давхар сануулахын зэрэгцээ хүнд үед хамтарч чаддаг улс, мөн цаашид ч хамтран ажиллахад саад болох зүйлгүй бөгөөд цаг хугацааны сорилтоор шалгагдсан хоёр орны хоорондын уламжлалт харилцаа хэвээр хадгалагдан үлдсэн гэдгийг харуулсан айлчлалууд байсан хэмээн дүгнэж болохоор байна. Халх голын байлдааны ялалтын ойн арга хэмжээ нь хоёр орны улс төрийн харилцааг тодорхойлох нэг чухал үйл явдал болох нь эндээс харагдаж байна.

Ерөнхийлөгч В.Путины 2019 оны 9-р сарын 3-нд Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал нь прагматик шинжтэй байж, хоёр улсын Ерөнхийлөгч нар ажил хэрэгч хэлэлцээр хийж, Монгол-Оросын харилцааг урагшлуулан хөгжүүлэх асуудлаар саналаа солилцсон. Ерөнхийлөгч В.Путиныг дагалдан тус улсын Гадаад хэргийн сайд С.Лавров, Ерөнхий сайдын орлогч А.Гордеев, Эрчим хүчний сайд А.Новак, Батлан хамгаалахын дэд сайд А.Фомин, төмөр замын РЖД нэгтгэлийн тэргүүн О.Белозеров, Оросын Шууд хөрөнгө оруулалтын сангийн тэргүүн К.Дмитриев, «Роснефть»-ийн тэргүүн И.Сечин зэрэг бизнесийн хүрээний төлөөлөл дагалдсан нь айлчлалын ажил хэрэгч чанар, түвшинг тодорхойлж байна. Айлчлалын үеэр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх Засгийн газар, яамд хоорондын нийт 10 баримт бичигт гарын үсэг зурсны дийлэнх нь эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсний зэрэгцээ уламжлалаа сэргээж уул уурхайн салбарт хайгуулын чиглэлээр хамтран ажиллахаар болов.

алдсан газар нутгийн нилээд хэсгийг эргүүлэн авч чадсанаар Карабахын дайны ялагч боллоо. Хэлэлцээрийн дагуу Армени 1992-1994 оны Карабахын дайны үеэр булааж авсан Агдам, Лачин и Кельбажарын районуудыг үе шаттайгаар Азербайжанд эргүүлэн өгөхөөр болов. Дөчин дөрвөн өдөр үргэлжилсэн Уулын Карабахын төлөөх дайнд Армений тал 2425, Азербайжаны тал 3000, Карабахын 1500 цэргийн албан хаагч, 4000 гаруй энгийн иргэд амиа алдаж, 8000 гаруй хүн шархдаж, хэдэн зуун хүн сурагтүй алга болж, олон мянган хүн дүрвэж, хот, суурин, дэд бүтэц эвдэрч сүйрэн их хэмжээний гарз хохирол амсаад байгаа юм.

Армен, Азербайжан хоёр Карабахд цэрэг дайны үйл ажиллагааг дахин эхлүүлэхгүй байх энх тайван, тогтвортой байдлыг хангах нэг баталгаа нь одоогийн байдлаар тус бүсэд энхийг сахиулагчдыг байрлуулах явдал юм. Арваннэгдүгээр сарын 10-ны орой гэхэд Оросын 200 гаруй цэргийн албан хаагчид Карабахд байлдааны үйл ажиллагаа болон гал зогсооход хяналт тавих зорилгоор хүрэлцэн ирсэн бөгөөд нийт 1960 цэргийн албан хаагч, 90 хуягт техник, 380 нэгж тусгай техникийн хамт таван жилийн хугацаатай, мөн таван жилийн хугацаагаар сунгагдах боломжтойгоор байрлах болов. Энхийг сахиулах үйл ажиллагаанд Оросын талаас чамгүй мөнгө зарцуулагдана. Түүнээс гадна, Азербайжаны ерөнхийлөгч Алиев Орос-Турк хамтран энхийг сахиулах тухай дурдсан явдал Азербайжанд Туркийн байр сууръ, өөлөө хэрхэн нэмэгдэж байгааг харуулж байна.

Таван жилийн дараа энхийг сахиулах ажиллагаа дууссаны дараа Азербайжан "Уулын Карабах"-ыг бүрэн эрхшээлдээ оруулахыг хүсвэл яах вэ? Орос улс энэ бүс нутагт байгаа статус-квогоо хадгалж чадах болов уу? Армениийн нийгэмд хариу авах сэдэл төрөхийг ч үгүйсгэхгүй гэх мэт олон асуулт хэвээр үлдэж байна.

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭН

# ОЛОН УЛС СУДЛАЛ - 2021: МОНГОЛЫН ОРОС СУДЛАЛ

*ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ*

Улаанбаатар
2022 он

# ГАРЧИГ

Товчилсон үгс . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 5

Өмнөх үг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 7

"Олон улс судлал 2021: Монголын Орос судлал" эрдэм шинжилгээний хурлыг нээж, ШУА-ийн Дэд ерөнхийлөгч, академич Г.Чулуунбаатарын хэлсэн үг . . . . . . . . . . . . . . . . . . . . . 11

## ОЛОН УЛС СУДЛАЛ - 2021: МОНГОЛЫН ОРОС СУДЛАЛ

*Д.Алтай* Монгол Улс дахь Орос судлалын өнөөгийн байдал, цаашдын зорилт. . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 13

*О.Батсайхан* Монголын Орос судлалд тулгарч буй асуудлууд . . . . . . . . . . . . . 27

*А.Нямдолжин* ОХУ-аас Монгол Улсын талаар баримталж буй бодлогын зарим шинэ хандлага: Оросын монгол судлаачдын судалгааны үр дүнгээс . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 31

*Г.Өнөржаргал* ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын стратеги . . . . . . . . . . . . 41

*Д.Бадрал* ОХУ ба барууны орнуудын харилцаа: АНУ, Европын холбооноос ОХУ-ын эсрэг хэрэгжүүлсэн хориг арга хэмжээ, үр дагавар . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 51

*А.Даваасүрэн* Монгол-Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны онцлог шинж чанарууд (1990-2020 он) . . . . . . . . . 61

*Т.Мөнх-Оргил*, *Д.Батбаяр* ОХУ ба Монгол Улсын батлан хамгаалах харилцааны зарим асуудалд . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 78

*Н.Хүдэрбат*, *Ц.Бямба-Эрдэнэ* Орос Улсаас Монголын нисэх хүчний салбарыг хөгжүүлэхэд үзүүлсэн тусламжийн тухайд (1925-2021 ) . . . . . . . . . . . . . . . . 88

*Х.Орхончимэг* Монгол Улсад байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн ангиудыг гаргахтай холбогдох зарим баримт. . . . . . . . . . . . . . . . 95

*Т.Сайнжаргал* Архивын салбарт хамтран ажиллах Монгол-Оросын хамтарсан комиссын үйл ажиллагааны тухайд . . . . . . . . . . . . 100

Хэлэлцүүлэг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 107

## МОНГОЛ УЛС, ОХУ-ЫН ХООРОНД ДИПЛОМАТ ХАРИЛЦАА ТОГТООСНЫ 100 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛАН 2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 02-НЫ ӨДӨР ГХЯ-НД ЗОХИОН БАЙГУУЛСАН "МОНГОЛ-ОРОСЫН ХАРИЛЦАА: ТҮҮХ, ОРЧИН ҮЕ БА ХЭТИЙН ТӨЛӨВ" СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ


ОХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны элчин зөвлөх Сергей Анатольевич Краминцевийн хэлсэн үг . . . . . . . 110

Выступление советника-посланника посольства Российской Федерации в Монголии С.А.Краминцева на научной концеренции, посвященной 100 летию установления дипломатических отношений между Россией и Монголией . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 115

*В.В.Кильпякова* Улаанбаатар дахь Русский Дом нь ардын дипломат хөтөч мөн . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 120

*В.В.Кильпякова* Русский Дом в Улан-Баторе - проводник народной дипломатии . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 126

*О.Батсайхан* Монгол-Зөвлөлтийн 1921 оны гэрээ: Түүх ба баримт. . . . . . . . 132

*А.Нямдолжин* Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ОХУ-ын гүйцэтгэх үүрэг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 143

*Ц.Батбаяр*, *Г.Баттүшиг* Монгол-Зөвлөлтийн худалдаа: Хөгжил, төлөвшлийн асуудлууд (1921-1930 он) . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 149

*Ч.Батдорж* ЗХУ-ын ШУА-ийн "Монголын комисс"-ын Монгол дахь үйл ажиллагаа . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 160

Хэлэлцүүлэг . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . . 188

# ОХУ-ААС МОНГОЛ УЛСЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ЗАРИМ ШИНЭ ХАНДЛАГА: ОРОСЫН МОНГОЛ СУДЛААЧДЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

А.НЯМДОЛЖИН
*Доктор (Ph.D)*
*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн*
*Орос судлалын салбарын эрхлэгч,*
*Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан*

Монголын талаар баримтлаж буй ОХУ-ын бодлого улс төр дипломатын хувьд хуучин ЗХУ-ын үеийнх шиг хүчтэй бодлого явуулахгүй ч Оросын байр суурь, түүхэн уламжлалт бодлого өөрчлөгдөхгүй, улс төр, эдийн засгийн тодорхой нөлөөгөө хадгалахыг зорьж байна. Оросын гадаад бодлогын баримт бичгүүдэд Монголын талаар баримтлах бодлого бүрхэг явж ирсэн. Учир нь ОХУ 1993 оноос хойш Гадаад бодлогын үзэл баримтлалаа зургаан удаа өөрчилж, шинэчлэн баталсан.

Оросын Монголын талаар баримтлах түүхэн уламжлалт бодлого өөрчлөгдөөгүй боловч Оросын гадаад бодлогын баримт бичгүүдэд Монголын талаар баримтлах бодлого бүрхэг явж ирсэн төдийгүй ОХУ-ын Гадаад бодлогын үзэл баримтлалын өмнөх 3 баримт бичигт Монголын талаар огт дурдаагүй бөгөөд 2013 оны 2-р сарын 13-нд шинэчилэн баталсан Гадаад бодлогын үзэл баримтлалын "Бүс нутгийн чиглэл" хэмээх зүйлд "Монгол Улстай уламжлалт нөхөрсөг харилцаагаа бэхжүүлэхийг зорино" гэж тусгажээ[1]. Энэ нь Монголыг геостратегийн эрх ашгийн хүрээндээ багтаан үзэж, хил залгаа, удаан жил өөрийн нөлөөнд байсан Монголыг анхаарлаасаа гаргахгүй гэсэн санаа агуулагдаж байна. Нөгөөтэйгүүр 2000 оноос хойшхи үеийн Оросын улс төрийн харилцааны идэвхижилт нь Оросын талд Монгол дахь нөлөөний төлөөх тэмцэлд оролцох боломжийг олгосон юм.

Эндээс үзэхэд ОХУ-ын Монгол Улсын талаар баримталж буй бодлого нь түүний геостратеги, гадаад бодлогын чиглэлээр тодорхойлогдож байна. Учир нь 1990-ээд онд хоёр орон ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих шилжилтийн үеийн олон талын хүндрэл бэрхшээлтэй тулгарч байсан ч ОХУ-ын Атлантизмын бодлого буюу Өрнөдийг түшиглэсэн чиг бодлого баримталж байсантай холбоотойгоор хоёр орны харилцаа сулран саарсан. Харин 2000 онд ОХУ-ын Ерөнхийлөгчөөр В.Путин сонгогдсоноос хойш Оросын гадаад бодлогын чиглэлд

---

1 Приоритеты Российской Федерации в решении глобальных проблем. Концепция внешней политики Российской Федерации. http://mid.ru/bdomp/ns-osndoc.nsf/e2f289bea62097f9c325787a0034c255/c32577ca0017434944257b160051bf7f!OpenDocument

өөрчлөлт гарч, Монголын талаар баримтлах бодлого нь Оросын Ази руу чиглэсэн бодлогоор тодорхой болсон гэхэд болно. ОХУ-ын Алс Дорнодын бүс нутаг төвөөсөө алслагдсан учир тэдгээрийг хил залгаа орнуудын хөрөнгө оруулалтыг татах замаар, мөн тухайн улс орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцааг хөгжүүлэх бодлого баримтлах болсон. 2018 оны ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины зарлигаар Монгол Улстай хил залгаа орших Буриадын БНУ, Ар Байгалийн хязгаарыг Алс Дорнодын субъектын харъяанд оруулсан. Тэгэхээр Алс Дорнодын Холбооны тойрог нь хуурай газраар Монгол, Хятад, Хойд Солонгостой хиллэх болж байна. Ийнхүү Байгаль нуур орчмын мужуудыг Монгол Улстай харилцаа тогтоох замаар хөгжүүлэхийн зэрэгцээ ОХУ Монгол Улсын төдийлөн сайн хөгжөөгүй эрчим хүчний салбар хийгээд Хятад руу Монголын нутгаар дамжуулан байгалын хийн хоолой тавих асуудал шийдэгдвэл Орос улс Сибирь, Алс Дорнодын бүс нутгаа мөн байгалийн хийгээр хангах асуудлаа илүү хялбар шийдвэрлэх боломжтой болж байна.

Монгол Улсын хувьд 1990-ээд онд гадаад бодлогодоо үндэсний ашиг сонирхлоо дээдлэх, хөрш Орос, Хятад хоёр оронтой тэнцвэртэй харилцах, гадаад харилцаагаа өргөтгөн олон түнштэй болох, гуравдагч хөршийн бодлого явуулах, бүс нутгийн интеграцид оролцож, өөрийн орон зайтай болох, олон улсын хамтын хүчин чармайлтыг дэмжих зэрэг асуудлуудыг Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалуудаа тусгаж мөрдөх болсон. Дээрх бодлогыг явуулахдаа Монгол Улс хүчирхэг нэг гүрний ивээлд байж, бодлогыг нь дагах замаар аюулгүй байдлаа хангах бус, харин бүх улс оронтой найрсаг харилцаа хөгжүүлж, идэвхтэй гадаад бодлого явуулах, улс төр, дипломатын аргаар ханган бэхжүүлэх, өөрийн аюулгүй байдлыг бүс нутгийн аюулгүй байдалтай нягт холбох чиглэл баримтлах болсон.

Монголын талаарх Оросын судлаачдын байр суурийг авч үзвэл Монгол Улс нь Оросын Дорныг чиглэсэн гадаад бодлогын нэг чухал хэсэг тул стратегийн чухал ач холбогдолтой.

Монголын талаарх судалгаа ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэн, Алс Дорнодын хүрээлэн, Стратегийн судалгааны хүрээлэн, ШУА-ийн Сибирийн салбарын Монгол, Будда, Төвд судлалын хүрээлэн, Эрхүүгийн Улсын их сургууль, Буриадын улсын их сургууль болон бусад их, дээд сургуулиуд дээр зангидагдан хөгжиж байдаг. Монголын талаарх судалгаа монгол судлаач, эрдэмтэн Г.С.Яскина, В.В.Грайворонский, М.И.Гольман, Е.В.Бойкова, С.Г.Лузянин, А.С.Железняков, Б.В.Базаров, В.А.Родионов, Ю.В.Кузьмин болон бусад эрдэмтэн судлаачдын бүтээлүүдэд тусгалаа олсон байдаг.

## Монголын гадаад бодлогын талаар

Монголын гадаад бодлогын талаарх асуудал Оросын эрдэмтдийн судалгаанд ихээхэн ач холбогдолтой сэдэв юм. Оросын улс төр судлаачид, олон улс судлалынхан, шинжээчид болон үндэсний аюулгүй байдлын мэргэжилтнүүд

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын болон Гадаад бодлогын үзэл баримтлалууд, түүнчлэн хоёр орны хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийг анхааралтай судлан, түүний агуулга амьдралд аль хэр ойр, бодитой хийгээд ялангуяа цаашдын ирээдүйд Орос улсын ашиг сонирхолд нийцэж буй эсэхийг анхааралтай судлан үздэг.

Монгол Улсын гадаад бодлогын асуудалд монголч эрдэмтэн асан **Г.С.Яскинагийн**[2] **"Монгол ба гадаад ертөнц"**[3] бүтээлийг дурдах хэрэгтэй. Тус номонд Монгол улс Орос, Америк, Хятад, Япон зэрэг орнуудаас гадна Ази, Европын бусад орнуудтай хэрхэн харилцаж байгаад анхаарч, үнэлэлт дүгнэлт гаргасан байдаг. Монгол-Орос, Монгол-Хятадын харилцааны ээдрээтэй асуудлуудад архивын шинэ материалуудыг ашиглан дүгнэлт хийсэн. Тэрээр 1990-ээд оноос хойших Монголын гадаад харилцааг дүгнэхдээ: "*Монгол орон өөрийгөө гадаадад нээж өгсөн. Монгол шиг хөгжиж байгаа орон ардчилалд амжилттай шилжихэд гадаад орчны хандлага (гадны санхүү, эд материал, цэргийн тусламжууд) ихээхэн нөлөөлсөн гэж дүгнэсэн байна. Монгол Улс өөрөө эдийн засагтаа шинэчлэл хийж, зах зээл рүү шилжиж, үндэсний эдийн засгаа либералчилж, гадаадад нээлттэй болгож хамтын ажиллагаагаа хөгжүүлсэн нь ихээхэн үр дүнгээ өгч байна... Монгол Улс гадаад ертөнцөд нээлттэй байх нь алхам алхмаар, аажмаар явагдах ёстой бөгөөд ингэснээр энэ үйл явцыг удирдан зохион байгуулах, үндэсний ашиг сонирхлыг бизнесийн ашиг сонирхолтой уялдуулах, дэлхийн улс орнуудтай гадаад бодлого, бусад харилцааны онцлогийг харгалзан үзэх цорын ганц арга зам юм.*"[4] гэжээ. Мөн тэрээр Монгол, Оросын 1993 оны "Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай" гэрээний талаар дурдахдаа: "Төвийг сахисан, өөрөөр хэлбэл, Орос улс Монголыг гадаад бодлогынхоо бусад түнш орнуудтай эн тэнцүү түвшинд тавьсан" хэмээсэн бол О.А.Джагаев: "1994 оны Монгол Улс, БНХАУ-ын хоорондын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг хугацаагүйгээр байгуулсан бол Монгол, Оросын 1993 оны гэрээг цаашид сунгах боломжтой 20 жилийн хугацаатай байгуулсан байдаг"[5] хэмээжээ. Хэдий тийм боловч ЗХУ задарсны дараа ОХУ бусад хил залгаа орнуудтай бүгдтэй нь ийм төрлийн гэрээ байгуулаагүй байсан

ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн монгол судлаач **В.В.Грайворонскийн**[6] туурвисан "***Реформы в социальной сфере современной Монголии***" (Орчин үеийн Монголын нийгмийн өөрчлөлт), "***Изменения в уровне жизни населения Бурятии (Россия), Монголии и Внутренней Монголии (Китай) в конце XX – начале XXI вв***" (ОХУ-ын Буриад, Монгол Улс, БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах орны хүн амын амьдралын түвшинд гарсан өөрчлөлт), "***Монголия в начале XXI в. (политика, экономика, общество)***" (XXI зууны эхэн

2 Г.С.Яскина. ОХУ-ын ШУА-ийн Дорно Дахины хүрээлэнгийн монгол судлаач асан.
3 М. ИВРАН. 2002.
4 Г.С.Яскина. Монголия и внешний мир. М. ИВРАН. 2002. С. 75
5 О.А.Джагаев. Россия и Монголия: очерк истории взаимоотношений. С.61
6 В.В.Грайворонский. ОХУ-ын ШУА-ийн Дорно Дахины хүрээлэнгийн монгол судлаач.

үеийн Монгол Улс: улс төр, эдийн засаг, нийгэм) нэг сэдэвт зохиолуудаа Монголын улс төрийн тогтолцоо, нийгэм, эдийн засгийн амьдралд гарсан өөрчлөлт, түүний дотор ядуурал, ажилгүйдэл, гэмт хэрэг, хар тамхи, архидалттай хэрхэн тэмцэж байгаа болон тэргүүлэгч донор орнуудын тусламж хэрхэн нийгмийн амьдралд хүрч байгааг судлан гаргаж, орчин үеийн Монгол-Оросын харилцааны тулгамдсан асуудлуудад үнэлэлт дүгнэлт өгчээ. **В.В.Грайворонскийн «*XXI зууны эхэн үеийн Монгол Улс: улс төр, эдийн засаг, нийгэм*»** номын "Гадаад бодлого" хэмээх бүлэгтээ: «*Монгол Улс хөрш орнуудтайгаа харилцах бодлогодоо тэднээс Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хандаж буй байдлыг харгалзан үзэх бөгөөд Монгол Улсын үндэсний ашиг сонирхол хөндөгдөөгүй тохиолдолд хөрш орнуудын маргаанд эс оролцож, төвийг сахих бодлого баримтлах ажээ. Монгол, Орос, Хятадын хоорондын харилцааны түүхэн туршлагын хэд хэдэн сөрөг үр дагаврыг харгалзан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд томъёолсон хамгийн чухал шинэ заалт юм. Орос, Хятадын хоорондын харилцаа хэвийн, найрсаг байгаа нөхцөлд Монголын бодлого ийм байх нь үндэслэлтэй, зүй ёсны бөгөөд үр ашгаа ч өгөх болно*»[7] гэжээ.

## Нэг. Монгол Улсын "гуравдагч хөрш"-ийн бодлогын талаар

Монгол Улсын гадаад бодлого, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаар тодорхойлсон "гуравдагч хөрш"-ийн улс төрийн чиглэл нь Монгол шиг жижиг эдийн засагтай орны хувьд чухал ач холбогдолтой. "Гуравдагч хөрш" бол Монгол Улсын хувьд батлан хамгаалах гэхээсээ илүү "улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэг"-ийн утга агуулсан бодлого болохын хувьд эдийн засгийн хямралт байдлыг даван гарахад чиглэгдэж байсан бөгөөд эдүгээ ч "гуравдагч хөрш"-ийн орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал эл бодлогын үндсэн чиглэл хэвээр байна. Оросын талаас Монголын "гуравдагч хөрш"-ийн бодлогыг төдийлөн таашаадаггүй. Энэ нөхцөл байдлыг харгалзан үзэх нь Монгол Улс "гуравдагч хөрш" орнуудын улс төр, эдийн засаг, санхүүгийн талбарт түшиг тулгуураа алдахгүй байхтай холбоотой асуудал юм. В.В.Грайворонский: «*Орос улсын үндэсний ашиг сонирхол болон аюулгүй байдлын үүднээс "гуравдагч хөрш"-ийн бодлогыг авч үзвэл түүний шууд хил залгаа бүс нутагт чухамхүү ямар орны стратегийн ашиг сонирхол ямар хэмжээ, хэлбэрээр хэрэгжиж байгаа нь огтын хамаагүй зүйл биш гэж бид бодож байна. Тодорхой таарамжгүй нөхцөлд нөлөө бүхий "гуравдагч"орны стратегийн сонирхлыг Монгол Улсад чиглэсэн зорилготойгоор буй болгож дэлгэрүүлэх арга зам нь улс орны үндэсний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд бус харин ч энэ бүс нутагт хэд хэдэн их гүрний геополитикийн болон стратегийн сонирхлыг хурцатгахад хүргэж болох юм гэж ойлгогдож байна*»[8] гэжээ. Мөн тэрээр «*Монголын "гуравдагч хөрш"-ийн бодлогод*

7 В.В.Грайворонский. Монголия в начале XXI века: политика, экономика, общество. М. 2017. ИВРАН. С.187.

8 В.В.Грайворонский. Концепция внешней политики Монголии. Проблемы Дальнего Востока. 2012. №2. С.56-59.

*хэд хэдэн чухал зүйл байгааг дурдаад, Орос, Хятадын нөлөөний эсрэг жин дарж, тодорхой үйлчилж чадахуйц гадны, томоохон, нөлөөтэй гуравдагч хүчин, нэг улс ч юм уу, нэг бүлэг улс ч юм уу байх учиртай гэж нэрнээс нь хүртэл ойлгогдож байна. Энэ нь Оросын санааг тодорхой хэмжээгээр зовоож байна*» гэжээ.

Буриадын их сургуулийн доктор, доцент **В.А.Родионов**[9] **“Социализмын дараах өөрчлөлтийн Монголын улс төрийн үйл явц”**[10] номонд Монгол Улс болон “гуравдагч хөрш” орнуудын харилцаа, ялангуяа Монгол, АНУ хоорондын харилцааг онцолсон байна. Тэрээр “*АНУ Монголын батлан хамгаалахын сургууль, сургалт, бэлтгэл зэрэгт туслалцаа үзүүлэн, хамтарч цэргийн хээрийн сургууль хийж, улмаар Афганистан, Ирак, Африкийн орнуудад монгол цэргүүд энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байгаа нь АНУ-ын улс төрийн нөлөө үзүүлэх нэг сувгийн үүрэг гүйцэтгэж байна*” гэжээ. Эндээс харахад Монголын талаар баримталдаг Оросын бодлого бол барууны эсрэг үзлийг төлөвшүүлэх, АНУ-аас холдуулж, гуравдагч хөршийн бодлогыг саармагжуулах санаа илт харагдаж байна.

**С.Г.Лузянины**[11] **“Владимир Путины Дорнын бодлого. “Их Дорно” руу Орос улс буцаж ирсэн нь**”[12] номын “Бидний бараг алдсан Монгол” хэмээх бүлэгтээ “*Монголыг бид 1990-ээд онд алдсан боловч, одоо нэр төртэйгээр буцаж очихыг хичээж байна. 1990-ээд онд Монгол Улс нь Орос болон Хятад хоёр хөршөөсөө илүү либерал, нээлттэй эдийн засгийн загварыг бий болгож чадсан юм. Түүнээс гадна, Монголын дотоод, гадаад бодлогын үр дүнд олон улсын түвшинд стратегийн гуравдагч түнш (Орос, Хятадаас гадна “гуравдах дахь хүчин”) бий болсон. Гуравдагч түнш орнуудад АНУ, Япон, Өмнөд Солонгос, Европын Холбоо болон бусад орнуудыг оруулж байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Гадаад бодлогын үзэл баримтлал зэрэг албан ёсны баримт бичгүүдэд дурдсанаар “гуравдагч хүчин” нь Орос, Хятадын хүчийг тэнвэржүүлж байгаа юм. Нэг талаас Оросын гадаад бодлогын схемд Монголын үүрэг роль буурсан нь 1990-ээд оны эхээр Монголын элитүүд, тэр дундаа засгийн эрх баригчдын дунд Оросын эсрэг уур амьсгал зонхилж байсантай холбоотой. Энэ байдал төдийлөн удаан үргэлжлээгүй нь Монголын ард түмэн Орос улс, оросын ард түмэнд уламжлалт нөхөрсөг сэтгэлээр ханддаг байдал нөлөөлсөн. Түүнээс гадна Монголчууд Орос улс, Орос хүмүүсийг найз нөхөр, хамгаалагчаа гэж хардаг, харин Хятадыг хаалттай дайсан, аюултай хөрш гэж хардаг”* хэмээн Монголын гуравдагч хөршийн бодлогын талаар болон шинэ үеийн Монголчууд Оросуудад хэрхэн хандаж байгааг дүгнэн бичсэн байна.

ОХУ-ын Дорно дахины хүрээлэнгийн монгол судлаач асан **М.Гольман: “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын асуудалд”** хэмээх өгүүлэлдээ:

9 В.А.Родионов. Буриадын Улсын их сургуулийн доктор, доцент
10 В.А.Родионов. Политический процесс в Монголии в условиях постсоциалистической трансформации. Улан-Удэ. 2018. Стр. 295.
11 С.Г.Лузянин. ОХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын хүрээлэнгийн дорно дахин судлаач.
12 С.Г.Лузянин. Монголия, которую мы почти потеряли. С.Г.Лузянин. Восточная политика Владимира Путина. Возвращение России на Большой Восток (2004-2008 гг.). М. АСТ: Восток-Запад. 2007.

"Монголын "гуравдагч түнш" хэмээгдэх Америк, Япон, Өрнөд Европ нь Монголын аюулгүй байдлаас болж өөрсдийгөө ноцтой мөргөлдөөнд татан орохгүй гэдгийг монголчууд ч өөрсдөө сайн ойлгож байгаа шүү дээ. Иймээс Монголын нутаг дэвсгэрт хэзээ ч өнгөлзөж байгаагүй, Монголын төр улсыг хадгалахад ямагт тусалж ирсан, өөрийн уламжлалт холбоотон, хамгаалагч байсан Орос улсад хандаж тусламж дэмжлэг авах боломжийг хадгалж үлдэх явдал Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Цэргийн номлолын аль алинд хэдийгээр бүрхэг тусгагдсан боловч практик дээр Оростой цэргийн хэргийн талаар хамтран ажиллах нь тус орны үндэсний аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэхэд их тус дөхөм болох нь өнөөдрийн хувьд бодитой билээ" хэмээн дурдсан байдаг

## Хоёр. Эдийн засгийн хамтын ажиллагааны талаар

Оросын Монгол дахь эдийн засгийн ашиг сонирхлын талаар **В.А.Родионовын**[13] **"Россия и Монголия. Новая модель отношений в начале XXI века"** (Орос ба Монгол. XXI зууны эхэн үеийн харилцааны шинэ загвар) номонд Оросын Монгол дахь эдийн засгийн ашиг сонирхлын талаар: *"Москва, Улаанбаатарын хоорондын улс төрийн харилцаа өндөр түвшинд хүрсэн нь энэ улсад Оросын бизнес эрхлэхэд чиглэсэн автомат "ногоон коридор" гэсэн үг биш гэдгийг Монгол дахь Оросын бизнес эрхлэгчдэд тулгараад буй бэрхшээлүүд харуулж байна. Энэ асуудал нь Орос, Монголын эдийн засгийн харилцааны гурав дахь томоохон өөрчлөлттэй холбоотой, өөрөөр хэлбэл, Монголын зах зээл дэх Оросын талын улс төрийн хамтын ажиллагааны түвшин ба эдийн засгийн давуу эрхийн хоорондын шууд холбоо байхгүй байна. Монголын улс төрийн тогтолцоонд хэд хэдэн хүчний төв болох улс төрийн нам, санхүү эдийн засгийн бүлэглэлийн нөлөө, үүнд гадаадын (хятад, япон, америк) бүлэглэлүүд Оросын эдийн засгийн ашиг сонирхлыг Монгол Улсад бий болгоход ноцтой саад болж байгаа тул Оросын бизнес эрхлэгчдээс орчин үеийн Монголын улс төрийн соёл ба бпзнесийн харилцааны онцлог шинж чанарыг харгалзан үзэх шаардлага тулгардаг."*[14] гэжээ.

**С.Г.Лузянины "Россия и Китай в Евразии" (Еврази дахь Орос ба Хятад)** номын "Орос-Монголын чиглэл. Орчин үеийн харилцааны онцлог" хэмээх дэд бүлэгт Монгол-Оросын эдийн засгийн хамтын ажиллагаанд саад болж байгаа хүчин зүйлийг монголын уламжлалт бүтээгдэхүүнд оногдуулж байгаа тарифын болон тарифын бус саад тотгор, Монголын нутгаар дамжин өнгөрөх Оросын бүтээгдэхүүнд оногдуулж буй төмөр замын өндөр татвар, Монголын экспортын мах махан бүтээгдэхүүнд оногдуулдаг эрүүл ахуй, хорио цээрийн хатуу дэглэм зэрэг хүндрэлүүд оршиж байгааг дурдаад Оросын экспорт, Монголын импортын хоорондын зөрүү жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь хоёр талын худалдаанд сөргөөр нөлөөлж байгааг онцолсон байна.

---

13 В.А.Родионов. Буриадын Улсын их сургуулийн доктор, доцент

14 В.А.Родионов. Россия и Монголия. Новая модель отношений в начале XXI века. Улан-Удэ. 2009. С.127-128

## Гурав. Монголын ШХАБ дахь статусын талаар

Монгол Улсад тулгарч буй асуудлуудад хоёр их гүрэн харилцан адилгүй хандаж буй мэт боловч стратегийн үндсэн асуудлаар нягт хамтран ажилладаг. Энэ утгаараа Оросын ч тэр Хятадын ч тэр бодлоор Монгол Улсыг Шанхайн Хамтын ажиллагааны байгууллагад жинхэнэ гишүүнээр элсүүлэх тал дээр нэгддэг. **В.Грайворонский:** *"Орос, Хятадын төрийн тэргүүнүүдийн зүгээс Монголыг ШХАБ-д элсүүлэх саналыг шууд тавьж байсан боловч, Монголын хувьд ШХАБ дахь бүрэн эрхт гишүүнчлэл нь ЕХ, Америк, Япон зэрэг орнуудтай харилцах харилцаанд сөргөөр нөлөөлнө хэмээн болгоомжилдог"* гэжээ. **В.А.Родионов**: "*Монгол Улс ШХАБ дахь ажиглалтын статусаа өөрчлөх сонирхолгүй байгаа нь ШХАБ нэг чухал чиглэлээ терроризм, экстремизим, сепаратизмтэй тэмцэх явдал гэж заасан бол тэр бүхэн нь Монголд одоогоор байхгүй, нэг хэсэгтээ ч байх нөхцөлгүй байна. Түүнээс гадна, хар тамхи, зэвсэг, хууль бус шилжих хөдөлгөөн зэрэг Төв Азийн бүс нутгийн асуудлууд ч Монголтой энэ чиглэлээр ойртох хүчин зүйл ч болж чадахгүй байна*"[15] хэмээсэн.

## Дүгнэлт

ОХУ-аас Монголын талаар баримталж буй бодлого, байр суурь, ашиг сонирхлын өөрчлөлт, онцлог болон эерэг, сөрөг талыг нээн илрүүлэх үүднээс Монгол Улсын хэрэгжүүлж буй гадаад бодлого, Монгол-Оросын хооронд тогтоосон иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны тэргүүлэх чиглэлүүд, түүний дотор улс төр, эдийн засаг, дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудын талаар Оросын эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүнд тулгуурлан ОХУ-аас Монголд хандах хандлага, түүнчлэн Монголоос Орост хандах хандлагыг судлан шинжлэх явдал хоёр орны цаашдын харилцаа, хамтын ажиллагааг тандан судлах, үйл явдлын өрнөлтийг баримжаалахад чухал ач холбогдолтой юм. Монголын улс төр, нийгэм, эдийн засаг, гадаад харилцаа, соёл, боловсрол, шинжлэх ухаан болон хоёр орны харилцааны хөгжил, өнөөгийн түвшин, ололт, бэрхшээл зэрэг олон асуудлыг дагнан судалсан, шинэ хандлагаар үнэлэн дүгнэсэн Оросын эрдэмтдийн эрдэм судлалын бүтээлүүд нь Оросын Монголын талаар явуулах геостратегийн бодлогын судалгаа болохын хамт төрийн бодлогодоо нөлөөлж, тэр нь эргээд Монгол Улстай харилцах бодлого, чиглэл болох талтай. Тиймээс энэ төрлийн судалгаа нь хоёр орны харилцааны судалгааны нэг судлагдахуун болох боломжтой юм.

---

15 В.А.Родионов. Монголия и ШОС: сотрудничество на расстоянии.// Известия Уральского Федерального университета. Сер.2. 2012. №4 (108)6 V6244-2506

## Оросын эрдэмтдийн бүтээлүүдийн тойм жагсаалт:

**Ном:**


1. Г.С.Яскина. Монголия и внешний мир. М. ИВРАН. 2002. 370с.
2. М.Б. Регионы России в торгово-экономическом сотрудничестве с Монголией. 2009. 168 с.
3. В.В.Грайворонский. "Реформы в социальной сфере современной Монголии". Москва. 2007. 252с.
4. Г.С.Яскина. История Монголии. XX век. Москва. 2007. 448с.
5. С.Г.Лузянин. Монголия, которую мы почти потеряли. С.Г.Лузянин. Восточная политика Владимира Путина. Возвращение России на Большой Восток (2004-2008 гг.). М. АСТ: Восток-Запад. 2007.
6. С.Г.Лузянин. Россия и Китай в Евразии. Москва. 2009. 282с.
7. М.И.Гольман. Современная Монголия в оценках западных авторов. Москва. 2009. 192с.
8. А.С.Железняков. Монгольский полюс политического устройства мира. Москва. 2009. 272с.
9. В.В.Грайворонский. Изменения в уровне жизни населения Бурятии (Россия), Монголии и Внутренней Монголии (Китай) в конце XX – начале XXI вв. Лос-Анджелас-Улаанбаатар. 2014. 284с.
10. Е.В.Бойкова. Российские военные исследователи Монголии (вторая половина XIX — начало XX века). Москва. 2014. 264с.
11. А.С.Железняков. Монгольская цивилизация. История и современность. Теоретическое обоснование атласа. Москва. 2016. 288с.
12. В.В.Грайворонский. Монголия в начале XXI века: политика, экономика, общество. Москва. 2017. ИВРАН. 351с.
13. Л.Болд. С.К.Калмыков. Монголия-Россия: особенности политических процессов. Улаанбаатар. 2017. 293с.
14. Родионов В.А. Россия и Монголия: новая модель отношений в начале XXI века. - Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2009. - 228 с.
15. В.А.Родионов. Политический процесс в Монголии в условиях постсоциалистической трансформации. Улан-Удэ. 2018. 339с.
16. М.И.Гольман. Монголия глазами монголоведа (60–70-е гг. XX века). Москва. 2019. 288с.


**Өгүүллийн эмхэтгэл:**


1. Глобализация и Монгольский мир. Улан-Удэ. 2010. 387с.
2. Россия и Монголия на пути стратегического партнерства. Москва-Улаанбаатар. 2011.437с.

3. Социально-политические процессы и ценности в условиях глобализации : [сб. ст.] / под ред. А. С. Железнякова и З. П. Яхимович. - М. : Новый хронограф, 2012. - 520 с.: ил. - ISBN 978-5-94881-194-9. I. Железняков, А. С., ред.
4. Место России и Монголии в современной региональной конфигурации. М.2012. 85с.
5. Современные российско-монгольские отношения: модели и сценарии. Улан-Удэ. 2013. С.247
6. Россия, Китай и Монголия: вместе навстречу вызовам современности. Москва, 2013, 224 с.
7. Россия-Монголия. 100 лет дипломатического сотрудничества. Улан-Удэ. 2013. 423с.
8. «Я рад, что стал монголоведом.» К 85-летию С.К. Рощина. Москва; Улаанбаатар, 2015, 296 с.
9. Монгольский мир в условиях взаимодействия России Восточной Азии в XX-XXI вв. Улан-Удэ. 2017. 203с.

**Эгүүлэл*:***

1. Яскина Г. Российско-Монгольское партнерство в первом десятилетии нового века.//Проблемы Дальнего Востока. №6, 2006. Стр. 15-24
2. И.Г. Аюшиева. Современная концепция внешней политики Монголии – Попытка преодоления буферного характера государственности. // Вестник Томского государственного университета. 2008. №316.
3. С. Якушев. Монголия в современной системе международных отношений. //Мировая экономика и международные отношения, 2010, № 8, с. 109–115. DOI: 10.20542/0131-2227-2010-8-109-115
4. В.В.Грайворонский. Концепция внешней политики Монголии. // Проблемы Дальнего Востока. 2012. №2. С.56-59.
5. В.А.Родионов Сравнительный анализ политических систем России и Монголии.// Официальный сайт ИС РАН. - 2008. URL:http://www.isras.ru/publ.html?id=615
6. В.А.Родионов. Монголия, которую мы не знали. – Полис. Политические исследования. 2011. № 4. С. 185-189
7. В.А.Родионов. Монголия и ШОС: сотрудничество на расстоянии.// Известия Уральского Федерального университета. Сер.2. 2012. №4 (108)6 V6244-2506
8. В.А.Родионов. Национальная безопасность Монголии в контексте отношений с Россией. //Власть. 2013. №2. С.137-140.
9. Родионов В. А. Политический процесс в постсоциалистической Монголии: формальные институты и неформальные практики // Власть. 2015. Том. 23. № 2. С. 76-81.

10. Родионов В. А. Монголия на рубеже XX-XXI вв.: случай постсоциалистической трансформации // Вестник Института социологии. 2016. № 18. С. 138-159.
DOI: https://doi.org/DOI: 10.19181/vis.2016.18.3.418
11. Родионов В. А. Монголия в конце 1980-х гг.: начало постсоциалистической трансформации // Власть. 2016. Том. 24. № 5. С. 156-160.
12. Родионов В. А. Фактор Далай-ламы XIV в современных монголо-китайских отношениях // Власть. 2017. Том. 25. № 9. С. 153-157.
13. Родионов В. А. Партийные фракции в политическом процессе современной Монголии // Власть. 2017. Том. 25. № 1. С. 72-76.
14. В.А.Родионов. Политический процесс в Монголии сквозь призму электоральных циклов.// Власть. 2019. №1. С.273-279.
15. В.А.Родионов. Российские ресурсы «мягкой силы» в Монголии: текущее состояние и потенциал использования. //Власть. 2020. №2. С.283-291.
16. Родионов В. А., Нямдолжин А. Политический образ Владимира Путина в Монголии // Власть. 2021. Том. 29. № 1. С. 30-36.
DOI: https://doi.org/10.31171/vlast.v29i1.7862
17. М.И. Гольман. Президентские выборы в Монголии. // Седьмые востоковедные чтения БГУЭП. Иркутск. 2013. С.238-245.
18. В.Б.Базаров. Внешнеполитический курс Монголии в XXI в.//Власть. 2016. Том 24 № 10. С. 83-87.
19. И.Ю.Фролова. Перспективы трёхстороннего сотрудничества России, Китая и Монголии. // Проблемы национальной стратегии № 6(45) 2017. С.84-102.
20. И.Г. Аюшиева. «Третий сосед» Монголии как идейно-политический концепт. // Вестник Томского государственного университета. 2017. № 420. С. 125–130. DOI: 10.17223/15617793/420/17
21. Т.Н. Литвинова, А.С.Железняков. Взаимное восприятие образов России и Монголии в контексте трансцивилизационного взаимодействия. // Социологические исследования № 5, 2019. С.129-138.
22. А.Б.Базаров. Анализ развития экономики Монголии по видам экономической деятельности. // Вестник Бурятского научного центра Сибирского отделения Российской Академии Наук. 2019. 1 (33), 198-204с.
23. А.В. Михалев. Символы советского присутствия в постсоциалистической Монголии. // Политическая наука, 2020. № 2. С.126-142
24. Б.Г. Санеев, С.П.Попов, Д.В. Максакова. Газификация Монголии:Ввзможности многостороннего сотрудничества. Работа выполнена по гранту РФФИ “18-510-94006 МОКНМ_а”. «Энергетическая политика» №3(145), март 2020
25. В.О.Намжилова. Российско-монгольские торговоэкономические отношения: дальневосточные перспективы. Регионалистика. 2021. Том 8. №1. С.29-38.

# МОНГОЛ УЛСЫН ТУСГААР ТОГТНОЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛД ОХУ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ

А.НЯМДОЛЖИН
*Доктор (Ph.D)*
*ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн*
*Орос судлалын салбарын эрхлэгч,*
*Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан*

Монгол Улс тусгаар тогтнол аюулгүй байдлаа улс төрийн ардчилал, зах зээлийн эдийн засгийн зарчмаар баталгаажуулах болсноо зарласнаас хойш 30 жилийг ардаа үджээ. Монгол Улсын улс төр, үзэл суртлын гадаад орчин өөрчлөгдөж, дотоод орчин дахь нийгэм эдийн засгийн шинэ тогтолцоонд суурь өөрчлөлтүүд эргэлт буцалтгүй хийгдэж байсан 1994 онд Монгол Улсын Их хурлаас “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал” батлаж улмаар 2011 онд шинэчлэн баталсан нь төрөөс үндэсний аюулгүй байдлын талаар явуулах бодлого, чиглэлийг тодорхойлсон чухал ач холбогдолтой баримт бичиг болсон юм. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд: “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг үндэсний аюулгүй байдал хэмээнэ” гэж заасан бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын үйл ажиллагаа ба гадаад бодлого нь энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт байна гэдгийг онцолсон юм.

*Гадаад орчны нөлөөлөл нь тухайн улсыг хүрээлж буй улс орнуудын болон тухайн улсын үндэсний ашиг сонирхол хоорондын харилцаа, шинж агуулгаас* шалтгаалж байдаг тул Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал нь олон улсын харилцааны нөхцөл байдал болоод их гүрнүүдийн хоорондох хүчний тэнцвэрээр тодорхойлогддог. Ялангуяа монголчуудын хүсэл зоригоос үл хамааран Орос, Хятад хэмээх хоёр хөршийн хоорондын харилцаа, эрх ашгийн тэнцвэр нь Монгол Улсын оршин тогтохуйн аюулгүй байдалтай шууд холбоотой хүчин зүйл байсаар ирсэн.

1990 оныг хүртэл Монгол, Орос хоёр оронд эхэндээ дэлхийн хувьсгалын онол, сүүлээр нь социализмын бүтээн байгуулах онол бүхий хоёр орны геополитик, эдийн засаг, цэргийн сонирхолын нягт сүлжилдсэн байдал ноёрхож байв. Зөвлөлтийн нөмөр нөөлөгт дотоод гадаад бодлогоо даатган шийдвэрлэж, түүний үзэл суртал, улс төр, эдийн засгийн хүчтэй нөлөө, хараат байдалд байсан нь Монгол Улсыг Зөвлөлтийн 16 дахь БНУ, Зөвлөлтийн дагуул улс гэх ойлголтыг бий болгосон гэж үздэг. Америкийн нэрт эрдэмтэн О.Латтимор 1936 онд Монголыг

Оросын дагуул улс гэсэн онолын чиг баримжааг гаргахдаа, дагуул улсын тухай үзэл санааг сайн талаас нь авч үзсэн байдаг. Тухайлбал, "Монголчууд өөрсдийн саналаар, зарим талаар Япон, Хятад хоёроос айн цэрвэснээс болж Оросын тойрогт оржээ" гэж бичжээ. О.Латтимор "Нүүдэлчид ба комиссарууд" хэмээх номондоо хоёр их гүрний зах хязгаарт чухал үүрэг гүйцэтгэдэг Монгол орон Орос, Хятадын хооронд стратегийн болон эдийн засгийн харилцаа холбоо хөгжүүлэхэд асар их ач холбогдолтой газар зүйн бүс болон хувирлаа хэмээгээд Монгол-Оросын харилцаа нь Монголын тусгаар тогтнолыг сэргээхэд онцгой үүрэг гүйцэтгэснийг тэмдэглэсэн байдаг. Тиймээс ч Монголыг олон улсын харилцааны томъёоллоор "дагуул улс" гэдэг статуст хамруулж ирсэн билээ. Харин тэр үед тийм нягт харилцаа холбоогүй байсансан бол орчин үеийн тусгаар тогтносон Монгол улс оршин тогтнох асуудал ч ээдрээтэй байх байсан. Тиймдээ ч олон улсын харилцааны хоёр туйлт тогтолцоонд сөргөлдөгч хоёр хөршийнхөө дунд газар зүйн байршлын хувьд хавчигдсан Монгол улс аюулгүй байдлаа улс хоорондын харилцааны хүрээнд нутаг дэвсгэрээ гадны халдлага түрэмгийллээс хамгаалах чиглэлээр тодорхойлж Оростой тогтоосон харилцаа нь аюулгүй байдлын найдвартай баталгаа болж байсан.

XX зууны эхэнд Орост Октябрийн хувьсгал гарсны улмаас Богд хаант Монгол улсын Засгийн газар 1919 онд Хятадыг түших шийдвэр гаргамагц Хятадын цэрэг Хүрээнд нэвтэрч, Монголын тусгаар тогтнолд аюул тулгарч байв. 1921 онд Ардын хувьсгал ялсны дараа ч Орос, Хятад, Япон улсуудын геополитикийн бодлогын улмаас Монгол улсын тусгаар тогтнолын асуудал хүнд бэрх цаг хугацааг туулахад хүрч байсан тэр үед 1936 оны ЗСБНХУ-БНМАУ-ын Харилцан туслалцах протокол нь Монголыг олон улсын харилцааны субъект болохыг харуулснаараа түүхэн ач холбогдолтой байсан. Дэлхийн хоёрдугаар дайны өмнөх "Алс Дорнод дахь хүчний харьцаа Монголын байр сууринаас шалтгаалах байдал бүрэлдэж байсан нөхцөл дэх их гүрнүүдийн зөрчил дунд Орос, Монголтой холбоотны харилцаа тогтоосон нь Монголын тусгаар тогтнолыг хуульчлан баталгаажуулах эхлэлийг тавьсан байна[1] хэмээн доктор Р.Болдын өгүүлсэнийг энд эшлэж байна. Дэлхийн хоёрдугаар дайны үед фашист Герман, милитарист Японы түрэмгийллийн эсрэг тэмцлийн эгнээнд нэгдэн, Алс Дорнодод Японы армийг бут ниргэж, Хятадын ард түмнийг чөлөөлөхөд оролцон хувь нэмрээ оруулсан явдал тэр үеийн Монгол улсын гадаад бодлого, үйл ажиллагааны чиг шугам болж байв. Энэ бодлого амжилт олсны нэг баримт бол ЗХУ 1945 онд Крымийн бага хурлын шийдвэрт Японы эсрэг дайнд оролцох нэг болзлыг "Гадаад Монголын статус кво-г хэвээр байлгах" гэж заасан явдал байлаа. Тухайлбал, Ялтын бага хурал, Зөвлөлт-Хятадын 1945 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн Гэрээ, Монголд явагдсан бүх нийтийн санал хураалт, тэрчлэн 1946 оны 1 дүгээр сарын 5-нд Гоминданы Засгийн газраас энэхүү санал хураалтын дүн болон Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрснөөр олон жил үргэлжилсэн Монголын олон улсын эрх зүйн хоёрдмол байдлын асуудал

1 Р.Болд. Монголын аюулгүй байдлын орчин, батлан хамгаалах бодлогын зарим асуудал. УБ. 1996.

эцэслэн шийдвэрлэгдсэн юм.[2] Ийнхүү Оросын маш тодорхой байр суурь, олон жилийн тууштай бодлого нь олон улсын тавцан дээр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Чингэхдээ Монгол улс аюулгүй байдлаа "буфер" улсын байдлаар хангаж ирсэн. Газар зүйн байршлын онолтой уялдан олон улсын харилцааны онол болоод Америкийн Пембрукийн их сургуулийн профессор Жон Чей, Томас Росс нар "буфер" улс гэж "жижиг улс болон төвийг сахисан улс хоёр том орны дунд байрласан орныг хэлнэ"[3] гэж тодорхойлсон бол Дэвид Найт: "буфер" улс нь ихэвчлэн хоёр буюу түүнээс дээш хүчирхэг, ашиг сонирхолын нөлөө бүхий орнуудын хооронд байрладаг улс"[4] гэж тодорхойлжээ. Монгол Улсын геостратегийн байршил нь олон зууны турш Оросын өмнөд хилийг батлан хамгаалж "буфер"-ийн үүрэг гүйцэтгэж ирсэн. Иймд буфер улсын хувьд газар зүйн хүчин зүйлийг үгүйсгэх аргагүй юм. Энэ ч үүднээс XX зууны тэргүүн хагаст Оросын хувьд Монголын буферын үүргийг хэвээр байлгах, Монголын хувьд тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд зөвшөөрүүлэн баталгаажуулах хүчин чармайлтаас үүдэн Монгол, Орос хоёр орны ашиг сонирхол нэг цэгт огтлолцож байв.

Москвагийн Олон улсын харилцааны дээд сургуулийн доцент В.Корсун "Сталин Монгол Улсад тусгаар тогтнол олгон баталгаатай буфер бүс болгох нь стратегийн эн тэргүүний асуудал гэж үзэж байсан бөгөөд тэрээр "Гадаад Монгол нь Зүүн Хойд Ази дахь ЗХУ-ын аюулгүй байдлыг хангах "буфер" болохын хувьд "хэрэв ЗХУ Монголд өөрийгөө батлан хамгаалах хууль ёсны эрхийг олгохгүй бол цаашдаа "... Герман, Япон хоёр эргэн сэргэж өмнөх шигээ хүчирхэг гүрэн болох аваас ЗХУ Алс Дорнодоо бүхэлд нь алдах болно"[5] хэмээн тэмдэглэсэн байна.

Эндээс харахад Орос улс Монголыг хувь заяаны холбоотон, түүний аюулгүй байдлын нэг гол буфер улс гэж харж хандаж ирснийг гэрчилж байна. Халх голын дайнд олон мянган цэрэг эрсийнхээ амийг алдан байж, Монголыг хамгаалан, Японд цохилт өгч ялсан нь нэг талаас буфер бүсээ аварч хамгаалах, нөгөө талаас Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолыг бататгахад чухал үүрэг гүйцэтгэсэн үйл явдал болсон юм. Тиймдээ ч эдүгээ Халх голын байлдааны хамтын ялалтад онцгой ач холбогдол өгч, тус ялалтын 70, 75, 80 жилийн ойн баярын арга хэмжээний хүрээнд ОХУ-ын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчлалуудаа хийх болсоноос харахад "буфер" бүсийн үүрэг өнөөдөр ч ач холбогдолтой хэвээр байх нь. Гэхдээ Хүйтэн дайнаас хойш "буфер" бүсийн хавчигдмал, хязгаарлагдмал хүрээнээс гарч, нэлээн өргөн хэмжээнд, тухайлбал, Зүүн Хойд Азийн бүсийн, Төв Азийн бүсийн, олон соёл иргэншлийн дундын бүс нутгийн "буфер" бүсийн үүрэг гүйцэтгэх төлөв харагдаж байна.

---

2 Ж.Базарсүрэн. Дэлхийн хоёрдугаар дайн, Монголын тусгаар тогтнолын асуудал. Дэлхийн II дайн: түүхэн сургамж, орчин үе. УБ.2005. 39-р тал.
3 Chay, J. and Ross, T., eds. (1986) Buffer States in World Politics. Westview Press: Boulder
4 Knight, D. B. (1988) 'Review'. Geographical Review, 78 (1): 93-95.
5 В.А.Корсун. Сталин и Китай в годы войны. Том VIII. Дипломат.

1960-аад онд буюу 60 жилийн өмнө ЗХУ, БНХАУ-ын харилцаа муудахад Монголын удирдлага Москвагийн талд зогссоноор Зөвлөлтийн цэрэг Монголын нутаг дэвсгэрт бараг 30 жил байрласан юм. Тэр үед дайн гарсан бол дайны тэргүүн шугам болж, хамгийн түрүүнд хохирогч болох аюултай байв. Ийнхүү Монгол улс хоёр хөршийнхөө нэгэнтэй нь эвссэнээр өөрийн газар нутгийг нөгөө хөршийн эсрэг хамгийн ойроос цохилт өгөх чадавхийг бүрдүүлсэн байдаг. Хятадын боломжит түрэмгийллийн эсрэг чиглэсэн 1966 оны хоёр орны хоорондын "Найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ"-гээр гадны халдлагад өртсөн тохиолдолд ЗХУ БНМАУ-ыг хамгаалах үүрэг хүлээсэн. Тиймдээ ч тус гэрээ нь Монгол-Оросын цэрэг, улс төрийн хамтын ажиллагааг Варшавын гэрээний орнуудтай хамтран ажиллахтай адил түвшинд хүргэснээрээ онцгой ач холбогдолтой гэрээ байв. Энэ утгаараа Зөвлөлт Оростой холбоотон байсан явдал Монгол улсыг тусгаар тогтносон улс гэж олон улсад хүлээн зөвшөөрөгдөхөд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

Монгол улс аюулгүй байдлаа хангах асуудлаас гадна тусгаар тогтнолынхоо энэ хугацаанд Зөвлөлт маягийн хөгжлийн загвараар замнан ЗХУ-ын тусламжтайгаар феодалын үеийн хоцрогдсон ахуй байдлаас орчин цагийн суурин соёл иргэншилд шилжиж, аж үйлдвэр, хот суурин газруудыг байгуулж, улс төр, нийгмийн байгуулал, эдийн засаг, соёл, урлаг, шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалахын салбарыг үүсгэн байгуулж хөгжүүлж чадсан юм. Нөгөө талаараа, Монгол-Зөвлөлтийн цэрэг, улс төрийн холбоо нь Оросын ашиг сонирхолд нийцсэн худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг өргөн агуулгаар тэтгэж байв. Социализмын замаар замнасан энэ хугацаанд гадаад харилцааны гол жин нь ЗХУ-д ногдож байсан хэдий ч Монгол улс дэлхийн 83 улстай дипломат харилцаатай, Нэгдсэн Үндэстний Байгууллага, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл зэрэг олон улсын байгууллагын гишүүн орон болсон байлаа.

Монгол-Хятадын чиглэл дэх Оросын шинэ гадаад бодлогын эхлэл нь 1986 онд Владивосток хотноо М.С.Горбачёв: "Оросоос Хятадтай харилцаагаа сайжруулах эрмэлзэлтэй байгаа ба үүнийг Монголын нутгаас Оросын цэргийг гаргах замаар шийдвэрлэнэ" гэсэн байдаг. Энэ нь Орос, Хятадын хоорондын харилцааг хэвийн болгож, цаашлаад Монгол, Орос, Хятад гурван улсын хоорондын хурцадмал байдлыг намжааж, Монгол-Оросын харилцаанд Хятадын зүгээс шууд цэргийн аюул заналхийлэл учруулж байсан хүчин зүйлийн нөлөөг бууруулсан юм.

Ийнхүү Монгол Улс хөрш хоёр орон Орос, Хятадтай эвсэж, дайсагнаж харилцсаар ирсэн зуун жилийн туршлагаас харахад хамгийн оновчтой бодлого бол хоёр улсын хооронд "тэнцвэртэй" харьцах явдал гэдгийг харуулж байна. Монгол Улсын "Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д "ОХУ, БНХАУ-тай сайн хөршийн найрсаг харилцаа, өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ. Чингэхдээ үндэсний эрх ашиг, харилцааны түүхэн уламжлалыг харгалзан бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг эрхэмлэж, бүхэлдээ тэнцвэртэй харилцахыг эрмэлзэнэ" гэж тунхагласан байдаг. Энэ зарчим нь "адил зай барих, бүх асуудлаар адил байр суурьтай байхыг бус, харин хоёулантай нь итгэлцлийг

бэхжүүлэх, сайн хөршийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх"-ийг хэлж байгаа юм. Хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцах тухай асуудал бол хувиар хэмжигдэх зүйл биш бөгөөд гадаад худалдааны хувьд аль нэг улс нь жин дарж болох ч улс төрийн хувьд тэнцвэртэй байх явдал юм.

Монгол Улс ОХУ-тай олон жилийн түүхэн уламжлал бүхий хамтын ажиллагаан дээрээ тулгуурлан 1993 онд байгуулсан Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээгээр хоёр орны шинэ үеийн харилцааны эрх зүйн үндсийг тавьсан юм. 1993 оны гэрээ нь хоёр орны харилцааг агуулгын хувьд өөрчлөн, холбоотны харилцаанаас сайн хөршийн харилцаанд шилжиж байгааг нэг талаараа тодорхойлсон. Цаашлаад 2000 оны Улаанбаатарын тунхаглал, Монгол-Оросын харилцааны мөн чанарыг стратегийн түншлэлийн хэмжээнд тогтоосон 2006 оны Москвагийн тунхаглал, Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай 2009 оны тунхаглалд суурилан хоёр орны харилцааг өргөтгөн гүнзгийрүүлж, 2019 онд "Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээ"-г хугацаагүйгээр байгуулснаар хоёр улсын харилцааны хүрч болох хамгийн дээд түвшний харилцаанд хүрээд байна. 2014 онд Монгол, Хятад хоёр улс харилцаагаа "Иж бүрэн стратегийн түншлэл"-ийн харилцаанд шилжүүлэн хөгжүүлэх болсноор Монгол, Оросын харилцаа, Монгол-Хятадын харилцааны түвшинээс хоцорч байсан бол одоо хоёр хөрштэйгөө хоёулантай нь иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаатай болоод байгаа юм. Ийнхүү Монгол Улс хөрш гүрнүүдтэйгээ улс төр, газар нутгийн аливаа маргаангүй, иж бүрэн стратегийн түншлэлийн эрхзүйн үндсийг баттай тавьлаа.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Халх голын ялалтын 80 жилийн ойд оролцохоор Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр байгуулсан тус "Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээ"-ний баримт бичиг нь Монгол улсаас БНХАУ-тай байгуулсан баримт бичгээс эрх зүйн хүч нөлөөгөөр илүү, заавал биелүүлэх үүрэг хүлээсэн шинжтэй заалтууд орсон нь Монгол улсын геостратегийн ач холбогдлыг нэг талаараа бататгаж байгаа юм. Тус гэрээнд: "Талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг-улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй бөгөөд нөгөө Талын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын эрх ашигт харшилсан аливаа нэгэн гэрээг гуравдагч улстай байгуулахгүй болон нөгөө Талын эсрэг чиглэсэн аливаа үйлдэлд оролцох, эсхүл ийм төрлийн үйлдлийг дэмжихээс түдгэлзэнэ. Аль ч Тал өөрийн нутаг дэвсгэрээ нөгөө Талын эсрэг түрэмгийлэл буюу аливаа хүчирхийлэл үйлдэх зорилгоор гуравдагч улсад ашиглуулахгүй. Гадаадын цэрэг, цөмийн болон үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх, нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол Улсын бодлогыг ОХУ хүндэтгэнэ"[6] гэсэн заалтыг тусган оруулжээ.

Америкийн зүгээс Орос болон Хятадад тавих хориг арга хэмжээний дарамт нэмэгдэж байгаатай холбоотой Орос-Хятадын харилцаа өргөжин тэлж, Оросын

6 Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, Оросын Холбооны улс хоорондын гэрээ. Монгол-Оросын харилцаа: баримт бичгүүд. 2005-2020. УБ. 190-р тал

Алс Дорнодын бодлого, Хятадыг чиглэсэн бодлого идэвхижиж байгаа нь Монгол Улсын геостратегийн ач холбогдлыг мэдэгдэхүйц өсгөж байна. "Орос-Хятадын харилцаа "Шинэ эрин үе дэх Орос, Хятадын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагаа" гэсэн хамтын ажиллагааны дараагийн үе шатанд хүрсэн нь Монгол Улсын гадаад хамгийн ойр орчин таатай байгааг илтгэж байна. Ялангуяа Монгол Улсын аюулгүй байдал нь дээр өгүүлсэнчлэн гадаад орчны хүчин зүйл, түүний дотор Орос, Хятадтай тогтоосон харилцаа хийгээд хөрш хоёр орны хоорондын харилцааны өөрчлөлт, төлөв байдал, хүчний тэнцвэрээр тодорхойлогдож ирсэн түүхтэй. Тиймээс Орос, Хятадын харилцааны ойртол, эрчимтэй түншлэлийн цаана хоёр улс Монгол Улстай харилцаагаа хөгжүүлэхдээ бие биетэйгээ өрсөлдөх гэхээсээ Монголын талаар ашиг сонирхлоо харилцан тохирч уялдуулах магадлалтай.

Монгол Улсын хувьд хөрш их гүрнүүдийнхээ улс төр, эдийн засгийн хэт их хараат байдалд орохоос болгоомжилсон бодлого, үйл ажиллагаа гэх мэт сөрөг хүчин зүйлсийг даван туулах шаардлага ч урган гарч байна. ОХУ 2009 оны "Эрчим хүчний стратеги"-иа шинэчлэн 2020 оны 6 дугаар сард "Эрчим хүчний стратеги-2035" баталсан ба үүний дагуу эрчим хүчний түүхий эдийн экспорт нь Европ гэсэн нэг чиглэлээс Ази Номхон далайн бүс нутаг, ялангуяа эрчимтэй хөгжиж байгаа Хятад улс руу чиглэж байна. Хоёр хөршийн иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаанд эрчим хүчний хамтын ажиллагаа, нэн ялангуяа, газрын тос, байгалийн хий болон нүүрсний салбарт хамтран ажиллах асуудал чухал байр суурь эзэлж байна. Энэхүү эрчим хүчний нэг чухал салбар болох байгалийн хий дамжуулах хоолойг Оросоос Монголын нутгаар дамжуулан тавих асуудал ч идэвхжин, Монгол, Оросын Засгийн газрын түвшинд хэлэлцэгдэх болсон нь Орос, Хятад хоёр улс зөвшилцөлд хүрч, тохиролцсоны үр дүн бөгөөд энэ нь цаашлаад Орос-Хятадын хоорондын гэрээгээр бэхжин, хэрэгжих л үлдээд байна. Ийнхүү Монголын нутгаар дайруулан хийн хоолой тавих, Монгол-Орос-Хятад гурван улсын эдийн засгийн коридор болон уул уурхай, байгалийн баялагийг олборлох томоохон төсөл хөтөлбөр яригдаж байгаа энэ үед Орос, Хятадын хооронд идэвхжиж буй эдийн засгийн хамтын ажиллагаа, интеграцийн үйл явцыг оновчтой мэдэрсэн эдийн засгийн дипломат үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Эцэст нь Монгол Улсын аюулгүй байдал, тусгаар тогтнолын эцсийн, найдвартай баталгаа нь ОХУ хэвээр байна. Монгол-Оросын иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд хоёр орны харилцаа улам бүр гүнзгийрэн хөгжихийн сацуу, Монгол, Орос, Хятад гурван талт хамтын ажиллагааг өргөжүүлэн, Ази Номхон далай дахь энх тайван, аюулгүй байдлыг хангах бүс нутгийн гүүр болох боломжтой. Олон улсын тавцанд идэвхитэй үйл ажиллагаа явуулж, бүс нутгийн интеграцид оновчтой оролцон, Монголын эргэн тойрны хүчний харьцаа, нөлөө бүхий улс орны ашиг сонирхолыг тэнцвэржүүлсэн бодлого хэрэгжүүлэн, хамтын ажиллагаа хөгжүүлэхэд чиглэсэн Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагаа улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бататгах гол хүчин зүйлийн нэг юм.

Олон Улс Судлал №1 (109), 2019 он  DOI: https://doi.org/10.5564/jis.v0i1.1253

# Хүйтэн дайны дараах Монгол, Хятад, Оросын гурван талт харилцааны үе шат ба онцлог

***Нацагдоржийн Ариунгуа***

*Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D)*
*ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэн*
*Улаанбаатар, Монгол Улс*
*Цахим хаяг: ariunguan@mas.ac.mn*

***Хураангуй:*** *Хүйтэн дайны үе дуусгавар болсноор Монгол, Орос, Хятад гурван улсын хоорондын харилцаанд тэдгээрийн улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, дотоод, гадаад хөгжлийн зорилт, олон улсын харилцааны өрнөл, чиг хандлага зэргээс хамааран багагүй өөрчлөлт гарсан бөгөөд энэхүү харилцааг тодорхой хэмжээгээр үечлэн судлах нь чухал болж байна. Чингэх нь гурван орны хамтын ажиллагааны хөгжил, энэхүү харилцааны үр өгөөж, нөөц боломж, тулгамдсан асуудлуудыг олж харахад ач холбогдолтой юм. Хүйтэн дайны дараах гурван улсын харилцаа нь хоёр талт харилцаагаар тодорхойлогдож байсан ч хоорондын харилцаанд тус бүрийн хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэсээр байгаа нь гурван улс геополитикийн нэг орон зайд багтдагтай шууд хамааралтай болно. Зохиогч гурван орны геополитикийн харилцан хамаарал эдгээр орнуудын хоорондын хоёр талт харилцаанд хэрхэн нөлөөлж буй асуудлыг хөндөн гурван талт харилцааны хэлбэр бий болоход ямар учир холбогдолтой болохыг харуулахыг зорьжээ.*



***Түлхүүр үг:*** *Хүйтэн дайны дараах Монгол, Орос, Хятад гурван улсын харилцаа, ашиг сонирхлын нэгдэл, хүлээлт*

1990-ээд оны эхэнд социалист систем нуран унаж, ЗХУ задарснаар олон улсын харилцаа хоёр туйлаас олон туйлд шилжиж, дэлхийн хэмжээний хүчний харьцаанд чанарын өөрчлөлт гарав. Тухайн үед олон улсын харилцааны дэг журам шинээр бүрэлдэн бий болж, Монгол Улс, БНХАУ, ОХУ нь гадаад улс төрийн бодлогоо шинээр тодорхойлсон нь гурван орны хоорондын харилцаанд ч шууд тусгалаа олсон юм. Нөгөөтэйгүүр хүйтэн дайны дараах гурван улсын харилцаа хоёр талт харилцаагаар тодорхойлогдож байсан ч хоорондын харилцаанд тус бүрийн хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэсээр байсан хийгээд байгаа нь ерөөс энэ гурван улс нь геополитикийн нэг орон зайд багтдагтай шууд хамааралтай болно.

ЗХУ задарч Монгол Улсын гадаад орчинд шинэ нөхцөл байдал үүссэнээр ЗХУ-ын улс төр, эдийн засаг болон үзэл суртлын нөлөөнөөс гарч, Монгол Улсад өөрийн сонгосон замаар хөгжих түүхэн нөхцөл бүрэлдэн бий болов. Монгол Улс нь газар зүйн хувьд Орос, Хятад хэмээх хоёрхон хөрштэй нь түүхээсээ аваад Монголын гадаад бодлогод маш чухал хүчин зүйл болсоор ирсэн. Иймээс ч Монгол Улс гадаад бодлогоо шинээр тодорхойлохдоо газар зүйн онцлог, түүхийн уламжлалынхаа дагуу хоёр хөршөө гадаад бодлогынхоо чухал хүчин зүйл гэж үзэж эдгээр орнуудтай харилцах харилцаагаа тэргүүлэх чиглэл хэмээн тунхаглан зарлаж, шинэ нийгэм байгуулахдаа ямартай ч хоёр хөрштэйгээ эрх тэгш үндсэн дээр харилцан ашигтай харилцаа тогтоохыг эрмэлзэн ийнхүү тунхагласан юм. Чингэхдээ энэ хоёр улстай адил зайнаас харилцах зарчмыг баримтлахаа[1] ч мөн онцлосон билээ.

Монгол Улс гуравдагч хөршийн бодлого баримтлахаа зарлаж, хоёрхон хөрштэй хиллэсэн газар зүйн өвөрмөц байрлалынхаа улмаас ихэнхдээ тэдэнд дулдуйдан оршин тогтнож байсан түүхэн нөхцлөөсөө гарч тусгаар тогтнолоо бэхжүүлэн хамгаалах, эдийн засгаа хөгжүүлэх таатай нөхцөл байдалтай золгов. Хоёр хөрш маань

[1] Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Улаанбаатар, 1994.

ч Монгол Улстай харилцахдаа гадаад орчинд шинээр үүссэн нөхцөл байдлаа харгалзах болов.

1990-ээд оноос хойших манай улсын хөршүүддээ хандсан харилцааг ерөнхийд нь авч үзэхэд хоёр их хөрш маань Монгол Улсын тодорхойлсон гадаад бодлогын чиглэл, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг ямагт хүндлэн харьцаж ирснийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд гурван улсын улс төр, эдийн засгийн дотоод, гадаад хөгжлийн зорилт, олон улсын нөхцөл байдлын өрнөл, онцлог зэргээс хамааран хоорондын харилцаанд нь багагүй өөрчлөлт гарсан бөгөөд өдгөө энэхүү харилцааг тодорхой хэмжээнд үечилж болохоор байна. Энэ нь гурван улсын хамтын ажиллагааны хөгжил, харилцааны үр өгөөж, нөөц бололцоо, тулгамдсан асуудлуудыг олж харахад ач холбогдолтой юм.

Бид энэхүү харилцааг үечлэхдээ юуны түрүүнд олон улсын харилцаанд гарсан болон гарч буй үндсэн өөрчлөлт, хоёр хөршийн дотоод, гадаад бодлогоос улбаатай зарчмын өөрчлөлтүүд гурван улсын харилцаанд хэрхэн нөлөөлсөн болон нөлөөлж байгааг эш үндэс болгон харилцааны үе шатыг тодорхойлохыг оролдов. Чингэхдээ Монгол Улс хөгжлийн чиг хандлагаа тодорхойлох, хөгжлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхдээ гадаад бодлогодоо хоёр хөршийн улс төр, эдийн засгийн хүчин зүйлийг хэрхэн харгалзан үзэж, ашиглаж ирснийг эш үндэс болгов. Хүйтэн дайны дараах гурван улсын харилцааг барагцаалан гурван үед хуваан тэдгээр харилцаанд гарсан өөрчлөлтүүд, онцлогийг доорх байдлаар тодорхойлохыг оролдов.

## Нэгдүгээр үе (1991-2011 он)

Хэдийгээр хүйтэн дайны дараа Монгол, Хятад, Оросын харилцаа гурвалсан харилцааны хүрээнд явагдаагүй боловч харилцан уялдаатай байж нөхцөлдөн хөгжсөөр байсан нь бидний дээр тэмдэглэснээр гурван орон геополитикийн нэг орон зайд багтдаг,





хөрш зэргэлдээ орнуудын хувьд улс төр, эдийн засгийн харилцан хамааралтай байдагтай холбоотой. Үүний нэг жишээ бол БНХАУ-ын Засгийн газар Монгол Улсаас цэргээ гаргах нөхцөлд ЗХУ-тай харилцаагаа сэргээх тухай шаардлага тавьж байсан зэрэг юм. Нөгөөтэйгүүр 1991 онд ЗХУ задарч, ОХУ байгуулагдсаны дараа Монгол дахь Оросын нөлөө багасахад Хятад улс тэрхүү орон зайг дүүргэхийг хичээж байсан нь хоёр хөршийн аль аль нь Монгол Улсад өөрийн ашиг сонирхолтой байсаар ирснийг харуулж буй зүйл юм.

ЗХУ 1991 онд задарч, "Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл" (ЭЗХТЗ) үйл ажиллагаагаа зогсоосон, мөн үүнээс өмнөхөн ЗХУ-ын зүгээс 1980-аад оны сүүлчээр Монголын эд бараанд гаалийн татварыг нэмэгдүүлснээр Монголын эдийн засаг гүнзгий хямралд орсон. БНМАУ нэг улсаас хэт хамааралтай байсны хор уршиг чухам энэ үед илтээр мэдэгдсэн юм. Монголд өрнөсөн ардчилсан хувьсгалын үсэр улс орноо ямар замаар хөгжүүлэх асуудал хурцаар тавигдаж, зах зээлийн замыг сонгож авсан болно. Гэвч тухайн үед улс орныг хөгжүүлэх тодорхой төсөөлөл хараахан бүрдэж амжаагүй, зах зээлийн эдийн засгийн зүй тогтлын талаарх мэдлэг дутмаг, зах зээлийн удирдлага менежментийг эзэмшсэн боловсон хүчин байгаагүй зэргээс хамаарч Монголын эдийн засагт хүндрэл үүссэнээр үл барам цаашдын хөгжилд ч маш олон асуудлыг дагуулсан. Харамсалтай нь энэ үед ЗХУ-ын тусламжаар бий болсон аж үйлдвэрийн чиглэл бүхий эдийн засгийн суурь нуран унаж, ашигт малтмалын салбарыг хөгжүүлэх нэрийдлээр ашигт малтмалын бүтээгдэхүүний экспортлолт Монгол Улсын эдийн засгийн гол чиглэл болон хувирав.

Тухайн үед Монгол Улс эдийн засагтаа учирсан хямралыг даван туулахын тулд Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк болон Япон, АНУ, Герман зэрэг улстай хамтран ажиллаж, мөн БНХАУ-тай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргүүлэх болов. Монгол Улс, БНХАУ-ын харилцаа, хамтын ажиллагааны үндэс суурь нь 1994 онд байгуулагдсан Монгол-Хятадын найрамдал, хамтын ажиллагааны гэрээ байв. Тухайн үед Хятадад ид өрнөж байсан шинэчлэлийн

бодлогыг хэрэгжүүлэхэд их хэмжээний түүхий эд шаардлагатай байсан нь Монгол Улс эрдэс баялагаа гадагш нь зөөх бодлоготой яв цав нийцэж, хоёр орны хооронд худалдаа-эдийн засгийн чиглэлээр маш эрчимтэй хамтын ажиллагаа өрнөв. Чухам энэ үед Хятад улс Монголын хамгийн том худалдааны түнш, хөрөнгө оруулагч болж хувирах эхлэл тавигдсан болно.

Нөгөөтэйгүүр тухайн үед БНХАУ-ын геополитикт таатай нөхцөл үүссэн нь хөрш зэргэлдээ Монгол Улсад Оросын нөлөө багассанаар Монголын гадаад орчинд үүссэн орон зайг эзлэн авах боломж бий болов. ОХУ-ын гадаад бодлого Өрнөдийн орнууд руу чиглэж барууны зах зээл дээр гарах сонирхолтой байсан зэрэг нь Монгол Улсын талаар явуулж байсан бодлогод нь шууд нөлөөлж, Монголын талаарх байр суурь нь идэвхигүй болсон юм. Хэдий Монголд Хятадын бодлого идэвхжиж, хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа эрчимжиж, улмаар Оросын эрх ашгийг хөндөж ирсэн ч ОХУ тухайн үед Монгол Улсын талаар идэвхгүй байр суурьтай байсаар байв. Монгол Улсын гадаад, дотоод нөхцөл байдлын талаар тухайн үед судалгаа хийж байсан барууны судлаачид бүтээл туурвилдаа Монгол дахь Оросын оролцоо, Оросын сигментийг онцгойлон дурдаагүй нь Монгол-Оросын харилцаа ямар түвшинд орсныг харуулах нэг үзүүлэлт юм[2]. Үүнийг мөн ОХУ-ын 1993 онд батлагдсан "Гадаад бодлогын үзэл баримтлал"-д Монгол Улсын талаар огт дурдаагүйгээс[3] ч харж болох юм.

Ийнхүү ЗХУ задарч түүний орон зайд байгуулагдсан ОХУ нь манай улсын хоёр хөршийн нэг болов. ЗХУ задарч түүний нэг чухал субьект байсан ОХУ өөрийн хөгжлийн чиглэлээ, түүн дотор гадаад

[2] Campi. A.A, "Mongolia in Northeast Asia-the NewRealities", *Geopolitcal relations between Contemporary Mongolia and Neighboring Asian Countries*, Chinese Culture University, Taiwan, 2004.; Fish.M.S, "The Inner Asia anomaly: Mongolia's democratization in comparative perspective", *Communist and Post-Communist Studies*, 2001, №34; Ginsburg.T, "Political Reform in Mongolia beetween Russia and China", *Asian Survey*, 1995, №5

[3] "Основные положения концепции внешней политики РФ утвержден распоряжением Б.Н.Ельцина от 23 апреля 1993г", *Внешняя политика и безопасность современной России (1991-2002)*, Хрестоматия в 4-х томах, Документы, М.,2002.





бодлогоо цоо шинээр тодорхойлох болсон. Монгол Улс өөрийн хөгжлийн замаа шинээр сонгосон зэрэг нь хоёр орны харилцаанд шинэ нөхцөл байдлыг үүсгэв.

Монгол Улс, ОХУ-ын хооронд байгуулагдсан "Найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай тунхаглал", 1993 оны "Монгол Улс, ОХУ-ын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ" хоёр орны харилцааны үндэс суурь болж өгсөн ба тухайн үед хоёр орны харилцааны түвшин доогуур байснаас гадна хоёр орны хооронд өрийн асуудал хурцаар тавигдаж эхэлсэн.

Манай хөрш хоёр орон ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцааны хувьд гэвэл хоёр орон бие биенээ "нөхөрсөг улс" хэмээн хүлээн зөвшөөрсөн "ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцааны үндсийн тухай хамтарсан тунхаглал" (2000), мөн "ОХУ, БНХАУ-ын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ (2001) болон 1964 оноос эхэлсэн хоёр талын хилийн маргааныг дуусгавар болгосон "ОХУ, БНХАУ хоорондын улсын хилийн зүүн хэсгийн нэмэлт хэлэлцээр" (2004) байгуулагдсан нь хоёр орны харилцааг хэвийн болгох үндэс суурийг тавьсан болно. Гэвч хоёр орны харилцаа тухайн үедээ ч мөн цаашид ч тодорхой хугацаанд эрчимтэй хөгжиж чадаагүй. Хэдий тийм боловч хоёр хөрш орны харилцаа хэвийн болж тогтворжсон нь манай улсын гадаад орчин баталгаажих нааштай нөхцөл байдлыг үүсгэв. Нөгөөтэйгүүр ЗХУ задарсны дараа ОХУ нь Монгол Улсын талаар идэвхитэй бодлого, хамтын ажиллагаа хэрэгжүүлээгүй нь Монголд Хятадын хүчин зүйл нэмэгдэх үндсэн нөхцөлийг бий болгосон. Монгол Улс нь гадаад бодлогын тунхаглалдаа үнэнч байж, БНХАУ, ОХУ-тай харилцах харилцаагаа гадаад бодлогынхоо тэргүүлэх чиглэлээ хэмээн үзэж хоёр хөрштэйгээ эрх тэгш үндсэн дээр харилцахыг эрмэлзсээр ирсэн юм.

Ийнхүү ЗХУ задарч, хүйтэн дайн дуусгавар болсны дараа үе буюу 1991-2000 оны эхний 10 жилийн хугацаан дахь Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын харилцаа, харилцан хамаарлыг дүгнэхэд энэ үед Монгол Улс хоёр хөрштэйгээ найрамдал, хамтын ажиллагааны үндэс суурийг тавьснаас гадна манай хоёр хөршийн харилцаа ч мөн хэвийн байдалд

шилжиж ирээдүйн гурамсан харилцааны суурь тавигдах үндсэн нөхцөл бүрэлдсэн хэмээн үзэж болохоор байна.

## Хоёрдугаар үе (2012-2016 он)

Тухайн үед гурван улсын хоорондын харилцаа хоёр талт харилцааны хэлбэрээр хөгжиж ирсэн боловч 2012 оноос гурван талт харилцаа, хамтын ажиллагааны чиглэл бүрэлдэн бий болж эхэлсэн. Тухайн үеийн гурван талт харилцааны хамгийн өндөр түвшний механизм бол Монгол, Орос, Хятад хөрш гурван орны Гадаад хэргийн яамдын гурван талт харилцаа байв. 2012 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Москва хотноо гурван улсын Гадаад хэргийн яам хоорондын найм дахь удаагийн зөвлөлдөх уулзалт анх удаа албан ёсны статустайгаар явагдсанаар гурван талт харилцааны механизм бүрэлдэн бий болсон байна. Тус зөвлөгөөнөөр гурван улсын хооронд улс төрийн болон түүхийн талаас шийдвэрлэгдээгүй асуудлууд байхгүйг талууд тэмдэглэж, цаашид гурван тал бие биенийхээ бүрэн эрх, аюулгүй байдал, язгуур эрх ашигтай холбоотой болон гурван улсын харилцаанд ач холбогдол бүхий асуудлаар харилцан хэлэлцэх, дэмжлэг үзүүлж ажиллахаа илэрхийлэв. Цаашид гурван тал худалдаа, эдийн засаг, хүмүүнлэгийн зэрэг салбарт хамтын ажиллагаа, солилцоог хөгжүүлэх, худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээнд уул уурхай, дамжин өнгөрөх тээвэр, дэд бүтцийн бүтээн байгуулалт, аялал жуулчлал, байгаль орчныг хамгаалах зэрэг салбарт гурван талт хамтын ажиллагааг өрнүүлэх нь чухал гэж тэмдэглэсэн. Энэ чиглэлээр манай улсын зүгээс зарим нэгэн асуудлыг ажил хэрэг болгох санаачилга гаргаж байсан ба тухайлбал НҮБ-ын Худалдаа хөгжлийн байгууллага, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр Монгол, ОХУ, БНХАУ-ын хооронд транзит тээврийн гурван талт суурь хэлэлцээр санаачлан эхлүүлж энэ хүрээнд яриа хэлэлцээр явуулж төслийг үндсэндээ тохироод байсан боловч тодорхой





шалтгаанаар хойшлогджээ[4].

Тухайн үед гурвалсан хамтын ажиллагаа бодит ажил болж өгөхгүй байсан нь гурван орны хоорондын хоёр талт харилцаанаас ихээхэн хамаарч байв.

1. Хятад-Оросын тухайн үеийн хоёр улсын хоорондын харилцааны онцлогийг дурдваас, БНХАУ, ОХУ-ын хооронд дээд хэмжээний стратегийн түншлэлийн харилцаатай, олон улсын тавцанд хоёр улсын нэгдмэл эрх ашгийг харилцан хамгаалдаг, дэлхийн хэмжээний тулгамдсан асуудлаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл дээр нэг байр сууринаас хандлаг, зарим судлаачдын үзэж байгаагаар Ази дахь олон улсын асуудлаар хоёр орны албан ёсны байр суурь ижил төстэй, НҮБ-ын шинэчлэлийн асуудлаар нэгдмэл байр суурьтай, бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд ШХАБ, БРИКС-ийн хүрээнд хамтын ажиллагаа хэрэгжүүлдэг. Мөн ОУВС, Дэлхийн Банкны үйл ажиллагааг орлуулах өөр төрлийн олон улсын механизмыг байгуулах санал болон Орос, Хятад улсын оролцоотой долларыг газрын тосны худалдаанд хязгаарлах буюу хэрэглэхгүй байх тал дээр тус тус санал нэгддэг. Ази дахь газар нутгийн талаарх БНХАУ-ын маргаан дээр ОХУ дундын байр суурінаас найрсагаар хандаж буйд талархдаг.

Хэдий тийм болович хоёр орны хооронд зөрчил, өрсөлдөөн оршсоор байсан бөгөөд тэдгээр нь зарим талаар намжмал өнгө аястай болсон ч өнөөг хүртэл хадгалагдсаар байгааг тэмдэглэх хэрэгтэй. Тэдгээрийн заримаас дурдахад БНХАУ-ын зарим нэгэн томоохон хэмжээний төслүүд нь хэдий ОХУ-ын эрх ашгийг шууд хөндөхгүй ч Орос, Хятадын хүчний харьцаанд шууд нөлөөлж буй явдал. Тухайлбал, БНХАУ Төв Азийн орнуудтай худалдаагаа либералчилсан, газрын тос, байгалийн хийн хоолойг барьж байгуулсан, дэлхийн өнцөг бүрд Хятадын төрийн өмчит компаниуд ашигт малтмалын олборлолтод оролцож байгаа; ОХУ-ын оролцоогүйгээр БНХАУ-ыг Төв Азийн бүс нутгаар дамжуулан

[4] ГХЯ-ны сайд Л.Болдтой хийсэн ярилцлага, *Өнөөдөр сонин*, Улаанбаатар, 2013.09.09.

шалттаанаар хойшлогджээ[4].

Тухайн үед гурвалсан хамтын ажиллагаа бодит ажил болж өгөхгүй байсан нь гурван орны хоорондын хоёр талт харилцаанаас ихээхэн хамаарч байв.

1. Хятад-Оросын тухайн үеийн хоёр улсын хоорондын харилцааны онцлогийг дурдваас, БНХАУ, ОХУ-ын хооронд дээд хэмжээний стратегийн түншлэлийн харилцаатай, олон улсын тавцанд хоёр улсын нэгдмэл эрх ашгийг харилцан хамгаалдаг, дэлхийн хэмжээний тулгамдсан асуудлаар НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл дээр нэг байр сууринаас ханддаг, зарим судлаачдын үзэж байгаагаар Ази дахь олон улсын асуудлаар хоёр орны албан ёсны байр суурь ижил төстэй, НҮБ-ын шинэчлэлийн асуудлаар нэгдмэл байр суурьтай, бүс нутгийн болон дэлхийн хэмжээнд ШХАБ, БРИКС-ийн хүрээнд хамтын ажиллагаа хэрэгжүүлдэг. Мөн ОУВС, Дэлхийн Банкны үйл ажиллагааг орлуулах өөр төрлийн олон улсын механизмыг байгуулах санал болон Орос, Хятад улсын оролцоотой долларыг газрын тосны худалдаанд хязгаарлах буюу хэрэглэхгүй байх тал дээр тус тус санал нэгддэг. Ази дахь газар нутгийн талаарх БНХАУ-ын маргаан дээр ОХУ дундын байр сууринаас найрсагаар хандаж буйд талархдаг.

Хэдий тийм боловч хоёр орны хооронд зөрчил, өрсөлдөөн оршсоор байсан бөгөөд тэдгээр нь зарим талаар намжмал өнгө аястай болсон ч өнөөг хүртэл хадгалагдсаар байгааг тэмдэглэх хэрэгтэй. Тэдгээрийн заримаас дурдахад БНХАУ-ын зарим нэгэн томоохон хэмжээний төслүүд нь хэдий ОХУ-ын эрх ашгийг шууд хөндөхгүй ч Орос, Хятадын хүчний харьцаанд шууд нөлөөлж буй явдал. Тухайлбал, БНХАУ Төв Азийн орнуудтай худалдаагаа либералчилсан, газрын тос, байгалийн хийн хоолойг барьж байгуулсан, дэлхийн өнцөг бүрд Хятадын төрийн өмчит компаниуд ашигт малтмалын олборлолтод оролцож байгаа; ОХУ-ын оролцоогүйгээр БНХАУ-ыг Төв Азийн бүс нутгаар дамжуулан

[4] ГХЯ-ны сайд Л.Болдтой хийсэн ярилцлага, *Өнөөдөр сонин*, Улаанбаатар, 2013.09.09.





анх удаа албан ёсоор тодорхойлон хоёр орны харилцааг эрчимжүүлэх талаар байр сууриа илэрхийлсэн байдаг. Түүнд өгүүлсэн нь: "ОХУ бол Хятадын стратегийн холбоотны хувьд байр суурь дээрээ баттай зогсож байгаа боловч эдийн засаг худалдааны салбарт болон Төв Азийн бүс нутаг дахь улс төрийн байр суурь нь Хятад улсынхаас зөрүүтэй. Хэдий тийм боловч тус бүрдээ ижил төстэйг нь сонгон авч ялгаатай зүйлээ орхиж, хоёр талын харилцаанд нэгдмэл эрх ашиг зөрчлөөс хавьгүй их байгааг харгалзан стратегийн харилцан итгэлцлийг бэхжүүлэх, хамтын ажиллагааны практик үйл ажиллагааг нэмэгдүүлэхээр эрмэлзэж буй нь хоёр талын маш том хамтын ойлголцол юм"[6] гэжээ.

Ийнхүү БНХАУ-ын гадаад бодлогын санаачилгууд гурван талт харилцаанд шинэ нөхцөл байдлыг үүсгэсэн нь тус гурван улсын хоорондын хоёр талт харилцаанд ч шинэ хандлагуудыг бий болгов. Тухайн үед Оросын тал Монголыг илүүтэй сонирхож эхэлсэн ба дээд хэмжээний хэд хэдэн айлчлал нь ОХУ нэгэн цагт Монголд алдсан өөрийн орон зайг эргүүлэн авах сонирхолтой байгааг харуулав. Энэхүү байдал манай хөрш БНХАУ-ын анхаарлыг зүй ёсоор татсан нь мэдээж. ОХУ гэнэт Монгол Улс руу чиглэсэн идэвхитэй бодлого хэрэгжүүлсэн нь газар доорх баялгийг нь сонирхохоос гадна геостратегийн хувьд Монголыг алдахгүй гэсэн Оросын гадаад бодлогын чиглэлээр тайлбарлагдаж байв. ОХУ нь эдийн засгийн хувьд бэхжихийн сацуу дэлхийн хэмжээнд идэвхитэй гадаад улс төрийн бодлого явуулж, өөрийн орон зайгаа тэлэн бэхжүүлэх бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Үүнтэй уялдаатай ОХУ хил залгаа хийгээд удаан жил өөрийн нөлөөнд барьж байсан Монгол Улсыг нөлөөнөөсөө гарахаас болгоомжилсон нь ойлгомжтой. Хэрэв чингэвээс олон зуун жилийн уламжлалтай Монголын талаар явуулж ирсэн Оросын бодлого талаар болж түүний геостратегийн бодлогод хохирол учирна гэсэн үг.

ОХУ-ын Монгол Улсын талаарх бодлого эрчимжсэн нь зөвхөн

[6] "Гурван улсын Ерөнхий сайд нар Хятадад нэгэн зэрэг хийсэн айлчлал юу өгүүлэв?", *Жэньмин жибао*, 2013.10 дугаар сарын дугаар.

БНХАУ Монголтой идэвхитэй харилцаа өрнүүлсэнд бус Монгол Улс нь гуравдагч хөршийн бодлогоо тууштай баримталж байснаас гадна гадаад орчинд нь шинэ нөхцөл байдал үүссэнээр тайлбарлагдана. Энэ нь олон улсын хүчний харилцаанд үүссэн хүчний шинэ хуваарилалттай ч холбоотой юм.

Оросын улс төрийн коньюктурын судалгааны тэргүүлэх шинжээч Е.Войко Монголын талаарх Оросын бодлогын баримталж буй бодлогын талаар "Хэдий Монгол Улс нь ашигт малтмал, байгалийн онцгой их нөөц баялаг байхгүй боловч томоохон геополитикийн тоглогч болох их гүрнүүдийн хурц өрсөлдөөний бай болоод байна. Өнөөдөр Монгол нь Оросын сонирхолын хүрээлэлд багтаж байгаа болович БНХАУ болон АНУ нь Монголыг Ази дахь түрэмгийллийнхээ түшиц газар хэмээн үзэж түүнийг өөрийн хяналтанд оруулахыг чармайж байна. ЗХУ энэ нутгийг орхиж явснаас хойш Өмнөд Солонгос, Япон мөн түүнд санаархаж байгаа билээ. Монголчууд өөрсдөө Оросыг итгэл даах, ашигтай түнш хэмээн үздэг. Нөгөөтэйгүүр, Монгол Улс нь БНХАУ-тай хиллэдэгийн хувьд ОХУ-тай нягт харилцаа тогтоосноор хил орчмоороо Оросын хүчин зүйлийг нэмэгдүүлэх юм. Монголын төлөө тэмцлийг Хятадын удирдлага явуулж байгаа бөгөөд Монгол Улстай хийж буй эдийн засгийн хамтын ажиллагаа нь Орос-Монголын хамтын ажиллагаатай харьцуулахад тоон үзүүлэлт, хэмжээгээрээ их юм. Хятадаар дамжин Монголын маш их хэмжээний ачаа тээвэр бусад орон руу чиглэдэг, Хятадын хөрөнгө оруулагчид Монголд маш идэвхитэй ажиллаж байна. Чингэхдээ Оросын бизнесменүүдийг бодвол Хятадын ажил хэрэгч хүмүүс нь улсын, хувийн гэхгүй том, дунд жижиг салбарт аль алинд нь анхаарлаа хандуулдаг"[7] гэжээ.

Үнэхээр бидний дээр тэмдэглэснээр сүүлийн жилүүдэд Монголыг тойрсон олон улсын чанартай өрсөлдөөн бий болсон нь дэлхийн хэмжээнд явагдаж буй хүчний шинэ хувиралттай холбоотой. Нөгөөтэйгүүр зөвхөн геополитикийн хувьд их гүрнүүдийн анхааралд байсан Монгол нь гадаадынхны эдийн засгийн ашиг сонирхолыг

[7] https://www.russian council.ru/





төрүүлэх болсон юм. Чингэхдээ хоёр хөршийн болон зарим гуравдагч орнуудын манай улсын талаар явуулж буй бодлого нь зөвхөн эдийн засгийн ашиг сонирхолоос үүдэн гарч буй биш энэ сонирхол илүү өргөн утгатай нь мэдээж.

Юуны түрүүнд хоёр хөршийн бодлогод эдийн засаг, улс төр, геополитикийн ашиг сонирхолын нийлбэр, гео-эдийн засгийн ашиг сонирхол манай оронд төвлөрч ирж байгааг илтгэж байна. ОХУ өнгөрсөн үе, ялангуяа XX зууны үеийн түүхийг зарим орнууд "засварлах" гэсэн оролдлого хийж буйг буруушааж, хөрш зэргэлдээ орнуудтай тогтоож буй харилцаагаа дайсны эсрэг хамтран тэмцэж явсан өнгөрсөн үеийн түүхэн дурсамж, эдийн засгийн тусламж зэргийг эш үндэс болгон хоёр орны харилцааг түүхэн талаас нь үндэслэн "харилцааны уламжлал" хэмээн хүчин зүйлийг бий болгох бодлого баримтлах болов. Манай улс ч гэсэн Оросын энэхүү бодлогыг дэмжих нь бодит байдал дээр хоёр ард түмний туулсан түүхэн замналыг сануулж, хоёр улсын найрамдалт харилцааг бэхжүүлэх, харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны маш чухал дэвсгэр болж өгөх талтай гэж үзэж буй. Нөгөөтэйгүүр энэ нь Оросын зөөлөн хүчний бодлого бөгөөд улс төр, эдийн засгийн харилцааг идэвхжүүлэхэд чухал хөшүүрэг болох ёстой ажээ.

Ийнхүү тухайн үеийн Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын хоорондын харилцааг дүгнэхэд, хоёр хөрш орны зүгээс манай улстай харилцаагаа бэхжүүлэх сонирхол нь тэдгээрийн эдийн засаг, гадаад улс төр, геополитикийн эрх ашиг зэргээр тайлбарлагдах ба үүн дээр манай улсын ашиг сонирхол ч харилцан нөхцөлдөж ирсэн юм.

**Гурав дахь үе ( 2016 оноос өнөө үе)**

Орчин үед манай хоёр хөрш орны гадаад улс төрийн бодлого, үйл ажиллагаа тэлж дэлхийн тавцанд глобал бодлогын томоохон тоглогчид болоод байна. Энэхүү хоёр орны харилцаа улам ойртон бэхжиж байгаа нь манай гурван улсын худалдаа, эдийн засгийн

харилцаа, хамтын ажиллагаанд ч чухал хөшүүрэг болж өгөх ёстой. Гурван орны хооронд өнөөгийн байдлаар хүчтэй яригдаж буй хамтын ажиллагааны төсөл бол эдийн засгийн нэгдсэн коридор болно. Тэгвэл энэхүү эдийн засгийн нэгдсэн коридор хэрэгжих үндэс суурь юу вэ гэсэн асуудал зүй ёсоор урган гарч ирэх ба энэ нь гурван улсын гурвалсан харилцааны өнөөгийн үе шатны зангилаа асуудал юм. Энэхүү төсөл нь манай гурван улсын дээд удирдлагын хүрээнд улс төрийн шийдлээ олчихоод байгаа. Гэвч энэхүү төсөл хэрэгжилтээ хүлээсээр байгаа бөгөөд төсөл хэрэгжих үндэс суурь нь манай хөрш хоёр орны гадаад дотоод бодлогын зорилго болон хоорондын харилцааны уялдаа холбоо, хамаарлаас ихээхэн шалтгаалах юм. Манай улсын хувьд хоёр хөрштэйгөө харилцан ашигтай эдийн засгийн коридортой болох нь түүхээсээ аваад эрмэлзэж байсан зүйлийн нэг мөн.

Энэхүү төслийг манай өмнөд хөрш БНХАУ-ын гадаад бодлогын зорилго, чиглэлийн өөрчлөлттэй холбон авч үзэх нь зүйтэй. БНХАУ-ын эдийн засаг хөгжихийн хэрээр дэлхийн тавцанд үйл ажиллагаа өсөн нэмэгдэж, "глобал засаглал"-ын хэмжээнд өөрийн оролцоог үнэлэх болоод байгаа ба гадаад улс төрийн практик үйл ажиллагаа нь ч энэ чиглэлд хэрэгжих болсон. БНХАУ "баян чинээлэг хөрш" хөтөлбөрийг зарлан хөрш зэргэлдээ орнуудтай түншийн харилцаагаа эрчимжүүлж, тэдгээртэй янз бүрийн түвшний стратегийн харилцаа байгуулах замаар улс төр, эдийн засгийн харилцаагаа хөгжүүлэх, өөрийн нөлөөгөө өсгөх зорилго тавьж байна. БНХАУ-ын дэвшүүлсэн "Нэг бүс, нэг зам" бодлого нь Хятадын бүсчилсэн бодлогын концепци бөгөөд уг төсөлд Хятадтай найрсаг харилцаатай, эдийн засгийн хувьд ашиг сонирхол нь нэг, бие биеэ нөхсөн, харилцан хамааралтай орнууд орж байгаа болно. Манай гурван улсын дээд удирдлагын хүрээнд улс төрийн шийдлээ олчихоод байгаа эдийн засгийн коридорын энэхүү төсөл "Нэг бүс, нэг зам" бодлого Хятадын гадаад эдийн засгийн маш том стратегийн хүрээнд хэрэгжих нь мэдээж. Учир нь энэхүү стратеги бол БНХАУ-ын дотоод хөгжилтэй маш их уялдсан тодорхой үе шаттай, маш сайн системчлэгдсэн бүс нутгийн бодлого бөгөөд энэхүү коридорын бүтээн байгуулалтыг ч





тэрхүү стратегийн хүрээнд авч үзэх болов уу.

ОХУ-ын хувьд ЗХУ задарснаас улбаалан олон улсын тавцан дээрх нөлөө эрс багассаныг нөхөх, алдагдсан нөлөөгөө сэргээх зорилго бүхий гадаад бодлого хэрэгжүүлсэн ба энэ чиглэлд амжилт олохын зэрэгцээ олон улсын хамтлагийн зүгээс шүүмжлэл эсэргүүцэлтэй тулгарч улс төр, эдийн засгийн хоригт ороод байгаа болно. Гадаад бодлогын хэрэгжүүлэлтэд хэт их анхаарал чиглүүлсний улмаас Өрнөдийн орнуудын хоригт өртөж эдийн засгийн байдал нь хүндэрч эдийн засгийн өсөлт нь 2 хувь хүртлээ буурсан. Сүүлийн үед ОХУ, БНХАУ-тай харилцаа, хамтын ажиллагаагаа нэлээд эрчимжүүлэх хандлагатай байгаа нь хөрш зэргэлдээ орнуудын хооронд байх ердийн харилцаа, эдийн засгийн хувьд харилцан хамааралтай байдаг ерөнхий зарчимд нийцэж байгаа боловч ОХУ-д АНУ болон Өрнөдийн орнуудын зүгээс үзүүлж буй хоригийн улмаас БНХАУ-тай хамтын ажиллагаа өргөнүүлэх сонирхол нь нэмэгдсэн гэж хэлж болно. Ийнхүү ОХУ Азийн чиглэлд бодлогоо эрчимжүүлэх шаардлага гарч ирсэн ба гурвалсан эдийн засгийн коридорын үзэл баримтлал ч үүнтэй уялдаатай бий болсон гэж хэлж болно. Монгол Улсын хувьд бидний дээр тэмдэглэсэнчлэн хоёр хөрш орнтойгоо харилцан ашигтай эдийн засгийн коридортой болох нь энэхүү хоёр орны хооронд хавчуулагдан орших газар зүйн хувьд, хязгаарагдмал байрлалтай улсын хувьд маш чухал ач холбогдолтой.

Хоёр хөрш орон маань глобал бодлого явуулдаг хоёр том гүрний хувьд гадаад улс төр, эдийн засгийн хувьд хэдий өөр өөрийн ашиг сонирхолтой боловч одоогоор АНУ-ын нөлөөлөл, "манлайлал"-ыг эсэргүүцэн "олон улсын системд тэнцвэр"-ийг бий болгох зарчимд ойртож байгаа болно. Орос, Хятадын энэхүү байр суурь бүр 1997 онд хоёр орны зүгээс олон улсын шинэ дэг журам төлөвшүүлэх ба олон туйлт ертөнцийн талаарх хамтарсан мэдэгдэл гаргаж байснаас эхлэлтэй.[8] Энэхүү байр суурь нь өнөөгийн шинэ нөхцөлд улам эрчимжиж байгаа бөгөөд тэдгээрийг АНУ-ын эсрэг байр суурин

[8] А.Нямдолжин, "Орчин үеийн Орос-Америкийн харилцаа: хязгаарагдмал түншлэл", *Pax Mongolica. Монгол энх төр*, Улаанбаатар, 3(2017).

дээр нэгдэж байна хэмээн олон улсын шинжээчид үзэж байгаа юм. Хэдий тийм боловч Орос, Хятадын харилцааг тийм бат бөх биш гэдгийг мөн онцолсоор байна. Тэдний үзэж буйгаар энэ хоёр орон өрсөлдөгч том гүрнүүд, иймээс хоёр орны харилцааны түлхүүр үг нь "өрсөлдөөн" бөгөөд тэдний ойртолт нь бодит биш. Эдгээр хоёр орон нь Төв Ази, Ойрхи Дорнод дахь нөлөөний төлөө өрсөлдөж байгаа, мөн Хятадын хүн ам их, түүхий эдээр маш гачигдаж буй учир хүн ам цөөнтэй Сибирийг анхаарлын төвдөө байлгадаг, цаашид Хятадын нөлөө энэ бүсэд байнга нэмэгдэх болно. Иймээс Хятад хүчирхэгжихийн хэрээр Оросын эрх ашгийг хөндөх болно гэдгийг тэмдэглэж байна. Райс Хадли Гэйт компаний (Rice Hadley Gates) судлаач Аня Мануэл "Атлантик" сэтгүүлд бичсэнээр сонин хэвлэлээр шуугиж байгааг эс тооцвол Орос, Хятадын хооронд АНУ, Япон, Европын холбооны улсуудын хоорондын харилцаа шиг тийм ойр харилцаа байхгүй гэдгийг онцолжээ.[9] Мөн Азийн судалгааны үндэсний товчооны (National Bureau of Asian Research) мэдээлж буйгаар, тэдгээрийн хооронд цэрэг, эдийн засгийн интеграци байхгүй боловч гадаад бодлогоо сүүлийн үед маш сайн уялдуулж байна. Тухайлбал, Алс Дорнодод бүс нутгийн зангилаа асуудлаар өөрсдийн байр сууриа ойртуулж байгаа нь Өрнөдийн орнуудын зүгээс тэдний геополитикийн эрмэлзлэлийг хазаарлах бодлогыг эсэргүүцэж байгаагийн илэрхийлэл юм. Гэвч тэдний ашиг сонирхол харилцан өөр, тэд жинхэнэ ашиг сонирхолоо одоохондоо хойш тавьж байна[10] гэжээ.

Ийнхүү хоёр хөрш орны харилцаа ойртон нэгдэж байгаа нь манай улсын гадаад ойрын орчинд шинэ нөхцөл үүсч байгаагийн нэг илрэл юм. Гэвч энэхүү нөхцөлд гурван орны хоорондын эдийн засгийн хамтын ажиллагаа өрнөх боломж байгаа эсэх асуудал өнөө хүртэл нээлттэй хэвээр байгаа билээ. Учир нь хоёр хөрш орны харилцаанд улс төрийн харилцаа давамгайлж ирсэн бөгөөд эдийн засгийн

[9] Anja Manuel, "It's not too late to Prevent a Russia-China Axis. Here's how the U.S. can avoid during the two countries together", *The Atlantic*, September 14, 2018.

[10] https://www.nbr.org/publication/china-russia-relations-strategic-implications-and-u-s-policy-options/





харилцаа хоцрогдсон хэвээр байна. Эдийн засгийн харилцаанд нь багагүй бэрхшээл оршсоор байгааг судлаачид тэмдэглэсээр байна. БНХАУ нь ОХУ-д хөрөнгө оруулах тэр бүр сонирхолгүй байгааг ОХУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэл мэдээллийн албаны дарга Дмитрий Песковын хэлснээс ч мөн харж болох юм. Тэрээр RT телевизд өгсөн ярилцлагадаа: "Хятад улс Орост хөрөнгө их оруулдаг гэж хэлэхэд хэцүү... манай хоёр орны харилцаанд Америкийн зүгээс манай улсад үзүүлж буй хориг нөлөөлдөг нь ажиглагддаг"[11] гэжээ. Хятад, Оросын хооронд байгуулсан нэлээд олон төсөл хэрэгжээгүй болон эхлэл төдий байгааг Оросын хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон судлаач нар тэмдэглэж байгаа юм. Тухайлбал, БНХАУ "Сибирийн хүч" ("Сила Сибири")-ийн төслийн санхүүжилтийг "Газпром"-д шилжүүлэн өгсөн, "Еврази" (Бээжин-Москва-Берлин) хурдан галт тэрэгний зам тавих төслөөс татгалзсан, хоёр талын хооронд тохиролцож байсан иргэний агаарын том хэмжээний онгоц зохион бүтээх төлөвлөгөө тасарсан ба Амар мөрөн дээгүүр баригдсан галт тэрэгний гүүр нь Оросын талын нэмэлт санхүүжилтээр тухайлбал, "Оросын шууд хөрөнгө оруулалтын сан"-гийн нэмэлт санхүүжилтийн үр дүнд баригдсан зэргийг Оросын тал дурдаж[12] байгаа болно. Алс Дорнодын Институтын орлогч захирал, Хятадын эдийн засаг, нийгмийн судалгааны Төвийн дарга А.Островский "Правда.Ру" сайтад өгсөн ярилцлагадаа: Өнөөгийн байдлаар, манай улс Хятадтай хэрэгжүүлж буй хамтарсан онцын төсөл байхгүй. 2014 онд Москва-Бээжин (Москва, Нижний Новгород, Казань, Екатеринбург, Оренбург хүрээд цаашаа Казахстан орох) хурдан галт тэрэгний төмөр зам байгуулах гэрээ байгуулсан боловч өндөр өртөгтэй, зардлаа нөхөж чадахгүй гэсэн үндэслэлээр энэхүү төслөөс татгалзсан. Оросоос Хятад руу хийн хоолой тавьж байгаа бөгөөд хүчин чадал нь жилд 55 тэрбум. куб байх ажээ. Үүнээс гадна Владивосток, Зарубино дахь усан боомт дахь "Приморье-1", "Приморье-2" хоёр төслөөс өөр төсөл байхгүй энэ төслийг хэрэгжүүлэхийн тулд Амар мөрөн дээгүүр төмөр замын

[11] Песков.Д Интервью RT от 3 июня 2019 года- https://www.pravda.ru/economics/1419900-china/

[12] https://www.pravda.ru/economics/1419900-china/

гүүр барих шаардлагатай ажээ. Ийнхүү хоёр орны эдийн засгийн харилцаа улс төрийн харилцаанаас хоцорч байгаа бөгөөд энэ нь тодорхой шалтгаануудаар тайлбарлагдана. Тэдгээр шалтгаанууд нь хоёр орны харилцаанд оршсоор байсан хүчин зүйл байхаас гадна мөн хоёр орны харилцаанд шинээр үүссэн нөхцөл байдаг.

Хоёр орны харилцаанд шинээр үүссэн нөхцөл байдал бол БНХАУ ОХУ-тай төсөл хэрэгжүүлж байгаад тэдгээрээс гардаг нь ОХУ-тай хамтарсан учир "Америкийн эсрэг этгээдүүдийн үйлдлийг зогсоох санкци" (CAATSA) хэмээх хуулиар хоригт мөн давхар өртдөгтэй холбоотой ажээ.[13] ОХУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэл мэдээллийн албаны дарга Д.Песков Хятад, Оросын эдийн засгийн хамтын ажиллагаанд Америкийн санкци нөлөө үзүүлдэг гэж онцолж хэлсэн байсан нь чухам үүнтэй холбоотой юм. ОХУ-ын Төв банкны мэдээлснээр, 2018 оны байдлаар ОХУ-д БНХАУ-ын зүгээс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 24%-аар буурч 3.592 тэрбум доллараас 2.623 тэрбум доллар хүртэл буурчээ. Нэг жилийн дотор Хятадын хөрөнгө оруулагчид Оросын эдийн засгийн бодит сектороос 969 сая долларыг татан авсан ба үүнээс 80% буюу 774 сая доллар нь хамтарсан үйлдвэрүүдийг татан буулгаснаар татагдан гарсан ба улмаар Оросын компаниуд дахь Хятадын хөрөнгө оруулалт 40% (1.932- 1.158 тэрбум доллар хүртэл) буурсан байна. Үлдсэн 195 сая доллар өрөнд тооцсон[14] байна.

Орост Хятадын хөрөнгө оруулалт хангалтгүй байгааг Оросын шинжээчид хөрөнгө оруулалтын нөхцөл байдал тааруугаас болж буй гэж тэмдэглэдэг. Учир нь ОХУ хүнд суртал ихтэй, өмч хөрөнгөө хамгаалах нөхцөл, хуулийн систем нь маш эрсдэлтэй ажээ. Нөгөөтэйгүүр, БНХАУ-ын төрийн зүгээс бизнесийн үйл ажиллагаан дахь оролцоо нь хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаанд хүндрэл учруулдаг гэдгийг Оросын шинжээчид тэмдэглэж[15] байна. Мөн ОХУ баруунтай үг хэлээ ололцох нь дээр бөгөөд глобалчлалын

[13] https://www.pravda.ru/economics/1419900-china/
[14] https://www.pravda.ru/economics/1419900-china/
[15] https://www.pravda.ru/news/economics/1394211-economics/По просьбе"Правды.Ру"



үр ашиг давуу эрхийг хэрхэвч алдаж болохгүйг[16] цохон тэмдэглэж байгаа юм.

Орос, Хятадын эдийн засгийн хамтын ажиллагааны боломжийн талаар ОХУ-ын Алс Дорнодын Институтын орлогч доктор А.Островский ярихдаа "Нэгдүгээрт, хоёр орны улс төрийн харилцаа хөгжсөн нь эдийн засгийн харилцааг хөгжүүлэхэд тус дөхөмтэй. Чингэхдээ Орос, Хятадын эдийн засгийн хэрэгцээг хангах хүчин чадалгүй байгаад гол учир шалтгаан оршино" гэжээ. 1995 онд манай хоёр орны эдийн засгийн хэмжээ багтаамж хүчин чадал ижил төстэй байсан. Гэтэл өнөөдөр Хятад үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээгээр Оросыг 8 дахин давж байна. Хятадын хэрэгцээ их, ялангуяа Оросын газрын тос, байгалийн хий, мод, загас, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг авах маш сонирхолтой байдаг. Гэтэл Хятадын зах зээл 1.4 тэрбум хүн бөгөөд Орос энэхүү зах зээлийг хангах боломжгүй юм. Чингэхдээ ОХУ БНХАУ-тай эдийн засгийн харилцааны боломжоо бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгааг дурдаад тухайлбал, өнөө ОХУ Хятадад зөвхөн нэг цөмийн цахилгаан (атомын) станц барьж байхад Америк, Франц нь Оросоос хэд дахин их цөмийн цахилгаан реакторыг барьж байгааг дурджээ. Мөн Орос-Хятадын худалдаа өөр орны валютаар гол төлөв ам.доллараар Америкийн банкуудыг дамжин гүйлгээ хийдэг. Энэ нь өөрийн эрхгүй (автоматаар) хоригт орох нөхцөлийг бүрдүүлдэг. Иймээс рубль, юаниар худалдаа хийх нь хоёр орны худалдааг хөгжүүлэх чухал хөшүүрэг[17] хэмээжээ.

Ийнхүү Орос, Хятадын эдийн засгийн харилцааны ерөнхий төлөвийг дүгнэснээс үзэхэд ерөнхий дүр зураг ийм байна. Нөгөөтэйгүүр геополитикийн ашиг сонирхол, өрсөлдөөний хүчин зүйл энэхүү харилцаанд хэвээр байгааг цохон тэмдэглэх хэрэгтэй. Өнөөгийн байдлаар ОХУ эдийн засгийн хувьд хүнд байдалд байгаа нь Хятад улстай харилцан ашигтай, энэ тэнцүү гараанаас бизнесийн орчин бий болгож чадахгүй нь хоёр орны харилцаа,

[16] Мөн тэнд
[17] https://www.pravda.ru/economics/1419900-china/

хамтын ажиллагааг хөгжүүлэхэд саад тотгор болж байгааг үгүйсгэж болохгүй. Энэ нөхцөлд эдгээр улсууд нь манай орны сонирхож буй том мега төсөлд хамтрах уу гэсэн асуудал зүй ёсоор тавигдаж байна. Гурвалсан харилцаа хөгжих ялангуяа маш том эдийн засгийн төслийн хүрээнд хөгжихөд бэрхшээл байгааг судлаачид онцлон тэмдэглэсээр байна. Үүнд юуны түрүүнд гурван улсын хөгжлийн түвшин өөр өөр гэдгийг судлаачид цохон тэмдэглэдэг бөгөөд эдийн засгийн хувьд хамгийн хөгжилтэй нь Хятад улс, Орос газрын тос, хий экспортлогч орон, тэндээс хангалттай хөрөнгө орж ирдэг учир өрсөлдөх чадвартай, харин Монгол Улсын эдийн засаг хүнд байдалд байгаа ба ОУВС-ийн хөтөлбөрт хамрагдсан зэргийг цохон тэмдэглэдэг. Нөгөөтэйгүүр, зах зээлийн чиглэл нь харилцан өөр өөр. ОХУ нь Өрнөдийн зах зээл рүү чиглэгдсэн ба Азийн бодлого нь тэр бүр тодорхой бус. Хятадын зах зээл хэдий өргөн хүрээнийх болovч гол төлөв зүүн тийш чиглэгдэж байгаа. Монгол Улсын хувьд Хятадын зах зээлээс хэт хамааралтай, зах зээлийн энэхүү энерцийг давахад хүндрэлтэй.

Гурвалсан эдийн засгийн коридор бий болоход саад учруулах бас нэг хүчин зүйл нь гурван улсын хөгжлийн стратеги нь ч зарчмын хувьд өөр. БНХАУ төлөвлөгөөт эдийн засагтай, ОХУ нь зах зээлийн эдийн засагтай болovч бүлэглэлийн сонирхол хүчтэй, Монгол Улс нь "Үндэсний хөгжлийн төлөвлөгөө", "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал" зэрэг бодлогын чанартай хөтөлбөрүүдтэй болovч засгийн эрхийг барьж буй намын эдийн засгийн хөтөлбөрийг гол төлөв мөрдлөг болгодог ба маш хүчтэй лоббийн зарчим үйлчилдэг зэрэг юм.

Гурвалсан харилцааны боломжуудыг харахад, гурван орны удирдлагын түвшинд тохиролцсон 32 төслийн ихэнх нь хэрэгжих боломжтой гэж харагддаг. Гэвч эдийн засгийн коридор зэрэг мега төслийн хувьд санхүү, эдийн засгийн боломж, зах зээлийн энерци нь давамгайлдаг. Үүнийг нотлох түүхэн баримт бол Хиагтын гурван улсын худалдааны зам. Тухайн үед Хятадын худалдааны картелиуд Алс Дорнод руу худалдаа хийх сонирхолгүй байсан учир Алс Дорнод





руу гарах замыг хааж байв. Оросын хаант улс үүнтэй тэмцэхийн тулд хүчээр Эрхүү хотноо Худалдааны төв байгуулж, Хиагтын худалдааны замыг хааж Алс Дорнодод худалдааны замыг хөгжүүлсэн байдаг. Харин өнөөдөр Монгол руу гарах гарцыг бодолцож байгаа болovч манай хоёр хөрш харилцан ашигтай, нэгэнт бүрэлдэн бий болсон эдийн засгийн коридорыг бэхжүүлэн хөгжүүлэх сонирхолтойг судлаачид онцолж байгаа бөгөөд хоёр хөршийн хамтын бодит харилцаанаас ч харагдаж байгаа болно.

ОХУ нь Сибирийг хөгжүүлэхэд санхүү, эдийн засгийн байдал хүнд байгаа өнөөгийн нөхцөлд[18] энэ бүс нутагт эдийн засгийн коридор байгуулахад тэр бүр бэлэн бус бололтой. Үүнтэй холбоотойгоор тус коридорын дамжин өнгөрөх, тус төсөлд оролцох Буриад, Тува зэрэг ОХУ-ын субъектуудын эдийн засгийн хөгжлийн түвшин доогуур, Оросын Холбоонд маш их өртэй, тэрхүү өр нь улам нэмэгдэж байгаа нь орон нутгийн чанартай хөгжлийн боломжийг боомилж байгааг судлаачид тэмдэглэж байна. Гэвч сүүлийн үед гурван улсын гурван талт харилцаа нэлээд идэвхжиж байгааг гурван талыг холбосон авто замыг байгуулах хамтарсан төсөл хэрэгжиж эхэлсэн, гурван улсын хооронд худалдаа эдийн засгийн чөлөөт худалдааны бүс байгуулах төсөл хэрэгжилтийнхээ эхний шатнаас гарах хандлага тодорч буй зэрэг нь хамтын ажиллагаа урагшлах найдлага, хүлээлтийг бий болгож байна.

Цаашид гурван улсын эдийн засгийн коридорын төсөл хэрэгжих боломж нээлттэй хэвээр байгаа бөгөөд ямартай ч улс төрийн хувьд гурван орны дээд хэмжээний түвшинд нэгэнт тохиролцсон нь цаашид биеллээ олох хүлээлт байгааг илтгэж байгааг дахин тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү төсөл бодит зүйл болж хараахан биелэгдээгүй болovч манай гурван улс энэ төслийн хэрэгжилтийн талаар ярьж төлөвлөж байгаа нь гурвалсан харилцаа, хамтын ажиллагаанд эерэг тал байгааг бодитойгоор харуулж байна. Үүнийг ч В.Путин 2019 онд болсон "Нэг бүс нэг зам" форумын үед хэлсэн үгэндээ:

[18] Розов И.С.Стратегия развития Сибири в контексте грядущего системного кризиса страны.- www.nsu.ru/fulf/ rozow

“Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны гишүүн орнууд Хятадын “Нэг бүс, нэг зам” төсөлд нэгдэхэд бэлэн байгаа учир нь энэхүү төсөл ОХУ-ын Евразийн хамтын ажиллагааны өргөн түншлэлийг бий болгох тухай үзэл санаатай ижил төстэй юм” гэж хэлснээс харж болох юм. Нөгөөтэйгүүр хятад судлаач А.Островскийн оновчтой хэлсэнээр энэхүү төсөл эдийн засгийн хувьд маш ашигтай гээд “Транссиб” гэхэд л Сибирийн хотуудын хувьд энэ бол зам харилцааны дэд бүтэц. Зам харилцаа хаана байна тэнд эдийн засгийн хөгжил байдаг. Зам харилцааны дэд бүтэц байхгүй бол зам ч байхгүй эдийн засаг ч байхгүй юм.”

Манай улсын хувьд гурвалсан харилцааны хамтын ажиллагааг эдийн засгаа хөгжүүлэх чухал гарц хэмээн харж байгаа ба Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Дорнын форум (2019) дээр Азийг хамарсан “Эрчим хүчний нэгдсэн супер сүлжээ” байгуулах санаачилга гаргасан нь үүний тод жишээ юм. Мөн манай улсын нутаг дэвсгэрээр хийн хоолой дамжин өнгөрүүлэх талаарх боломжийг судлах талаарх ОХУ-ын Ерөнхийлөгчийн өгсөн амлалт зэрэг нь гурван талт хамтын ажиллагаанаас хүлээх маш том хүлээлт юм.

Ийнхүү гурван улсын найрамдал, хамтын ажиллагааны уламжлал, ашиг сонирхол, газар зүйн байрлал, харилцан итгэлцэл нь тэдгээрийг нэг цэг дээр аваачих бодит нөхцөл бөгөөд манай хөрш гурван орны харилцааг гурвалсан хэлбэрээр хөгжих хөрсийг бий болгосоор байна.

Бид тус өгүүлэлдээ хүйтэн дайны дараа гурван улсын харилцаа хэдий аажим ч гэсэн хэрхэн урагшилж буйг харуулахыг зорив. Харин энэхүү гурван талт харилцаа, хамтын ажиллагаа нь бодитойгоор хэрэгжих нь маш олон зүйлээс хамаарах нь мэдээж бөгөөд юуны түрүүнд манай хоёр хөршийн ашиг сонирхол нийцэлд хүрэх шаардлагатай байгаагаас гадна манай гурван улсын эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжил, гадаад орчны таатай нөхцөл байдлаас ихээхэн хамаарах юм.